

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

## НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1-2
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3-30
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	31-105
<hr/>	
<i>1.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	33-46
<i>2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	46-58
<i>3.“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/</i>	58-59
<i>4.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт, тогтоолын төсөл</i>	59-80 84-85
<i>5.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	80-81
<i>6.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	81-82
<i>7.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	82-84
<i>8.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	85-90
<i>9.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн</i>	91-94

*мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

*10.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 94-95

*11.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 95

*12.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл* 95-96

*13.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл* 96-98

*14.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 98-105

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
05 дугаар сарын 02-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 52 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Н.Алтанхуяг, Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Бямбацогт, С.Ганбаатар, Н.Ганибал, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Б.Саранчимэг, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, Б.Чойжилсүрэн, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Д.Батлут, Г.Мөнхцэцэг, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд;

Тасалсан: Ж.Ганбаатар.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

***Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох, мөн газрын ахлах шинжээч Ц.Намчинсүрэн, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор Т.Намнан, мөн сургуулийн “Нано технологийн төв”-ийн захирал Ч.Ганзориг, Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ж.Батжаргал, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр нар хариулж, тайлбар хийв.

*Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Т.Аубакир, Э.Батшугар, Г.Дамдинням, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Ч.Ундрам, Н.Учрал, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3.“шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа” гэж хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн боловсрол олгох, шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	12
Бүгд:	39

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.6 дахь заалт нэмж, мөн зүйлийн 3.1.15 дахь заалтын “3.1.12-г” гэснийг “3.1.13-г” гэж өөрчлөх.

“3.1.6."грант" гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилсан нөхцөл, болзол тавьсны үндсэн дээр тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулах зориулалтаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	14
Бүгд:	39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “үндэсний” гэснийг “удирдлагын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.6.ж дэд заалтыг хасаж, төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “20 хүртэл” гэснийг “19” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 13  
Бүгд: 39  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “Ерөнхий сайдын захирамжаар” гэснийг “Засгийн газрын тогтоолоор” гэж, мөн төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “ажиллах үлгэрчилсэн дүрмийг Ерөнхий сайдын захирамжаар” гэснийг “үлгэрчилсэн дүрмийг Засгийн газрын тогтоолоор” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.6.үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, суурь болон хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлын чиглэл, санхүүжилтийг батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.5.шинжлэх ухаан, технологийн урьдчилсан таамаглалд шаардлагатай баримт материалыг энэ хуулийн 3.1.14-3.1.18-д заасан болон холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2 дахь хэсэг нэмэх:

“22.2.Засгийн газар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх бөгөөд уг асуудлыг Татварын хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн гарчгийг “Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг дэмжих” гэж өөрчилж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Засгийн газар төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлд санхүүжилтийн дэмжлэг олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын байгууллага, гадаад улсын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт хамтарсан эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, шинжлэх ухаан, технологийн хамтарсан төсөл хэрэгжүүлэх эрхтэй.

24.3.Монгол Улсын харьяат эрдэмтэн, судлаач, эрдэм шинжилгээний байгууллага нь гадаад улс, олон улсын байгууллага, шинжлэх ухааны нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “авьяаслаг судлаачдыг” гэснийг “авьяас, ур чадвартай судлаачийг” гэж, мөн зүйлийн 27.3 дахь хэсгийн “авьяаслаг эрдэмтэн, судлаачийг” гэснийг “авьяас, ур чадвартай, мэргэшсэн эрдэмтэн, судлаачийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.7 дахь хэсэг нэмэх:

“28.7.Эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиглэлээр дотоодод ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа эрдэм шинжилгээний ажилтанд сургалтын төлбөрийн 100 хүртэл хувийн дэмжлэгийг тухайн эрдэм шинжилгээний байгууллагаас үзүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 10  
Бүгд: 39  
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шинжлэх ухаан, технологийн төсөл, үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж, санхүүжүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “судлаачдын хамтлагт” гэснийг “судлаачид” гэж, 36 дугаар зүйлийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.” гэснийг “холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 12  
Бүгд: 39  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

### **“37 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

37.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

37.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.



Зөвшөөрсөн: 25  
 Татгалзсан: 14  
 Бүгд: 39  
 64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, “Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
 Татгалзсан: 13  
 Бүгд: 39  
 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**1.Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**31 дүгээр зүйл.**Дээд боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Шинжлэх ухаан” гэснийг “Үндэсний шинжлэх ухаан технологийн” гэж өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагч ажлын хэсэг дээрх саналыг татан авч байгаа тухай мэдэгдэж, санал хураалт явуулаагүй болно.

**2.Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
 Татгалзсан: 15  
 Бүгд: 39  
 61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын дэд сайд П.Баттөр, Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Г.Батхуяг, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Ц.Чулуунбат, Ая зохиогч, продюсер Д.Өлзий-Орших, “Эконтэ” ХХК-ийн захирал Э.Тамир, “М мюзик” ХХК-ийн захирал Д.Батмагнай, “Өмгөөллийн Төгс энд Ко” ХХК-ийн захирал Г.Төгсбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

*Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, А.Адьяасүрэн, П.Анужин, Т.Аубакир, Э.Батшугар, Г.Дамдинням, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “эрхлэх хувь” гэснийг “эрхэлж байгаа” гэж, 4.1.9 дэх заалтын “зэргийг кластержуулах замаар дэмжсэн,” гэснийг “зэргээр энэ хуулийн 4.1.8-д заасан кластер байгуулсан” гэж, “төвлөрлийн түвшин бусад бүс нутгаас өндөр байгаа” гэснийг “төвлөрсөн” гэж өөрчилж, 4.1.8 дахь заалтын “байршлын хувьд” гэсний дараа “болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	19
Татгалзсан:	20
Бүгд:	39

48.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	24
-------------	----

Татгалзсан: 15  
 Бүгд: 39  
 61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “эрхлэх хувь” гэснийг “эрхэлж байгаа” гэж, 4.1.9 дэх заалтын “зэргийг кластержуулах замаар дэмжсэн,” гэснийг “зэргээр энэ хуулийн 4.1.8-д заасан кластер байгуулсан” гэж, “төвлөрлийн түвшин бусад бүс нутгаас өндөр байгаа” гэснийг “төвлөрсөн” гэж өөрчилж, 4.1.8 дахь заалтын “байршлын хувьд” гэсний дараа “болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
 Татгалзсан: 14  
 Бүгд: 40  
 65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хөдөлмөр эрхлэлт,” гэснийг “6.1.3.” дахь заалт руу шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
 Татгалзсан: 13  
 Бүгд: 40  
 67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “түгээх үйл явцыг” гэснийг “түгээхтэй холбоотой үйл ажиллагааг” гэж, 7.4 дэх хэсгийг 7.5 дахь хэсэг болгон өөрчилж, 7.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 7.2-т заасан” гэснийг болон “7.5” дахь хэсгийг тус тус хасах гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
 Татгалзсан: 17  
 Бүгд: 40  
 57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “агуулгыг дэмжих” гэснийг “агуулгын дэмжлэг” гэж, 8.3 дахь хэсгийн “эзэмшүүлнэ” гэснийг “олгоно” гэж, 8.4 дэх хэсгийн “15-18 хүртэлх” гэснийг “16-18” гэж, 8.5 дахь хэсгийн “заасныг хэрэгжүүлж,” гэснийг “заасан үндэсний соёлын агуулгыг дэмжих болон” гэж, “хязгаарлалт тавих, шаардлага тавихтай холбоотой журам” гэснийг “хязгаарлалт тогтоохтой холбоотой журам” гэж өөрчилж, 8.3 дахь хэсгийн “энэ хуулийн 8.4-т заасан” гэснийг болон “8.2” дахь хэсгийг тус тус хасаж, 8.5 дахь хэсгийн “8.3” гэсний өмнө “8.1,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
 Татгалзсан: 16  
 Бүгд: 40  
 60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.3 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 9.8 дахь хэсгийн “Мэргэжлийн” гэсний дараа “болон техникийн” гэж нэмж, 9.4 дэх хэсгийн “мэргэшүүлэх, мэргэшсэн хүний

нөөцийг бүрдүүлэхэд” гэснийг “мэргэшүүлэхэд” гэж, 9.6.2 дахь заалтын “Боловсролын тухай хуульд” гэснийг “боловсролын хууль тогтоомжид” гэж, 9.6.3 дахь заалтын “шатны” гэснийг “түвшний” гэж, 9.6.4 дэх заалтын “чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа” гэснийг “чиглэлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа” гэж, 9.8 дахь хэсгийн “9.6-д” гэснийг “9.6.1, 9.6.4-т” гэж, “9.7-т” гэснийг “9.7.1, 9.7.2-т” гэж өөрчилж, 9.6.1 дэх заалтын “хөнгөлөлттэй” гэснийг болон “, холбогдох журмыг батлах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 13  
Бүгд: 40  
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн “10.3” дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 12  
Бүгд: 40  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “тэргүүн ээлжид” гэснийг, 11.1.3 дахь заалтын “үндэсний болон олон улсын” гэснийг хасаж, 11.1.5 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 11.3 дахь хэсгийн “11.2” гэснийг “10.1” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 13  
Бүгд: 39  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, цаашид тухай бүр нийцүүлэн өөрчилж, 12.4 дэх хэсгийн “дэмжлэг” гэсний өмнө “дэд бүтэц, систем нэвтрүүлэхэд” гэж, 12.6 дахь хэсгийн “удирдлагын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “систем хөгжүүлэлтийг” гэснийг “системийг” гэж, “хийх” гэснийг “хөгжүүлэх” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай “12.7” дахь хэсэг нэмэх:

“12.7.Энэ хуулийн 12.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллага нь Оюуны өмчийн тухай хуулийн 17.2-т заасан дагнан байгуулсан объектын төрлийн зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн олонхыг нэгтгэсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.3-12.6” гэснийг “12.3, 12.5, 12.6” гэж, “12.9 дэх хэсгийн “бүтээгдэхүүний зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн чиглэлээр” гэснийг “асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага

нь” гэж өөрчилж, мөн хэсгийн “төрөөс” гэснийг, 12.4 дэх хэсгийн “тодорхой” гэснийг болон 12.10 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “дэмжлэг” гэсний өмнө “болон бусад” гэж нэмж, 13.1.1 дэх заалтын “төсвийн дэмжлэг үзүүлэх” гэснийг “төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж, 13.1.4 дэх заалтын “гаргах” гэснийг “санхүүжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “14.1” гэсний дараа “, 14.5” гэж, 14.5 дахь хэсгийн “олон” гэсний дараа “улсын” гэж нэмж, 14.5 дахь хэсгийн “Холбогдох журмыг Засгийн газар батална.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “хамтын удирдлагын байгууллага,” гэсний дараа “эсхүл” гэж, 15.10 дахь хэсгийн “Соёлын” гэсний өмнө “холбогдох төрийн байгууллага” гэж нэмж, 15.2 дахь хэсгийн “төр, нийтийн” гэснийг “төрийн” гэж, “холбогдох бүртгэлийг” гэснийг “бүртгэл” гэж, 15.6 дахь хэсгийн “таатай үнээр” гэснийг “хөнгөлөлттэй үнэ” гэж, 15.10 дахь хэсгийн “авах” гэснийг “өгөх” гэж өөрчилж, 15.8 дахь хэсгийн “, хөтөлбөрийг” гэснийг болон “15.9” дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16.1 дэх хэсгийн “боловсруулан,” гэснийг, 16.4 дэх хэсгийн “Төрөөс” гэснийг хасаж, 16.3 дахь хэсгийн “Төр өөрийн мэдэлд байгаа” гэснийг “Төрийн эзэмшлийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “кластерын” гэсний ард “төлөвлөлт, эсхүл” гэж нэмж, 17.6 дахь хэсгийн “олгохдоо” гэснийг “хүссэн этгээд нь” гэж, 17.8 дахь хэсгийн “төвлөрлийн түвшинг” гэснийг “төвлөрлийг” гэж өөрчилж, 17.8 дахь хэсгийн “менежмент хийх мэргэжлийн багийн

зардлыг” гэснийг болон 17.9 дэх хэсгийг тус тус хасаж, 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк, цогцолбор байгуулах саналыг техник, эдийн засгийн үндэслэлийн хамт Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “болон” гэснийг “, эсхүл” гэж, “мэдээлэлд үндэслэн бүртгэх,” гэснийг “болон шаардлагатай бусад мэдээлэл, журамд үндэслэн бүртгэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын “үндсэн” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай “20.2.7” дахь заалт нэмэх:

“20.2.7.оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.8 дахь заалтын “чадавхыг” гэснийг “мэдлэгийг” гэж өөрчилж, 21.1.9 дэх заалтын “улс орны хөгжлийн онцлогт нийцүүлэн” гэснийг, 21.1.10 дахь заалтын “менежмент хийх” гэснийг болон “21.1.11” дэх заалтыг тус тус хасаж, “21.1.2” дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.2.энэ хуульд заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалтын “холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах” гэснийг “холбогдох хуулийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “үйлдвэрлэлийн” гэснийг “үйлдвэрлэлийг дэмжих” гэж өөрчилж, 24.1.3. дахь заалтын “соёлын” гэснийг өмнө “энэ хуулийн 4.1-д заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “эдийн” гэснийг дараа “засгийн” гэж нэмж, “хөтөлбөр, төсөв” гэснийг “төлөвлөгөө” гэж, 25.1.3 дахь заалтын “ашиглуулах” гэснийг “эзэмшүүлэх” гэж өөрчилж, 25.1.1 дэх заалтын “талаарх” гэснийг болон 25.1.4 дэх заалтын “нутаг дэвсгэрт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “эдийн” гэснийг дараа “засгийн” гэж нэмж, “талаарх” гэснийг болон “, төсөв” гэснийг тус тус хасах, 26.1.2 дахь заалтын “нутаг дэвсгэрийн” гэснийг “орон нутгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын “үйлдвэрлэлийн” гэснийг “үйлдвэрлэлийг дэмжих” гэж өөрчилж, 27.1.3. дахь заалтын “соёлын” гэснийг өмнө “энэ хуулийн 4.1-д заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн Гарчгийн “үйл ажиллагаан дахь тайлагнал,” гэснийг “үйл ажиллагааны” гэж, 28.4 дэх хэсгийн “авсан” гэснийг

“олгосон” гэж өөрчилж, 28.3 дахь хэсгийн “мэдээллийн” гэсний өмнө “бүртгэл,” гэж нэмж, “энэ хууль болон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39  
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### Хоёр.Найруулгын санал

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эдгээртэй” гэснийг “эдгээр хуультай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “арга хэмжээ, журмыг” гэснийг “арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг” гэж, 9.6.1 дэх заалтын “чиглэлийн” гэснийг “чиглэлээр” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтын “хөрөнгө оруулалтад” гэснийг “хөрөнгө оруулалт” гэж, 12.2 дахь хэсгийн “бүртгэгдсэн бүтээл” гэснийг “бүтээлийг” гэж, 12.8 дахь хэсгийн “этгээд” гэснийг “этгээдэд” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “эдлүүлнэ” гэснийг “үзүүлнэ” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “хориглоогүй буюу” гэснийг “хориглоогүй,” гэж, 15.4 дэх хэсгийн “загварыг” гэснийг “загвараар” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “хүн ам” гэснийг “иргэдэд” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “, зэрэг арга хэмжээнд” гэснийг “бусад үйл ажиллагаанд” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “гадна” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болон” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалтын “системтэйгээр” гэснийг хасаж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Засгийн” гэсний дараа “газрын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*



***1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:***

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “системийг ашиглах” гэснийг “системийн” гэж өөрчилж, “системийн хөгжүүлэлт хийх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 13  
Бүгд: 39  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

***2.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар” гэснийг “3, 18 дугаар” гэж өөрчилж, “хэсэг” гэсний дараа “, заалт” гэж нэмж, доор дурдсан агуулгатай “18.6” дахь хэсэг нэмэх:

“18.6.Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 13  
Бүгд: 39  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 15  
Бүгд: 39  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “чиглэл” гэсний өмнө “тодорхой” гэж,” гэснийг хасаж, “33 дугаар зүйлийн” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн “Шилдэг бүтээл” гэснийг “Шилдэг уран бүтээлч болон шилдэг бүтээл” гэж” нэмж, мөн зүйлийн “50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийн “дурсгал” гэснийг, “түүх соёлын дурсгалт зүйлээр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14  
 Бүгд: 39  
 64.1 хувийн саналаар дэмжигдлээ

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “Соёлын тухай хуулийн” гэсний дараа “9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтын “уран сайхны” гэснийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
 Татгалзсан: 13  
 Бүгд: 39  
 66.7 хувийн саналаар дэмжигдлээ

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлд “26 дугаар зүйлийн 26.3,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
 Татгалзсан: 15  
 Бүгд: 39  
 61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**3.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “хассугай” гэсний өмнө “тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
 Татгалзсан: 13  
 Бүгд: 39  
 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “15.1.15” гэснийг “15.1.16” гэж өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

15.1.16.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор албан татвар ногдох орлогын 5 хувиас хэтрэхгүйгээр өгсөн хандив гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24  
 Татгалзсан: 15

Бүгд: 39  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

***5.Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “нүүр” гэсний дараа “болон” гэж нэмж, “талд үндэсний агуулга, хэлбэр, дүр төрхийг илэрхийлсэн үзэл баримтлал,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 12  
Бүгд: 39  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

***Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “22.5.11, 22.5.12” гэснийг “22.5.20” гэж өөрчилж, “хөнгөлнө” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан үг хэлэв.

***6.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 болон 2 дугаар зүйлийн “16.1.17” гэснийг “16.1.19” гэж, 2 дугаар зүйлийн “заалтын” гэснийг “хэсгийн” гэж, “16.1.16” гэснийг “16.1.18” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 15  
Бүгд: 39  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

***7.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 болон 2 дугаар зүйлийн “38.1.21” гэснийг “38.1.23” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 15  
Бүгд: 39  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**8.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Соёл, урлагийг дэмжих сан” гэснийг “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан” гэж өөрчилж, 13.3.5 дахь заалтын “арга хэмжээнд оролцуулах,” гэснийг, 13.3.7 дахь заалтын “онцгой” гэснийг, “13.4” дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

**9.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9.14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмэх:

“3.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох, хянах, хэрэглэгчийн статистик мэдээлэлд үндэслэн хязгаарлалт тогтоохтой холбоотой журмыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 13  
Бүгд: 39  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 9.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*10.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаар:*

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.10 дугаар зүйлийн” гэснийг “1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.46 дахь заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 15  
Бүгд: 39  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*11.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:*

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “үүсвэрээс” гэсний дараа “болон гадаадын киног Монгол Улсад гаргасны ашгийн 2 хувиас” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*12.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:*

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16  
 Бүгд: 39  
 59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**13.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “, өөрчлөлт” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**2 дугаар зүйл.**Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2 дахь хэсгийн “34.27” гэсний дараа “, 34.28” гэж нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
 Татгалзсан: 14  
 Бүгд: 39  
 64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**14.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
 Татгалзсан: 13  
 Бүгд: 39  
 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**15.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмж, төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйл болгон өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**1 дүгээр зүйл.**Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалтын “аргачлалыг” гэсний дараа “соёлын болон” гэж нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 27  
 Татгалзсан: 12  
 Бүгд: 39  
 69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*11. Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:*

**Нэг. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г. Занданшатар:** 2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “байгууллагатай” гэсний өмнө “төв” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
 Татгалзсан: 17  
 Бүгд: 39  
 56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М. Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б. Болдбаатар нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г. Занданшатар:** “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
 Татгалзсан: 16  
 Бүгд: 39  
 59.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт, тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын явцын тайланг Түр хорооны дарга Ж.Чинбүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Г.Тэмүүлэн, Д.Сарангэрэл нарын тавьсан асуултад Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн, мөн хорооны гишүүн Ц.Сандаг-Очир нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 13 цаг 23 минутаас хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

*Чуулганы нэгдсэн хуралдаан 13 цаг 59 минутад түр завсарлаж, 14 цаг 30 минутад эхлэв.*

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 14 цаг 30 минутаас хуралдааныг даргалав.*

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг түр хойшлуулав./14.32/*

***Тав.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.



Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Н.Энхболд:** 1.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 19  
Бүгд: 39  
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.*

**Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт, тогтоолын төсөл /үргэлжлэл/**

**Г.Занданшатар:** Хянан шалгах түр хорооны саналаар, “Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39  
53.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.8-д заасны дагуу Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хороог татан буугдсанд тооцов.

*Уг асуудлыг 14 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

**Найм.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	17
Бүгд:	38

55.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.*

***Ес.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38

57.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.*

*Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаан хойшилсон тул хэлэлцэхийг түр хойшлуулав. /15:28/*

*Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаан хойшилсон тул хэлэлцэхийг түр хойшлуулав. /15:28/*

*Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хууль санаачлагч байхгүй байгааг мэдэгдэж, хэлэлцэхийг түр хойшлуулав. /15:29/*

***Арав.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван нэг.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын

Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван хоёр. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван гурав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39  
53.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

*Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Анужин Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлэх горимын санал гаргав.*

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн П.Анужины гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэхээр тогтов. /15:40/

*Арван дөрөв.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мөн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхсайхан, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 14 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 4 цаг 40 минут үргэлжилж, 72 гишүүнээс 43 гишүүн хүрэлцэн ирж, 59.8 хувийн ирцтэйгээр 16 цаг 03 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 02-ны  
өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 52 минут

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданишатар:** Өглөөний амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна.

Нэгдүгээрт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, зарчмын зөрүүтэй 18 саналтай.

Хоёрт нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Гуравт, “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Дөрөвт, Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт, тогтоолын төсөл.

Тавдугаарт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Зургаадугаарт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн төслүүд.

Долоодугаарт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Найм.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Ес.Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Аравт, Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Арван нэгд, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Арван хоёр.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Арван гурав.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл.

Арван дөрөв.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг.

Арван тав. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Арван зургаа. “Засгийн газарт чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.



Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьшаа үг хэлэх хүсэлтийг 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлсэн байна. Ингээд Ширнэнбандийн Адьшаа гишүүн үг хэлнэ.

Ашигт малтмалын тухай хууль Байнгын хороон дээр л хэлэлцэх ёстой юм байгаа юм.

**Ш.Адьшаа:** Их Хурлын гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд энэ хэлэлцэж байгаа хуулиудын асуудалтай холбогдуулж Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг миний бие 2023 оны 12 сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Өнөөдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуулиуд өнөөдөр Улсын Их Хурлаар хэлэлцэгдээд зарим нь батлагдаад явж байна. Сөрөг хүчний гишүүний хуулийг энэ оруулж ирэх асуудлыг та бүгд яагаад анхаарч өгөхгүй байна? Би Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль дээр өнөөдөр энэ уул уурхайн засаглалын тухай, хариуцлагагүй уул уурхайн тухай, уул уурхай, уугуул иргэдийн асуудал, орон нутгийн өөрөө удирдах байгууллага энэ уул уурхайн лиценз, худалдан борлуулах, газрын баялгаа зарахад тэдний оролцоог хууль, эрх зүйн хувьд өнөөдөр шинэчилж, тогтолцооны өөрчлөлт хийх ийм зайлиггүй шаардлага байгаа учраас энэ хуулийн төсөл өргөн мэдүүлсэн.

Энэ хуулийн төсөл бол өнөөдөр хөдөө орон нутагт байгаа тэр уул уурхайн золиос болж байгаа уугуул иргэдийн асуудлыг энд хуулийн зохицуулалтаар шийдэх шаардлагатай байгаа. Өнөөдөр хөдөө орон нутагт уур уурхай ухааж төнхдөг асуудал газар авч бүүр үндэсний аюулгүй байдлын

хэмжээний асуудал болсон тухай иргэд олон түмэн үнэхээр нулимс дуслуулж, гомдол мэдүүлж байна. Тэр Завхан аймгийн Ургамал сумын Тосгуур багийн иргэн Пүрэвжавын Хоролмаа, Аюушийн Пүрэвсүрэн гээд хоёр иргэн үнэхээр уйлж байсан. Бид нар өнөөдөр энэ алтны, газар ухсаны золиос болж байна. Бид нарын мал бэлчээх газар, малын хашаа бүгдийг нь ухсан, бүгдийг нь төнхсөн.

Гэтэл энэ асуудлыг хэн ч өнөөдөр ярьж, хэлж шийдэхгүй байна. Орон нутгийн удирдлага нь ч энэ уул уурхайтай хуйвалдсан, төр нь ч хуйвалдсан, Засгийн газар нь ч хуйвалдсан байна. Бид одоо яах юм бэ гэж ингэж уйлж байна энэ хүмүүс чинь. Гэтэл өнөөдөр тэр уул уурхайн асуудал, түүний дотор уугуул иргэдийн асуудал, энэ уул уурхайн баялгийг зарж худалдахад орон нутгийн өөрөө удирдах байгууллагын асуудлыг энэ хуулиар зохицуулах ийм шийдлийг гаргахыг зорьсон юм. Энэ хуулийн төслийг энэ Улсын Их Хурлын хэлэлцэх Ашигт малтмалын тухай хуулийн төсөлтэй хамтарч хэлэлцүүлж өгөх саналыг оруулж байна. Оруулж байна. Энэ бол өнөөдөр энэ уул уурхайн засаглал, хариуцлагатай уур уурхай, газрын баялаг, Монголын ард түмний өмч байх энэ Үндсэн хуулийн зарчимд чинь тулгуурласан ийм хуулийн зохицуулалт байгаа.

Өнөөдөр энэ асуудлыг шийдэж байж, уул уурхайн золиос болсон нутгийн иргэд, хөдөөгийн малчид эд нарын энэ асуудлыг шийдье Монголын төр. Энэ асуудлыг зохицуулъя. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдлийг тодорхой хэмжээнд уул уурхайн энэ ашиглалт, олборлолт, худалдан авалтын асуудал дээр зохицуулж өгье гэсэн ийм зарчмыг энэ хуулийн төсөлд тусгасан юм. Өнөөдөр энэ асуудлыг та бүхэн энэ хэлэлцэх асуудалд яаралтай оруулж, хамтарч хэлэлцүүлэх асуудлыг шийдье гэсэн ийм бодолтой байна.

Өнөөдөр байгалийн баялагт эзэн байх, газрын хэвлийн баялгаас одоо байгаа Монгол Улсын иргэн, ирээдүйд байх Монгол Улсын иргэн хувь хүртэнэ гэсэн энэ Үндсэн хуулийн зарчим чинь өнөөдөр цаасан дээр тунхаг шинж чанартай байгаа. Өнөөдөр энэ 30 жилийн уул уурхайн энэ золиос, энэний асуудал өнөөдөр хөдөөгийн ард иргэд, малчид болоод байна. Малчид болоод байна. Гэтэл энийг мэдээлэлд ойрхон байдаг.

**Г.Занданшатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн үг хэллээ. Одоо бид нар бас 4 жил Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиа сайн судалж сурмаар байгаад байна. Байнгын хороон дээрээ хэлэлцүүлээд л Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлнэ шүү дээ. Хэлэлцэх асуудлын дэгт намуудын бүлгүүдийн дарга нар байдаг. Тэгээд нам, бүлгийн даргаараа дамжуулаад Их Хурлын дэд дарга нараараа байдаг юм уу энэ саналаа Даргын дэргэдэх зөвлөл дээр оруулаад хэлэлцүүлэхгүй. Тэгээд л гэнэт санасан юм шиг ингээд л яриад байж болохгүй.

**Одоо Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга харууцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн

тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Их Хурлын даргын 2024 оны 60 дугаар захирамжаар төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Аубакир, Батишугар, Дамдинням, Жаргалмаа, Мөнхцэцэг, Мөнхцэцэг, Одонтүяа, Ундрал, Учрал, Чинбүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсан бөгөөд ажлын хэсгээс хуулийн төслийн талаарх гаргасан саналаа Байнгын хорооны хуралд танилцуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Шинжлэх ухаан, технологийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэн, дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Нэгдүгээрт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг хүний амьдралын чанар, нийгэм, эдийн засгийн болон шинжлэх ухаан, технологийн хөгжил, үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн байхаар тодорхойлох.

Хоёрдугаарт нь шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, бүс нутагт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхой болгох.

Гуравдугаарт нь шинжлэх ухаан технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагуудын судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хууль тогтоомжийг заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх.

Дөрөвдүгээрт нь шинжлэх ухаан технологийн хүний нөөцийг бэлтгэх, шинжлэх ухааны авьяастныг нээх, эрдэм шинжилгээний ажилтан, түүний нийгмийн баталгааг хангах.

Тавдугаарт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийг хөгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн журам, захиалагч, гүйцэтгэгчийн эрх, үүргийг зохицуулах талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллын бэлтгэлээ.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж, Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гараагүй болно.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг

явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын 18 санал байгаа. Ажлын хэсгийн гишүүд энд орж ирчихсэн байна.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Ханджавын Батжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Доржготовын Баттогтох Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновац хөгжүүлэлт хэрэгжилтийн зохицуулалтын газрын дарга, Дүгэрийн Рэгдэл Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, Цэеэн-Ойдовын Намчинсүрэн Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновац хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Төмөрнүрэвийн Намнан Шинжлэх ухааны их сургуулийн ректор, Содномдаржаагийн Мөнхбат Шинжлэх ухаан технологийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Доржгочоогийн Одгэрэл Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал, Чимэдийн Ганзориг Монгол улсын их сургуулийн “Нано технологийн төв”-ийн захирал.

Тэрийг тухайн заалтдаа асуу. Дашдондогийн Ганбат гишүүнээр тасалсан. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асуу. Дашдондогийн Ганбат, Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Тэгээд

Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

**Д.Ганбат:** Та бүхнийхээ өглөөний амар амгаланг айлтгая. Энэ соёлын тухай, шинжлэх ухааны тухай хууль аягүй чухал. Энэ санхүүжихдээ Боловсролын яамаар дамжиж санхүүжиж байна уу, Соёлын яамаар дамжиж санхүүжиж байна уу? Боловсрол уу, Шинжлэх ухаан, технологийн хууль? Бид бүхэн их хоцрогдож байна. Энэ дэлхий дээр хиймэл оюун ухаан ИЕ энэ тэр гээд энэ зүйлүүд ороод ирчихсэн байна. Супер компьютерүүд орж ирж байна. Тэгтэл бид нар нөгөө л бүжиглээд л, дуулаад л хэдэн өвөр монголчууд шиг л байна шүү дээ. Айн? Энэ мөнгө төгрөгөө хаана, яаж тавих юм бэ? Энэ Шинжлэх ухаан, технологийн хуулийг баталснаараа юу юу өөрчлөгдөж, юу юу сайжрах юм? Би өмнө нь хэлж л байсан тэр байгалийн шинжлэх ухаан байхгүй болчихоод байна шүү гэж. Өнөөдөр манай багш нарын бага анги, цэцэрлэгийн багш нар эндээс л эхлэлтэй шүү дээ. Хүн яаж боловсрол эзэмшиж байна, манайх чинь эрхэм баян эрдэм ном гэдэг ийм л ард түмэн л дээ. Энд л мөнгө төгрөг хүүхдэдээ зарцуулж байдаг ийм сайхан уламжлалтай.

Гэтэл энэ бага ангийн багш нарын цалин, тэр тусмаа физикийн, химийн, математикийн багш нарын цалин ямар байна вэ? Ийм мэргэжлүүдээ бэлдэхгүйгээр энэ багш нараа сайжруулахгүйгээр цалинг нь сайн болгохгүйгээр явахгүй.

Нөгөө талаар одоо автобусны жолооч нарын цалин, энэ гадаа цэвэрлэгээ хийж байгаа нийтийн ахуй үйлчилгээний ажилтны цалин одоо ТҮК билүү 3 сая, 3 сая 500 болж байгаа гэсэн. Тэр маш сайн байна. Үүнтэй ингээд харьцуулаад үзэхээр энэ математикийн багш, тооны багш нар, физик, химийн багш нар, биологийн багш нарын цалин 5 саяас доошгүй байх ёстой. Ийм өөрчлөлт хийж байж Шинжлэх ухаан,

технологийнхоо хуулийг өндөр түвшинд ч гаргана уу гэхээс биш энэ талаар энэ хуульд заасан юм байна уу? Бид нар чинь дундаж хүүхдүүд нь дэлхийгээс болоод 5, 6 жилээр хоцорчихсон байна шүү дээ. Ийм нөхцөл байдалтай байна. Хуучин хэдийгээр сайн, муу хэлэгдээд байдаг тэр социализмын үед бид нар боловсролоор сайн байсан. Тэрний хүчинд ч гэсэн зах зээлийг амжилттай даван туулсан гэж ойлгож байгаа. Сүүлийн 30 жилд энэ үнэхээр хүнд болсон. Тэр байтугай уншиж, бичиж чаддаггүй хүүхдүүд байна л гэсэн шүү дээ 8, 9 дүгээр ангид. Манай Цогтгэрэл гишүүн хэлж л байсан шүү дээ. Хаана байдаг юм, хэн мэдэх вэ. Тэрийгээ хаана байдгаа ч мэдэхгүй болчихсон байна шүү дээ та нар чинь. Угаасаа энэ гадна, дотно юм бичиж байгаа хэлбэр байдлыг нь хараад байхад ойлгомжтой л байгаа шүү дээ. Тэгээд байгаа үнэхээр муу юмнуудаа хэлж, ярьж чадахгүй байж байж бид нар их бүх юм болж байгаа, бүтэж байгаа, сайн сайхан байгаа юм шиг мөнгө тавиад л байдаг, мөнгө тавиад л байдаг тэр нь яг оновчтой байдаг юм уу, үгүй юм уу? Энэ дээр та нөхдүүд ямар бодолтой байна вэ?

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Баагаагийн Баттөмөр гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

**Б.Баттөмөр:** Шинжлэх ухаан технологийн хуулийг хэлэлцэж байна. Энэ хуулийг анх 1996 онд анхны хуулийг батлаад 2008 онд өөрчлөлт хийгээд 2008 оноос хойш 8 удаа өөрчлөлт хийсэн байгаа. Энэ өөрчлөлтүүдийг хийсний үндсэн дээр ер нь шинэчлэх ийм шаардлага үүссэн юм. Үүнийг би анх 4 жилийн өмнө өргөн бариад тэгээд хэлэлцэгдэхгүй явсаар байгаад хамгийн сүүлд бол Засгийн газраас өргөн бариулах нь зүйтэй гээд Засгийн газар үүнийг өргөн бариад хэлэлцүүлчхэж байгаа юм.

Ганбат гишүүний хувьд цалин хөлстэй холбоотой асуудлыг тавьж байна. Ер нь энэ шинжлэх ухаан

технологийн хөгжүүлэх бол ДНБ-ийг өсгөнө, бүтээмж өснө. Хүний хөдөлмөрийн үнэлэмжийг өсгөх ёстой шинжлэх ухаан технологийн тусламжтайгаар энэ. Өнөөдөр Монгол Улсын 24 оны байдлаар ДНБ 74 их наяд төгрөг байгаа. Үүний үр дүн хүмүүсийн цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмсэн. Сая 4 сарын 1-нээс эхлээд тэтгэврийг нэмээд, 100 мянган төгрөгөөр нэмээд, цалинг бас 10 хувиар нэмчихсэн явж байгаа. Тэгэхээр шинжлэх ухаан технологийн энэ хөгжлийг л бид сайн болгох юм бол өсөлтийн нэг хэлбэр болно. Үнэхээр монголчуудын цалин бага байгаа. Тэр бол нэмэгдүүлэх шаардлагатай. Нэмэгдүүлэхийн тулд энэ Шинжлэх ухаан, технологийн хуулийг л оруулж ирж, нэг хөшүүрэг нь болно.

Ер нь гол хөшүүрэг цалин нэмэхэд хаана байна гэхээр баялаг дээрээ менежмент хийх хэрэгтэй. Мөн эдийн засгаа тэлэх хэрэгтэй. Бүтээмжээ нэмэгдүүлэх, энэ олон хүчин зүйлийн үндсэн дээр Монгол Улсын эдийн засаг тэлж байж, төсөв тодорхой хэмжээний мөнгөтэй болж байж, хувийн хэвшилээ дэмжиж тэдний шаардлагад нийцсэн тэр урт хугацаатай, бага хүүтэй зээл олгох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдаж авах мэтээр их цогц арга хэмжээнүүдийг авсны үндсэн дээр Монгол Улсын эдийн засаг тэлэх юм. Үүний үндсэн дээр ард иргэдийн цалин хөлсний хэмжээ бол нэмэгдэх юм. Энэ тодорхой үе шаттайгаар ингээд цаашаа явна. Энэ шинжлэх ухаан технологийн хууль бол энэ зорилгын хүрээнд л ингэж шинэчилж найруулагдсан гэж ойлгож болох юм гэж хариулт өгье.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

**Д.Ганбат:** Ер нь хамгийн суурь юм одоо анхан шатаас явна. Тэр тусмаа математикаас, химис, физикээс биологиос шалтгаална. Дунд сургуулийн лабораториуд ямар байгаа вэ? Хими, физик, математикийн багш нар бүрэн

хангалттай байгаа юу? Шаардлага хангаж байгаа юу? Ер нь өнөөдрийн эрдэмтний цалин ямар байна вэ гарынх нь цалин? Тэрийг мэдмээр байх юм. Энэ хууль батлагдсанаар тэр эрдэмтэн ямар цалинтай болоод, ямар бүтээмжтэй болох юм бэ? Энэ Баттөмөр гишүүн бүтээмжийн асуудал ярьж байна энэ маш сайн.

**Г.Занданшатар:** Санал хэллээ тийм ээ. Цалинг нь, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд хариулна.

**Л.Энх-Амгалан:** Ганбат гишүүнийг бас энэ шинжлэх ухааны чиглэлээр суурийг бэлдэх, хүүхдийг шинжлэх ухаанчаар багаас нь бэлдэх энэ санаа, зовнилыг бол би их хүндэтгэж хүлээж авч байна.

Ер нь бид нар энэ одоогийн энэ манай Ардчилсан намынхан болохоор юу яриад байгаа юм. Энэ хөтөлбөрийн нэг чанарын асуудал л яриад байгаа юм л даа. Энэ хөтөлбөр чинь өөрөө цөм хөтөлбөр гээд 2012-оос, 12 онд л эхэлсэн хөтөлбөр дээр л саяын PISA-гийн үнэлгээ хийгдсэн шүү дээ Ганбат гишүүнээ. 2012 оноос эхэлсэн цөм хөтөлбөр дээр тэгээд гарч байгаа үр дүн нь ийм юм байгаа юм.

Тэгээд бид нар хүссэн, хүсээгүй энэ хөтөлбөрийн шинэчлэл хийгээд хүүхдийг 1 дүгээр ангиас нь КОДИНГ-ийн хичээл 3 дугаар ангиас нь Англи хэл заах гэх мэтчилэнгээр сая боловсролын багц бүр дээр нэлээн томоохон шинэчлэлүүд эхлүүлсэн Ганбат гишүүнээ та мэдэж байгаа.

Физик, математикийн багш нар бол тийм хомсдолд орчихсон юм байхгүй. Ер нь улсын хэмжээнд жил бүхэн 2-оос 2300.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Одоо Жигжидийн Батжаргал гишүүн баярлалаа.

**Ж.Батжаргал:** Шинжлэх ухаан, технологийнхоо салбарын талаар эрх зүйн орчныг нь шинэчлэх талаар асуудалд хандаж байгаа явдалд туйлын баяртай байна. Бид одоо ер нь энэ хөгжлийн загвар төлөвлөлт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, технологийнхоо чиглэл дээр энэ шинжлэх ухааны байгууллагуудаа жоохон түшиж ажиллахгүйгээр явах боломж үнэхээрийн хомс байгаа. Тийм учраас би 2, 3 асуулт байгаад байна гэж.

Энэ шинжлэх ухааны байгууллагуудын чинь санхүүжилт нь ер нь ямархуу байдлаар шийдэгдэхээр энэ хуульд тусгагдав нэг? Сангийн хэлбэрээр явах гээд байна уу? Энэ олон салбар барьчихсан мэргэжлийн яамнууд чинь захиалгат судалгааны өөрийн зардал байх юм уу, байхгүй юм уу? Ерөөсөө өнөөдөр амьдралаас салчхаад байгаа юм чинь захиалгат судалгааны ажил байхгүй, тэрийг дагаад тэр салбарын технологи хөгжүүлэлт, бүтээгдэхүүн, хөгжүүлэлт байхгүй. Үүнээс болоод бидний чинь бүтээмж явахгүй байгаад байгаа шүү дээ. Тэгээд энэ талаар ямархуу асуудлыг хөндөв гэдэг зүйл байна.

Дараагийн нэг зүйл хувийн хэвилийн байгууллагууд энэ шинжлэх ухааны байгууллагуудтай чинь яаж хамтарч ажиллах юм бэ? Өөрийнхөө салбарын хөгжлийг гэдэг юм уу, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийнхээ талаар ямархуу байдлаар энэ шинжлэх ухааны байгууллагуудтай хамтарч ажиллаж, хөгжүүлэлтийн юмнуудыг хийж түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх юм? Энэ талаар ер нь ямар асуудал тусаад орчхов гэдэг асуудал байна.

Гурав дахь зүйл. Бид хэд ер нь юм хийнэ гэхээрээ дандаа бүтэц санхүүжүүлэх гээд байдаг улсууд. Гэхдээ шинжлэх ухааны гэдэг юм уу, судалгааны чиглэлийн олон байгууллагууд байна. Наад захынх нь зардлыг санхүүжүүлэх хэмжээний хөрөнгө мөнгө нь тусаж

өгдөггүй тэгээд нэг тийм дундуурхан бүтэцтэй байгууллага л яваад байгаа. Үр дун, өгөөж муутай. Нэгдүгээрт бүтцийнх нь хувьд, боловсон хүчнийх нь хувьд яаж эднүүсийгээ жоохон чадамжуулах юм.

Хоёрдугаарт, тэр судалгааны ажлынх нь асуудлыг ер нь ямархуу байдлаар дэмжих юм? Тэрийг нь яаж үйлдвэрлэлд нэвтрүүлэх юм л гэдэг асуудал байгаад байгаа шүү дээ. Жишээ нь, тэр Дарханы Ургамал газар тариалангийн хүрээлэн гээд том хүрээлэн байна. Энэ газар тариалангийн бүтээгдэхүүний анхдагч үр үржүүлгийн асуудал тэнд эрэл явагдах ёстой. Тэр байхгүй. Дараагийн залгаад хийгдэх ёстой асуудал нь сорт сорилын төвүүд бүсчилж байгуулагдах ёстой. Тэгж байж энэ газар тариалангийн салбар чинь үрийн хангамж нь яг зохих ёсоороо хангагдаж явах бололцоо нь бүрдэнэ. Энэ чиглэлийн яг энэ шиг энэ шинжлэх ухаан, технологийн байгууллагууд чинь ер нь яаж ажиллахаар энэ хуульд тов тодорхой тусаж оров? Энэ талаар тодорхой мэдээлэл авъя.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн, ажлын хэсгийн ахлагч.

**Б.Баттөмөр:** Батжаргал гишүүний хувьд чухал асуудлууд тавьж байна. Энэ ер нь тэр сая Дарханы 144 гээд тэр өрийн асуудал байгаа юм л даа. 6 жилийн хугацаанд 61 тийм 61.8 тэрбум төгрөгийн цэвэр тийм үр ашгийг эдийн засагт үзүүлсэн. Монгол улсад энэ элэг шилжүүлэн суулгах технологи нутагшсан. Үүнийг нутагишуулсан хүмүүсийн нэг нь манай энэ танхимд сууж байна. Чинбүрэн эмч байна. Энэ бол маш олон хүний амийг аварсан, маш их олон тэрбум төгрөгийн зардлыг хэмнэсэн, цаашаа үе мөчийг орлуулах гэх мэтийн маш их олон ийм зүйлүүд гарч ирж байгаа юм.

Хамгийн гол нь бол бид нар юу гэхээр энэ Монгол улсад бий болсон судалгааны энэ хөгжүүлэлтийн асуудлаа цаашаагаа хөгжүүлэх үйлдвэрлэлд нэвтрүүлэх энэ асуудал их учир дутагдалтай байгаа юм. Тэгээд энэ хуулийн тэр 22 дугаар зүйлд хувийн хэвшлийн судалгаа, хөгжүүлэлт, технологийг дэмжих гэж байгаа юм. Энэ дээр хувийн хэвشلүүд тодорхой хэмжээний судалгаа хөгжүүлэлтийг хийгээд тэгээд тэрийг нь бол төрд бас авдаг, хамтарч ажилладаг, энэ дээрээ бол худалдаж авч болдог.

Дээрээс нь татварын хөнгөлөлтийг Татварын хуулийн дагуу үзүүлдэг ийм эрх зүйн орчнуудыг бүрдүүлж өгч байгаа юм. Энэ хуулийн бас гол асуудал бол юу гэхээр ерөөсөө төр дангаараа хийхээс гадна хувийн хэвшилтэйгээ хамтарч хийдэг энэ эрх зүйн орчныг бий болгосноороо ийм ач холбогдолтой гэж ингээж үзэж байгаа юм. Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх төрийн дэмжлэг гэдэг тусгай заалтууд байгаа. Энэ заалтууд маань бол тодорхой ажил болно. Энэ хөгжиж байгаа орнуудад энэ шинжлэх ухааны үүрэг бол юу гэхээр тэр нээлт хийхээсээ илүүтэйгээр энэ нэгэнт бий болчихсон өндөр технологиудыг нутагшуулах асуудал маш их чухал асуудал болж тавигдаж байгаа юм л даа. Дугуйг дахин зохион бүтээж хэрэггүй гэдэг шүү дээ. Тийм учраас өндөр технологиудыг Монгол орны энэ орчиндоо зохицуулж нутагшуулах асуудлын эрх зүйн орчин нь энд бүрдэж байгаа.

Мөн хоёрдугаарт нь юу вэ гэхээр энэ шинжлэх ухаан, технологийн энэ ач холбогдолтой асуудлуудыг энэ шийдвэр гаргах түвшинд өөрөөр хэлбэл зөвлөх энэ утгаараа Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийг байгуулж, Ерөнхий сайдын дэргэд ажиллуулна. 19 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус Монголын шилдэг эрдэмтдийг энд оруулъя. Салбар болгоноороо. Ингэснээрээ бол юу гэхээр энэ Засгийн

газраас гарч байгаа шийдвэр бол шинжлэх ухааны үндэслэлтэй болно. Яамнуудад салбар зөвлөлүүд байгуулагдана. Орон нутгуудад дэд зөвлөлүүд байгуулагдах, ингэснээрээ Монголын төрөөс гарч байгаа шийдвэр болгон шинжлэх ухааны үндэслэлтэй болох ийм эрх зүйн орчин бүрдэж байгаа юм. Ийм хариултыг хэлье. Манай ажлын хэсгээс, яамнаас нэмж хариулж болно.

**Г.Занданшатар:** Ганбаяр дэд сайд. Ганболдын Ганбаяр Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд 4 номер.

**Г.Ганбаяр:** Учрал гишүүний асуултад тодруулъя. Таны хэлж байгаагаар ер нь шинжлэх ухааны энэ санхүүжилтийн төвлөрлийг нэлээн задлаад, салбарын болоод аймгийн Засаг дарга нарын багцад буюу улсын төсөв, орон нутгийн төсөв дээр санхүүжүүлэх захиалга, судалгаануудыг санхүүжүүлэх тэр эрх зүйн орчныг нь энэ хуулиар нээгээд өгчхөж байгаа юм. Одоо байгаа эрх зүйн орчин зөвхөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад байгаа.

Тэр нь нөгөө Шинжлэх ухаан, технологийн сангаар дамжуулж, 15 тэрбум төгрөг л хуваарилагддаг байсан. Энэ нь өнөөдөр шинжлэх ухаан салбарт ялангуяа захиалга судалгаа энэ газар тариалангийн чиглэлийн юу гэдэг юм будаа сортын асуудал гээд байхад хаанаа ч хүрэхгүй мөнгө. Үндсэндээ манай шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн л бараг урсгал зардалд хүрэхдээ хүрэхгүйдээ мөнгө байсныг энэ хуулиар улс болон аймаг орон нутгийн, тэгээд салбар яамнуудын дэргэд дэргэдэх зөвлөлөөрөө дамжуулаад тухайн сахилгынхаа судалгаагаа тухайн тухайн бүтэц дээрээ тааруулаад санхүүжих тэр эрх зүйн орчныг бүрдүүлэхээр хуульчилж оруулж ирж байгаа. Тэгээд өнөөдөр Их Хурал дэмжээд гарах юм бол санхүүжилтийн хувьд нэлээн тийм тэлсэн ийм эрх зүйн орчинтой болно л гэж бид нар ойлгож байгаа, хүлээж байгаа.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя. Дараа нь санал хураалттай гишүүд чуулганы танхимд.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр яг энэ чуулган дуусах энэ мөчтэй зэрэгцүүлээд олон олон хуулиуд, ялангуяа сонгуульд зориулсан хуулиуд Баялгийн сангийн тухай хууль тэр нөгөө мал нийгэмчлэх хууль энэ тэр гээд олон олон хуулиуд орж ирж байгаа. Тэгээд батлаад батлаад гаргалаа. Тэгээд энэ дээрээс нь дахиад Цэцийн хууль байна. 2 ч хууль байгаа. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль бас орж ирж байна. Тэгээд энэ Шинжлэх ухаан, технологийн бас энэ хууль орж ирж байна. Энэ чинь маш чухал чухал хуулиуд байхгүй юу даа. Тэгээд энэ хуулиудыг дөнгөж ирц хүргээд яг энэ Их Хурлын гишүүдийн Байнгын хороо, ажлын хэсэг, Их Хурал дээр ерөөсөө ямар ч мэтгэлцээн, хэлэлцүүлэг болохгүйгээр энэ хуулиуд батлагдаад явах гэж байна. Ингэж салбарын хуулийг чанаргүй, гурилдаж гаргаж болохгүй гэж би үзэж байгаа.

Тийм учраас энэ Их Хурал сүүлийн энэ цөөхөн хугацаандаа өөрийнхөө тогтоосон заавал хэлэлцэх ёстой тэр хууль, тогтоолуудаа, дээрээс нь шинэ Их Хурал бүрэлдэхэд шаардлагатай тэр хуулиудыг л хэлэлцээд явсан нь дээр. Тэгэхгүй бол одоо энэ чинь замбараагүй юм болох нь байна шүү дээ. Чоно борооноор гэгчээр энэ Шинжлэх ухаан, технологийн хууль дээр чинь ямар ч тендергүйгээр бараа, үйлчилгээ, санхүү янз янзын үйлчилгээ авахад тендергүйгээр ажлаа хийхээр болчихсон орж ирж байна шүү дээ.

Жишээ нь, Засгийн газар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шинжлэх ухаан, технологийн төсөл, үндэсний судалгаа, хөгжүүлэлтийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг

төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж санхүүжүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөхгүй гэж байна шүү дээ. Энэ чинь тэгээд л ерөөсөө тийм цүнх баригчаа аваачиж томилчихоод тэрүүгээрээ л бүх ажлаа хийлгэнэ л гэсэн үг шүү дээ.

Ингэж болохгүй. Та нар ерөөсөө энэ чинь энэ яаж байна гэхээр та нар ерөөсөө хувийн хэвилийн тэр шинжлэх ухааны хөгжүүлэлтийг огт хийхгүй, төрийн өмчөөрөө л бүх юмаа хийнэ. Тэнд нэг бугисан хэдэн нөхдүүд л тэндээ ажиллаад, тэндээ хувааж иднэ гэдэг л ийм л юм. Өөрөөр хэлбэл, энэ чинь хувийн хэвшил л тэр шинжлэх ухааныг илүү сайн зүгт нь авчирч хөгжүүлнэ үү гэхээс бусдаар төрийнхөн тэгээд л хөгжүүлчихдэг байсан бол Монгол одоо хүртэл хөгжихгүй юугаа хийж байгаа юм. Ингэж хувийн хэвилийг дарамталсан хувийн хэвилийнхнийг дандаа хойш нь татсан тэгээд өөрсдийнхөө цүнх баригчдыг томилчихсон төрийн өмчийн болон тэр шинжлэх ухааны байгууллагуудаа ивээн тэтгэсэн ийм л юмыг хийх нь байна шүү дээ. Та нар наанаа дандаа ингээд энэ хувийн хэвилийг дэмжинэ гэж ярьдаг мөртөө цаанаа бүх юмыг, бүх салбарт, бүх хуулиар, бүх түвшинд бүгдийг нь энэ төрийн болгох ийм ажлыг хийж байна шүү дээ Цогтбаатар гишүүнээ. Бүгд төрийнх болж байна шүү дээ энэ чинь. Та тэрний эсрэг тэмцээд байгаа биз дээ? Тэр хуулиа явуул л даа. Энэ арай хэтэрнэ. Ингэж тэгээд энэ Шинжлэх ухааны академийн янз янзын тэрний харьяа байгууллагууд сайн байдаг байсан бол Монгол одоо хөгжөөд л өнөөдөр гоё түвшинд очихгүй яасан юм? Бид нар ийм хэл ам, хэрүүл тэмцэл хийсэн авгай хүүхний хэрүүл хийсэн л ийм л орон хэвээрээ үлдэж байна шүү дээ. Бусад бүх орон бүгдээрээ эй ай-аар бүх асуудлаа шийддэг болоод л явж байна шүү дээ. Бидний боловсрол өдрөөс өдөрт унаад л



*бид нарын бид нарын боловсрол.../минут дуусав./*

**Г.Занданшатар:** Хэн хариулах уу? Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Энэ хуулийн бас зүйл, заалт нь Пүрэвдорж гишүүнээ, та нар энийгээ сайн уншаарай. Хувийн хэвилийг дэмжих гээд цоо шинэ заалт орж ирж байгаа шүү. Урд талын хуулиуд дээр нь байхгүй. Нэгдүгээрт энийг ингээд хэлчихье.

Хоёрдугаарт, энэ хууль маань бол дөнгөж сая орж ирээд л сонгуулийн урд талд ингээд л ингэж байгаа юм байхгүй. Хаврын чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусчихсан байгаа. Үүнийг хэлье.

Гуравдугаарт нь бол энэ тендерийн асуудал байж байгаа. Энэ ажлын хэсэг гаргасан юм саналыг нь. Энэ та нар унш даа Засгийн газар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шинжлэх ухаан, технологийн төсөл, үндэсний судалгаа, хөгжүүлэлтийн төсөл, судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж, санхүүжүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр тэр хуулийг дагахгүй гэж байгаа юм. Үүнийг яагаад ингэж оруулсан гэхээр энэ сүүлийн үед энэ ченжүүд бий болчихсон. Эрдэм шинжилгээний байгууллага дээр байж байгаа 100 сая төгрөгийн үнэтэй судалгааг тэндээс 100 саяар нь аваад төрийн тендерт ороод 300 саяар шахчихдаг. Тодорхой жишээ байна шүү дээ. Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр дээр гарсан. Тодорхой юм.

Тийм учраас бол энд их тийм их мөнгө зараад байх юм бол байхгүй. Яг Засгийн газар жил жилийнхээ төлөвлөгөөнд ямар суурь судалгаанууд байна үүнийг тэр тухайн байгууллагаар

нь хийлгэе. Энэ тэртээ тэргүй энэ байгууллагуудыг чинь төрөөс санхүүжүүлж байгаа шүү дээ. Тэр утгаар нь энийг ингэж оруулсан юм. Тэгээд бүгд санал нэгтэй үүнийг дэмжсэн.

Хувийн хэвилийг бол дэмжинэ. Хувийн хэвилийн судалгааг бол бүх талаар дэмжиж байгаа. Өнөөдөр бүтэц, энэ эрдэм шинжилгээний байгууллага, энэ шинжлэх ухааны бүтэц маань төрийн, хувийн хэвилийн хамтарсан ийм бүтэцтэй байх юм гэсэн ийм саналууд энд явж байгаа юм. Тэгээд яамныхан нь энэ дээр тодорхой хариултууд байвал нэмээд өгнө биз дээ.

**Г.Занданшатар:** Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

**Б.Пүрэвдорж:** Надаа энэ дэд ажлын хэсэг, ажлын хэсгийнхэн бүгдээрээ мэдээллээ яг энэ яг энэ заалт дээр очоод санал хураах үед өгөөрэй. Хэн гэдэг гишүүн энэ зарчмын зөрүүтэй саналаар гаргасан юм? Хэн гэдэг гишүүд дэмжсэн юм, хэн ажлын дэд хэсгээс хэн оруулж ирсэн юм? Энэ нь хувийн хэвилийнхээ эсрэг төрд л бүх юмыг хийх ёстой, төр л бүхний толгой дээр байх ёстой гэдэг энэ ардчиллын эсрэг заалтыг хэн оруулж ирээд байгаа юм тэр юм бүгдийг нь ярьж, би тэгээд яг тэр асуулт, санал дээр би бүгдийг нь асууж, лавлаж тодруулна. Ер нь энэ Их Хурлын гишүүд ийм хурдан хууль оруулж ирээд л тэгээд л ерөөсөө гуравхан өдрийн дотор өргөн бариад л тэгээд л хэлэлцүүлээд л тэгээд шийдүүлдэг гэж юм байхгүй шүү. Ер нь явах хүнээр ачаа бүү татуул гэж үг байгаа шүү. Үлдэх хүнээр битгий ачаа бүү татуул гэж үг байдаг шүү. Тийм учраас энэ тийм.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулна.

**Л.Энх-Амгалан:** Пүрэвдорж гишүүнээ одоо ингээд бид нар бас төрийн

ой санамж гэж юм байх ёстой шүү. Суулийн үед үндсэндээ энэ чинь сонгууль дөхөөд ингээд ийм улс төрийн акцаа Улсын Их Хурлын гишүүнийхээ эрхийг давуулан ашиглаж 5 дахь өдрийн өглөө бүхэн микрофон ашиглаж ингэж улс төрийн рейтингээ дээшлүүлэх ийм явцгүй акц хийх би шаардлагагүй гэж ойлгож байгаа. Тэр тусмаа ингээд шинжлэх ухаан руу дайрдаг, шинжлэх ухааны нэр хүндийг ингэж унагаж байгаа ийм хариуцлагагүй үг, үйлдэл гаргаж байна шүү та. Өнөөдөр Сайханбилигийн Засгийн газрын үед энэ шинжлэх ухаануудын хүрээлэнгүүдийг бүгдийг нь татан буулгасан ийм шийдвэр гарч байсан. Тэгээд бүгдийг нь татан буулгачхаад, бүх санхүүжилтийг нь зогсоочхоод та нар санхүүжилт шинжлэх ухаанаас ямар өр өгөөж хүлээгээд байгаа юм? Иймэрхүү хэлбэрээр та нар улс төржиж болохгүй шүү би хариуцлагатай хэлж байна.

**Г.Занданшатар:** Нэмж лавлах юм байна. Энэ асуулт, хариултыг тодруулах биш, та тэгэхдээ өөрөө энэ дээр байна шүү дээ 22 дугаар зүйлд хувийн хэвшлийн судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих гэж байгаа энэ “Ар Эн Ди” буюу судалгаа хөгжүүлэлтийн ажлыг энэ чинь маш цогц хууль дээр бас ингэж, төрийн ажил тасралтгүй явах ёстой. Энэ чинь сонгууль болох гэж байгаад бүх юмаа хийж болохгүй. Шинжлэх ухаан академийн статус олон улсын хуучин цагаараа яваад байна шүү дээ социализмоор. Тийм учраас та бол хэлэлцэх эсэх дээр, хэлэлцэх эсэх. Энэ анхны хэлэлцүүлэг явж байна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асууна. Та бол тийм асуулт асуухгүй байгаа юм. Тийм учраас шинжлэх ухаантай дайсагнаж хэрэггүй.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3. “шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа” гэж хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн боловсрол олгох, шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг;”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Тилеуханы Аубакир, Энхбаярын Батшугар, Гонгорын Дамдинням, Бадарчийн Жаргалмаа, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Салдангийн Одонтуяа, Чинбатын Ундрам, Жигжидсүрэнгийн Чинбүрэн цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. Ирц өглөөнийхөө ирцээр явдаг юм. Энэ бүртгэлийн санал хураалт шүү. Эхний санал хураалт бүртгэлийн санал хураалт явуулчихна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу өглөөний ирцээрээ бүртгэж явна. Санал хураалтыг тэр зарчмаар оруулна. Ер нь ингээд дэлхий даяар технологи шинжлэх ухааны 4 дүгээр эрин үе эхэлж байхад ингээд шинжлэх ухааныг эсэргүүцээд хурал хаяж гарвал их л муухай юм болох байх даа.

Хөөш хөөш үгүй үгүй тэр тендергүй явах чинь гүйцээн боловсруулах чиглэл өгнө. Хөөе Пүрэвдорж гишүүнээ ер нь патент эзэмшигч бол шууд гэрээ байгуулдаг Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуулийн тийм заалт байдаг юм. Тухайн тэр заалт дээрээ л ярина шүү дээ та. Энэ 22 дугаар зүйл дээр ийм заалт байна лээ жишээлбэл би танд уншиж өгье.

Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлт, технологийн хөгжлийг дэмжих. Бүгд явдаг юм. Засгийн газар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэнэ энэ тэр гэх мэтчилэн. Тэгээд шинжлэх ухаандаа загнаж хэрэггүй. Тийм хаяж явж хэрэггүй, тэгээд л тухайн заалт дээрээ л ярь. Тэрийгээ тэр 13 дахь санал. Адьшаа гишүүн дэмжиж байгаа юм байна. Саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Ингээд санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүн тайвшир тайвшир. Яах вэ ажил хэргийн төлөө аль маргалдахыг тэр гэх вэ. Тэгээд сургуулийн хүүхэд шиг хаяж гарч гүйгээд яах вэ энэ чинь. Ингээд санал хураалт явуулъя. Адьшаа гишүүн та ирцэд орчих тэгэх үү. Үгүй үгүй энд гарчихсан байгаа. Сая гарахдаа гаргачихсан. Одоо ингээд болж байна. Пүрэвдорж миний хүү картаа хийчих. Санал хураалт явуулъя. Учрыг магадалъя. Дэмий мэтгэлцээн болсон. Үгүй ирцэд байхгүй байгаа юм. Пүрэвдорж гишүүн орчихсон байна. Ингээд ирц 54 хувьтай байгаа. 39 гишүүн 54 хувьтай ирц байна. Санал хураалтад бэлдье. Санал хураалт. Тийм тийм. 13-ыг 13-ыг гүйцээн босгох чиглэл өгчихье. Тэр Патент, технологийн хуулийн тэртэйгээ явъя. Таны саналыг ингээд хүндэтгэж хүлээж авъя.

27 гишүүн дэмжиж, 69.2 хувийн саналаар санал хураалт. Яг тэнд гэрэл анивчаад байна.

2.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.6 дахь заалт нэмж, мөн зүйлийн 3.1.15 дахь заалтын “3.1.12-т” гэснийг “3.1.13-т” гэж өөрчлөх.

“3.1.6."грант" гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилсан нөхцөл, болзол тавьсны үндсэн дээр тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулах зориулалтаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй

олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг;”. Санал гаргасан ажлын хэсэг.

Пүрэвдорж гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр би ер нь бол хүч түрж баталсан олон хуулийн хэрэгжилт дээр би хяналт тавиад л явж байгаа юм. Их Хурлын гишүүний үүрэг бол хяналт тавих. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих. Тэгэхээр ер нь ингэдэг байхгүй юу даа. Энэ Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар тийм ээ, гоё гоё заалтуудыг хувийн хэвшлийг ингэж дэмжинэ гэдэг гоё гоё заалтууд орчихсон байгаа. Тэрэнд нь манай хувийн хэвшлийнхэн аймаар баярлана. Үгүй ёстой сайхан хууль дэмжинэ гээд явна тийм үү? Тэгэнгүүт яг урд нь тэрний ард нь бас нэг ийм заалт оруулчихдаг байхгүй юу.

Өөрөөр хэлбэл, төрийн өмчийн шинжлэх ухааны байгууллагад бүх юмыг тендергүйгээр өгнө гэж байна. Тэгээд амьдрал дээр хэрэгжих дээр байна шүү дээ. Тэр хойно байгаа тэр хувийн хэвшлийнхэнд гоё заасан заалт нэг ч хэрэгжихгүй. Хаана хэрэгждэг үү гэхээр хэн нэгэн албан тушаалтны цүнх баригчийн тавьсан тэр шинжлэх ухааны байгууллага дээр бүгдээрээ тендергүй очдог байхгүй юу даа. Тэгээд Монгол хөгжихгүй байгаад байхгүй юу. Би энэ дээр би зүгээр л энэ заалтаа больчоод тэр. Хэрвээ тэр төрийн өмчийн төрийн байгууллага нь байна шүү дээ тийм төрийн өмчийн тэр шинжлэх ухааны байгууллага нь тийм сүрхий юм бол хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд л тэр юмаа авцгаа. Би тэр дээр чинь эсэргүүцэхгүй байгаа шүү дээ. Монгол сайхан хөгжөөсэй л гэж байгаа юм. Бусдаар би та нарын тэр хойно хувийн хэвшлийнхнийг дэмжинэ гэсэн заалтыг чинь би бас дэмжиж л байгаа.

Тэгэхдээ амьдрал дээр огт хэрэгжихгүй. Амьдрал дээр юу хэрэгжих вэ гэхээр тендергүйгээр шалгаруулах тэр юманд дарга нар бүгдээрээ шунан орно шүү дээ. Бүгдээрээ тийшээ шунаж дэв мэт тийшээ орно. Тэрний дагуу баахан тендергүй ажил, тэр хэн нэгнийх нь хамаарал бүхий цүнх баригчийнх нь газар очно. Тэгээд л Монгол хөгжихгүй л өнөөдрийг хүртэл явлаа шүү дээ. Би энийг л хэлж байгаа. Тэгээд над руу дайрвал дайрна л биз.

**Г.Занданишатар:** Хариулт байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй л.

Пүрэвдорж гишүүнээ энэ 13 дахь санал хураалтыг өнөөдөр хэлчихлээ. 13 дахь санал хураалт. Ингээд санал хураалт явуулна. Санал хураалт. Энэ дээр чиглэл дараа нь өгнө.

25 гишүүн дэмжиж, 64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ дээр байна шүү дээ “грант” гэдэг заавал гадаад үг хэрэглэх гээд байгаа юм? Тэтгэмж, буцалтгүй тусламж, шинжлэх ухааны ингээд дотроо тодорхойлчихож байгаа юм чинь бас шинжлэх ухаан талаас тэтгэлэг юу байдаг юм үг зохиож болно шүү дээ. Заавал гадаад үг орохоор л гоё болгоод энийг эцсийн найруулга дээр найруулгаар засмаар байгаа юм. Шинжлэх ухааны хүмүүс байна даа Рэгдэл гуай. Хэлний зөвлөлтэйгөө ярьж байгаад заавал “грант” гээд гадаад үг л тавихаар л “грант” болоод явчихвал наадах чинь.

Дараагийнх нь 3. Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “үндэсний” гэснийг “удирдлагын” гэж өөрчлөх. санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн хуульд ийм заалт байгаа юм. Гадаад үг хууль

тогтоомжид ашиглах бол тэрийг Хэлний зөвлөлөөр тодорхойлолт магадалгаа гаргасан байна гэж.

4.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.6.ж дэд заалтыг хасаж, төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “20 хүртэл” гэснийг “19” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “Ерөнхий сайдын захирамжаар” гэснийг “Засгийн газрын тогтоолоор” гэж, мөн төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “ажиллах үлгэрчилсэн дүрмийг Ерөнхий сайдын захирамжаар” гэснийг “үлгэрчилсэн дүрмийг Засгийн газрын тогтоолоор” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Академик эрх чөлөө гэж байгаа юм.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.6.үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, суурь болон хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгирүүлэлтийн ажлын чиглэл, санхүүжилтийг батлах;”. Санал гаргасан ажлын хэсгийн. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.5.шинжлэх ухаан, технологийн урьдчилсан таамаглалд шаардлагатай баримт материалыг энэ

хуулийн 3.1.14-3.1.18-д заасан болон холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2 дахь хэсэг нэмэх:

“22.2.Засгийн газар хувийн хэвилийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх бөгөөд уг асуудлыг Татварын хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 23 дугаар зүйлийн гарчгийг “Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг дэмжих” гэж өөрчилж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Засгийн газар төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлд санхүүжилтийн дэмжлэг олгоно. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын байгууллага, гадаад улсын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт хамтарсан эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, шинжлэх ухаан, технологийн хамтарсан төсөл хэрэгжүүлэх эрхтэй.

24.3.Монгол Улсын харьяат эрдэмтэн, судлаач, эрдэм шинжилгээний байгууллага нь гадаад улс, олон улсын байгууллага, шинжлэх ухааны нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх эрхтэй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “авьяаслаг судлаачдыг” гэснийг “авьяас, ур чадвартай судлаачийг” гэж, мөн зүйлийн 27.3 дахь хэсгийн “авьяаслаг эрдэмтэн, судлаачийг” гэснийг “авьяас, ур чадвартай, мэргэшсэн эрдэмтэн, судлаачийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Талентад авьяасыг л үнэлэх гэж байгаа юман дээр яах вэ ур чадвар энэ тэр гээд нэмээд явчихаар хэтрүүлж.

66.7 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

12.Төслийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.7 дахь хэсэг нэмэх:

“28.7.Эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиглэлээр дотоодод ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа эрдэм шинжилгээний ажилтанд сургалтын төлбөрийн 100 хүртэл хувийн дэмжлэгийг тухайн эрдэм шинжилгээний байгууллагаас үзүүлж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Ер нь урд, хойд хөршид, ер нь дэлхий дээр мянган эрдэмтэн гэх мэтчилэн гадаадаас эрдэмтдээ татаж авчрах тийм л бодлого гарч явж байгаа л даа. Дотоод гэж энэ дотор уншигдаагүй шүү дээ. Одоо 12 дахь энэ одоо хураах гэж байгаа санал дээр байгаа. Өнгөрсөн дээр байхгүй. Хураачихсан. Энэ 12 дээр тэр дотоодод гэсэн. Ингэж бичээд л уншигдчихлаа. Эцсийн хэлэлцүүлэг дээр..

13.Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шинжлэх ухаан, технологийн төсөл, үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж, санхүүжүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөхгүй.”.

Үүнийг ингээд гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Энэ их хэл амтай, маргаантай. Энэ байна шүү дээ яг ингэж заах бол Төрийн ба орон нутгийн өмчийн хуулийг дагаж өөрчлөх хэрэгтэй болно. Үндсэн хуулиа барьчихдаг байхгүй юу. Тэр хуульд өөрчлөлт ороогүй байхад үүгээр нь ингээд явагдахгүй.

Хоёрдугаарт, патенттай бол шууд гэрээ байгуулж болно гэх мэтчилэн ийм заалтууд байгаа. Үүнийгээ нарийвчилж яаж байж явахгүй энэ дээр чинь нэлээн тийм. Гүйцээн боловсруулах чиглэл өгчихсөн. Энэ дээр олон санал, олон хүн үг хэлэх гэж байгаа юм.

14.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “судлаачдын хамтлагт” гэснийг “судлаачид” гэж, 36 дугаар зүйлийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.” гэснийг “холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 37 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“37 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

37.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

37.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гэмт хэргийн шинж энэ тэр гэж тодорхойлохгүй. Энэ найруулга дээр байна шүү дээ. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэж найруулал даа. Гэмт хэргийн шинжтэй, шинжгүй гэдгийг чинь хууль өөрөө тодорхойлохгүй шүү дээ. Хууль тодорхой байх ёстой. .

25 саналаар, 25 хүн дэмжиж, 64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**31 дүгээр зүйл.** Дээд боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Шинжлэх ухаан” гэснийг “Үндэсний шинжлэх ухаан технологийн” гэж өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ саналыг ажлын хэсэг татаж авах санал гаргасан учраас буцааж татаж авлаа.

2.Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд илжжүүлээ. Дараа нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль хойшилчихсон. Энх-Амгалан сайд, сайд нар гарч явахгүй, гишүүд гарч явахгүй. Энэ олон хойшилж байгаа тухай хуулийг бүгдээрээ хэлэлцүүлж дуусгана шүү.

11.50 цаг

**Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.**

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын

зөрүүтэй 48 санал байгаа. Ажлын хэсгийг оруулж ирье.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “эрхлэх хувь” гэснийг “эрхэлж байгаа” гэж, 4.1.9 дэх заалтын “зэргийг кластержуулах замаар дэмжсэн,” гэснийг “зэргээр энэ хуулийн 4.1.8-д заасан кластер байгуулсан” гэж, “төвлөрлийн түвшин бусад бүс нутгаас өндөр байгаа” гэснийг “төвлөрсөн” гэж өөрчилж, 4.1.8 дахь заалтын “байршлын хувьд” гэсний дараа “болон” гэж нэмэх. Санал гаргасан. Улсын Хурлын гишүүн Чинбатын Ундрэм, Амгалангийн Адъяасүрэн, Пүрэв-Очирын Анужин, Тилеуханы Аубакир, Энхбаярын Батшугар, Гонгорын Дамдинням, Бадарчийн Жаргалмаа, Гомпилдоогийн Мөнхцэцэг цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт.

Адьяаа гишүүнээ энэ хуулийг хэлэлцэж баталчхаад гарчих тэгэх үү. Ширнэнбаньдийн Адьяаа гишүүн үг хэлнэ горим. Гишүүд гарч явахгүй. Энэ хуулийг санал хурааж дуустал Байнгын хороод хуралдахгүй. Энэ санал хураалтыг дууссаны дараа Байнгын хороод хуралдана.

**Ш.Адьяаа:** Уг нь энэ заалтыг би дэмжсэн юм. Тэгээд сая энэ төхөөрөмж гацчихлаа. Дахиж санал хураалт явуулж өгөх үү?

**Г.Занданшатар:** Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Тэрний өмнө ажлын хэсгийг танилцуулчихъя.

Соёлын сайд Чинбатын Номин, Ажлын хэсэг нь Ундрэм. Соёлын дэд сайд Пүрэвсүрэнгийн Баттөр, Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Готовсүрэнгийн Батхуяг, Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн

дарга Содномжамцын Батцэцэг, Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Цэрэндоржийн Чулуунбат, Ая зохиогч, продюсер, дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн гишүүн Дашийн Өлзий-Орших, Монгол анимэйшн холбооны гүйцэтгэх захирал Энхсайханы Тамир “Мюзик” ХХК-ийн захирал Дашнямын Батмагнай, “Өмгөөллийн Төгс энд Ко” ХХК-ийн захирал Ганжуурын Төгсбаяр.

Санал хураалт явуулна. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явна. Энхболд гишүүн суудлаасаа суучих. Ганбат гишүүн суудалдаа суучих. Баярлалаа. Энэ Пүрэвдорж гишүүнийг дууд. Санал хураалт. Зогсож байгаад санал өгч болохгүй. Санал хураалт үймүүлээд, хүмүүсийн анхаарал сарниулна.

24 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт дэмжигдсэн учраас. Суу өөрийнхөө хуулийг хэлэлцүүлчхээд тэгээд. Санал хураалт. Одоо саналын томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энх-Амгалан гишүүн босож явахгүй гэж, ирц бүрдүүлнэ гэж ам тангаргаа өгч байна. Үдээс хойш хүртэл яг сууна гэсэн юм. Тэгж шинжлэх ухааны хуулиа авсан.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хөдөлмөр эрхлэлт,” гэснийг “6.1.3.” дахь заалт руу шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Сарангэрэл гишүүн хаачих нь вэ?

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “түгээх үйл явцыг” гэснийг “түгээхтэй холбоотой үйл ажиллагааг”

гэж, 7.4 дэх хэсгийг 7.5 дахь хэсэг болгон өөрчилж, 7.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 7.2-т заасан” гэснийг болон “7.5” дахь хэсгийг тус тус хасах.Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Түрүүчийнхийг бас 67.5 хувийн саналаар санал дэмжсэн.

4.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “агуулгыг дэмжих” гэснийг “агуулгын дэмжлэг” гэж, 8.3 дахь хэсгийн “эзэмшүүлнэ” гэснийг “олгоно” гэж, 8.4 дэх хэсгийн “15-18 хүртэлх” гэснийг “16-18” гэж, 8.5 дахь хэсгийн “заасныг хэрэгжүүлж,” гэснийг “заасан үндэсний соёлын агуулгыг дэмжих болон” гэж, “хязгаарлалт тавих, шаардлага тавихтай холбоотой журам” гэснийг “хязгаарлалт тогтоохтой холбоотой журам” гэж өөрчилж, 8.3 дахь хэсгийн “энэ хуулийн 8.4-т заасан” гэснийг болон “8.2” дахь хэсгийг тус тус хасаж, 8.5 дахь хэсгийн “8.3” гэсний өмнө “8.1,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт явчихсан. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн, 48-н санал хураалттай. Одоо жоохон шуурхай явуулна. 1-ээс өмнө амжуулъя. Намайг унисаны дараа.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.3 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 9.8 дахь хэсгийн “Мэргэжлийн” гэсний дараа “болон техникийн” гэж нэмж, 9.4 дэх хэсгийн “мэргэшүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд” гэснийг “мэргэшүүлэхэд” гэж, 9.6.2 дахь заалтын “Боловсролын тухай хуульд” гэснийг “боловсролын хууль тогтоомжид” гэж, 9.6.3 дахь заалтын “шатны” гэснийг “түвшний” гэж, 9.6.4 дэх заалтын “чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа” гэснийг “чиглэлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа” гэж, 9.8 дахь хэсгийн “9.6-д” гэснийг “9.6.1, 9.6.4-т” гэж,



“9.7-т” гэснийг “9.7.1, 9.7.2-т” гэж өөрчилж, 9.6.1 дэх заалтын “хөнгөлөлттэй” гэснийг болон “, холбогдох журмыг батлах” гэснийг тус тус хасах.

Дашдондогийн Ганбат гишүүн. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

**Д.Ганбат:** Ерөнхийдөө Соёлын хуулийг дэмжиж байгаа юм. Гэхдээ энэ Улсын Их Хурал, бид нар нэлээн сайн ажиллаад энэ хуулийг шахаад ингэж явж байна л даа. Тэгээд энэ хэдэн гишүүд энэ хуулийн өчнөөн олон заалт дээр л ажилласан байна шүү дээ. Ийм дутуу дулимаг боловсруулсан ийм юмыг Засгийн газар оруулж ирж байх нь зөв юм уу? Заримдаа энэ Улсын Их Хурал чинь Монгол ардын намын дарга нарын хуулийн хэлтэс шиг байх юм аа айн? Хуулийн хэлтэс ч юм уу, нэгж ч юм уу юу ч юм. Арай дэндүүлэх юм. Манай цөөнх Пүрэвдорж гишүүн бид хоёр бүгдээрээ л энэ гишүүн шар махтайгаа хатаж байна шүү дээ. Энэ Улсын Их Хурлын сонгуулийн тойрог энээ тэрээ гэхээсээ гадна энэ хуулийг чинь аятайхан хууль гаргачихын төлөө их хичээж ажиллах юм.

Тэгтэл одоо энэ Засгийн газрын байж байгаа царай нь үгүй энэ Соёлын яаманд чинь өчнөөн мөнгө төгрөг хуваарилна биз дээ? Тэгээд сайжруулна барина гээд. Одоо бид нар Солонгосоос суралцах хэрэгтэй байна шүү дээ. Тэр өчнөөн сайн контент хийгээд дэлхий даяар тарааж чадаж байна. Бид нар чинь хэдэн мянган жилийн уламжлалтай ийм соёлтой улсууд. Аялал жуулчлалын хувьд энэ дээр аятайхан юм байгаа. Тэр ганцхан “НУ” хамтлаг гэхэд л энэ Засгийн газраас илүү юм хийж чадаж байна шүү дээ. Айн? Энэ чинь соёлоо түгээж байгаа хэлбэр биш юм уу? Тийм, ингэж ажиллаж байна. Тэгэхээр тэрэнтэй харьцуулаад үзэхээр энэ Засгийн газар аягүй чамлалттай байгаа байхгүй юу даа.

400, 500 тэрбум тавьчихсан байдаг. Тэгээд л энд хэдэн хэрэгтэй, хэрэггүй контентууд, контент телевизээр зэрэг зэрэг цацаж иргэдийн толгой угаахаас өөр юм алга байна шүү дээ. Энэ Улсын Их Хурал их маш сайн ажиллаж байгаа гэж бодож байгаа. Гэхдээ заримдаа арай дэндүү байна. Конвероор хууль, конвероор Хятад бараа ингээд л штамп тавиад л гаргаж байгаа юм шиг л ийм хуулиуд Засгийн газар нь шахаад байдаг юм уу, шаардаад байдаг юм уу? Давхар дээлтэй сайд хэтэрхий олон байгаагийн гай юм уу, юу юм? Эсвэл энэ намын дарга Ерөнхий сайд нь болчихоор дарамттай байдаг юм уу? Ямар учир, шалтгаан байна? Энэ чинь энэ Улсын Их Хурлын талаар л би ярьж байна шүү дээ. Хууль сайжруулахын төлөө л ярьж байна. Тийм, хууль ярьж байна. Тэгвэл больчихъё л доо.

**Г.Занданшатар:** Харин энэ ингээд Номин сайд чинь давхар дээлгүй байхгүй юу. Тэгээд энэ чинь бас Засгийн газар гэхээсээ энэ уран бүтээлчид нь дэмжээд ингээд сууж байгаа биз дээ? Энэ уран бүтээлчид дэмжээд санаачилж ажиллаж байгаа юм чинь.

Тийм учраас ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Зургаа төслийн 10 дугаар зүйлийн “10.3” дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Буцаачихсан. 28 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэр Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуультайгаа нийцүүлээд, Худалдан авах хуультай нийцүүлээд Пүрэвдорж гишүүнээ тэндээс янзал. Одоо наад хуулиа сайн дэмжинэ шүү Пүрэвдорж гишүүнээ.

7.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “тэргүүн ээлжид” гэснийг, 11.1.3 дахь заалтын “үндэсний болон олон улсын” гэснийг хасаж, 11.1.5 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 11.3 дахь хэсгийн “11.2” гэснийг “10.1” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

8 дахь саналыг ажлын хэсэг гүйцээн боловсруулах чиглэл авах санал гаргасан учир гүйцээн боловсруулах санал.

9 дэх санал мөн адил. 9 дэх саналыг мөн гүйцээн боловсруулах чиглэл. Гүйцээчихсэн.

10.Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “дэмжлэг” гэсний өмнө “болон бусад” гэж нэмж, 13.1.1 дэх заалтын “төсвийн дэмжлэг үзүүлэх” гэснийг “төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж, 13.1.4 дэх заалтын “гаргах” гэснийг “санхүүжүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Ер нь Тамгын газар, ажлын хэсэг сайн ажилласан л даа.

24 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “14.1” гэсний дараа “; 14.5” гэж, 14.5 дахь хэсгийн “олон” гэсний дараа “улсын” гэж нэмж, 14.5 дахь хэсгийн “Холбогдох журмыг Засгийн газар батална.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Яах вэ одоо сунжруулж яах юм. Үүнийг шуурхай явуулчихъя.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1 дэх хэсгийн “хамтын удирдлагын байгууллага,” гэсний дараа

“эсхүл” гэж, 15.10 дахь хэсгийн “Соёлын” гэсний өмнө “холбогдох төрийн байгууллага” гэж нэмж, 15.2 дахь хэсгийн “төр, нийтийн” гэснийг “төрийн” гэж, “холбогдох бүртгэлийг” гэснийг “бүртгэл” гэж, 15.6 дахь хэсгийн “таатай үнээр” гэснийг “хөнгөлөлттэй үнэ” гэж, 15.10 дахь хэсгийн “авах” гэснийг “өгөх” гэж өөрчилж, 15.8 дахь хэсгийн “; хөтөлбөрийг” гэснийг болон “15.9” дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 16.1 дэх хэсгийн “боловсруулан,” гэснийг, 16.4 дэх хэсгийн “Төрөөс” гэснийг хасаж, 16.3 дахь хэсгийн “Төр өөрийн мэдэлд байгаа” гэснийг “Төрийн эзэмшлийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураачихна. Дараагийнх дээр өгүүлчихье.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “кластерын” гэсний ард “төлөвлөлт, эсхүл” гэж нэмж, 17.6 дахь хэсгийн “олгохдоо” гэснийг “хүссэн этгээд нь” гэж, 17.8 дахь хэсгийн “төвлөрлийн түвшинг” гэснийг “төвлөрлийг” гэж өөрчилж, 17.8 дахь хэсгийн “менежмент хийх мэргэжлийн багийн зардлыг” гэснийг болон 17.9 дэх хэсгийг тус тус хасаж, 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк, цогцолбор байгуулах саналыг техник, эдийн засгийн үндэслэлийн хамт Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Ням-Осорын Учрал гишүүн, дараа нь Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Н.Учрал:** Эдийн засгийн энэ төрөлжүүлэх гол салбар бол соёлын салбар болсон байна. Тийм учраас энэ Соёлын тухай хууль гэхээсээ илүүтэйгээр Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг оруулж ирж байгааг би дэмжиж байгаа. Тэгээд энэ хууль ч бас нэлээдгүй удлаа шүү дээ Их Хурал дээр. Өмнө нь 2019 онд тухайн үед яг энэ уран бүтээлч нар нэгдээд энэ оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай хуулийн төслийг санаачлаад тэгээд би өргөн барьж байсан юм.

Тухайн үед энэ оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах хууль бол батлагдсан. Энэ хууль дээр саяын энэ зарчмын зөрүүтэй санал дээр дахин найруулах чиглэл өгсөн тэр 8 дугаар заалт буюу Оюуны өмчийн хуулийн 17.2-т заасан нөгөө дагнан байгуулсан объектын төрлийн зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн олонхыг нэгтгэсэн байна гэдэг заалт дээр бол бас анхаарах шаардлагатай гэж саналаа хэлмээр байна.

Энэ юу вэ гэхээр Оюуны өмчийн хуулиар бол хоёр агуулгыг хуульчилж өгсөн. Нэгд бол нөгөө материаллаг бус баялгийг үнэлэх анхны үнэлгээний тогтолцоог бий болгож өгсөн. Үүнийг мэргэшсэн үнэлгээчдийн байгууллага үнэлээд тэр трейд марк буюу барааны тэмдгээр, зохиогчийн эрхийн гэрчилгээгээр баталгаажсан тэр уран бүтээлийг банканд барьцаанд тавиад зээл авах, тэгээд уран бүтээлээ хийх бололцоог бол үүнээс олгосон. Үгүйгээр өнөөдөр уран бүтээлч нарын хөгжим хэрэгсэл, ширээ сандлыг нь үнэлчхээд энэ продакшн тэдэн төгрөгийн үнэлгээтэй юм, та нар олон улсад өрсөлд гэвэл энэ бол бодит үнэлгээ биш байхгүй юу.

Жишээ нь, энэ Чука ахын, энэ хөгжмийн зохиолч энэ Өлзий-Орших ах эд нарын чинь уран бүтээлийг студид байгаа тоног төхөөрөмжөөр нь үнэлээд

олон улсад өрсөлд гэж хэлэх утгагүй байхгүй юу.

Тэгэхээр зохиогчийн эрхийн гэрчилгээгээр үнэлэгдсэн дууг, дээрээс нь тэр трейд марк буюу барааны тэмдгийг нь үнэлээд тухайн компанийн дүрмийн санг л өсгөх ийм л бодлогыг Оюуны өмчийн хуулиар хийсэн. Тэгэхээр Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хууль бол энэ Оюуны өмчийн хуулийг амилуулахад тодорхой хувь нэмрээ оруулах ёстой. Тэгээд Баттөмөр гишүүний ахалсан тэр Мэргээжлийн холбооны хууль гарсантай холбогдуулаад одоо энэ хуульд заасан хамтын удирдлагын байгууллага бол мэргээжлийн холбоо болж эхэлнэ. Соёлын салбарт нэг л мэргээжлийн нэгдсэн холбоо байгуулагдана. Тэгээд тухайн мэргээжлийн холбоо өөрөө асуудлаа шийддэг, өөрөө тэр тендер, үнэлгээ хороонд нь ордог, тэр байгууллага дүгнэлтүүдээ өгдөг ийм зөв тогтолцоо руу шилжих ёстой.

Тийм учраас хамтын удирдлагын байгууллагаа мэргээжлийн нэгдсэн холбоо гэж явбал илүү хүчтэй байна гэж бас хэлмээр байгаа юм. Тэгэхээр үүнийг ажлын хэсэг бас анхаараач л гэж хэлмээр байна.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ соёлын үйлдвэрлэлийн кластерын асуудал яригдаж байгаа. Тэгээд энэ дээр тодорхой хувийн хэвшилүүдийг дэмжих тухай асуудал яригдана. Тэгээд тодорхой тодорхой ажлуудыг хийхээр заагаад энэ дээрээ тусгайлсан журмыг Засгийн газар гаргах тухай асуудал яригдаж байгаа.

Тэгэхээр би одоо манай Харангын Чука ах буюу Чулуунбат ах байна, манай гитарчин Өөжгий буюу Өлзий-Орших байна. Та 2 бас энэ дээр бас нэлээн санаануудыг сайн гаргаад, үүнийгээ бас яаж хувийн хэвчлээр дэмжүүлэх вэ гэдэг, тийм хувь уран бүтээлчдээ илүү

яаж олон нийт болон олон улсад хүргэх вэ гэдэг энэ ажлуудаа хийх санаануудыг сайн гаргаж өгсөн байна.

Тэгэхээр нэг зүйл дээр би та нарт сануулъя. Би Гадаадын харьяатын даргаар очсон чинь хоёрхон хуультай тэгсэн мөртөө 86 журамтай байсан байхгүй юу. 86 журмаараа бүх эрх мэдлийг бүгдийг нь зөвхөн дарга нар шийддэг болгочихсон байсан юм. Тийм учраас энэ Засгийн газрын журам чинь хуулиасаа давсан журамд гардаг юм шүү. Хуулиасаа давсан журамд гардаг. Тэр 86 журмаас 44-ийг нь хүчингүй болгож байж тэр байгууллага олон нийтэд нээлттэй, шуурхай үйлчилдэг байгууллага болсон юм.

Тийм учраас яг энэ дагаж гарах Засгийн газар энэ чинь бүх асуудлыг чинь зохицуулсан журмыг 17.9-өөр гаргах нь, хийх нь байна шүү дээ. Тэн дээрээ та хоёр бас анхааралтай байгаарай. Өөрсдийнхөө тэр хувь уран бүтээлчид, тэр хувийн хэвилийнхнийгээ дэмжих тал дээр тэр журам дээр нь илүү хуулиасаа давсан эрх мэдлийг авчих уу зай. Тэр дээрээ сайн анхаараарай л гэж би та хоёрт хэлье. Тэгээд энэ хуулийг бас та хоёр оролцож байгаа учраас би дэмжиж байгаа гэдгээ хэлье.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Цогтбаатар дарга сууя, Баттөмөр гишүүн суу. Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “болон” гэснийг “, эсхүл” гэж, “мэдээлэлд үндэслэн бүртгэх,” гэснийг “болон шаардлагатай бусад мэдээлэл, журамд үндэслэн бүртгэх,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

23 гишүүн дэмжиж, 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Та хоёр дуу хийх гэж байгаа бол байна шүү дээ ямар ч үг хэлэхгүй. Шуурхай 1-ээс өмнө шуурхайлъя. Тийм байна.

16.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын “үндсэн” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай “20.2.7” дахь заалт нэмэх:

“20.2.7.оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байх.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.8 дахь заалтын “чадавхыг” гэснийг “мэдлэгийг” гэж өөрчилж, 21.1.9 дэх заалтын “улс орны хөгжлийн онцлогт нийцүүлэн” гэснийг, 21.1.10 дахь заалтын “менежмент хийх” гэснийг болон “21.1.11” дэх заалтыг тус тус хасаж, “21.1.2” дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.2.энэ хуульд заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Пүүжээ тэгэхдээ өөрөө дуу хийхийг бодож байснаас Алтайн ятгыг байна шүү дээ орчин үеийн инновац хийгээд, шинэ хөгжмийн инструмент хийгээд ингээд тэрүүгээр ая тоглуулна гэж ярих ёстой. Ховдын аялгуу хийх ёстой гэж ярих ёстой.

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалтын “холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах” гэснийг “холбогдох хуулийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “үйлдвэрлэлийн” гэснийг “үйлдвэрлэлийг дэмжих” гэж өөрчилж, 24.1.3. дахь заалтын “соёлын” гэсний өмнө “энэ хуулийн 4.1-д заасан” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

20.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “эдийн” гэсний дараа “засгийн” гэж нэмж, “хөтөлбөр, төсөв” гэснийг “төлөвлөгөө” гэж, 25.1.3 дахь заалтын “ашиглуулах” гэснийг “эзэмшүүлэх” гэж өөрчилж, 25.1.1 дэх заалтын “талаарх” гэснийг болон 25.1.4 дэх заалтын “нутаг дэвсгэрт” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “эдийн” гэсний дараа “засгийн” гэж нэмж, “талаарх” гэснийг болон “, төсөв” гэснийг тус тус хасаж, 26.1.2 дахь заалтын “нутаг дэвсгэрийн” гэснийг “орон нутгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

24 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

22.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын “үйлдвэрлэлийн” гэснийг “үйлдвэрлэлийг дэмжих” гэж өөрчилж, 27.1.3. дахь заалтын “соёлын” гэсний өмнө “энэ хуулийн 4.1-д заасан” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 28 дугаар зүйлийн Гарчгийн “үйл ажиллагаан дахь тайлагнал,” гэснийг “үйл ажиллагааны”

гэж, 28.4 дэх хэсгийн “авсан” гэснийг “олгосон” гэж өөрчилж, 28.3 дахь хэсгийн “мэдээллийн” гэсний өмнө “бүртгэл,” гэж нэмж, “энэ хууль болон” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 30 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “эдгээртэй” гэснийг “эдгээр хуультай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “арга хэмжээ, журмыг” гэснийг “арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг” гэж, 9.6.1 дэх заалтын “чиглэлийн” гэснийг “чиглэлээр” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтын “хөрөнгө оруулалтад” гэснийг “хөрөнгө оруулалт” гэж, 12.2 дахь хэсгийн “бүртгэгдсэн бүтээл” гэснийг “бүтээлийг” гэж, 12.8 дахь хэсгийн “этгээд” гэснийг “этгээдэд” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “эдлүүлнэ” гэснийг “үзүүлнэ” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “хориглоогүй буюу” гэснийг “хориглоогүй,” гэж, 15.4 дэх хэсгийн “загварыг” гэснийг “загвараар” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “хүн ам” гэснийг “иргэдэд” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “, зэрэг арга хэмжээнд” гэснийг “бусад үйл ажиллагаанд” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “гадна” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болон” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалтын “системтэйгээр” гэснийг хасаж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Засгийн” гэсний дараа “газрын” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 1 дүгээр зүйлийн “системийг ашиглах” гэснийг “системийн” гэж өөрчилж, “системийн хөгжүүлэлт хийх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тийм, ер нь.

2.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар” гэснийг “3, 18 дугаар” гэж өөрчилж, “хэсэг” гэсний дараа “, заалт гэж нэмж, доор дурдсан агуулгатай “18.6” дахь хэсэг нэмэх:

“18.6.Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар

батална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тийм урын сангийн гэгчихсэн байна шүү урын сан. Хэл, найруулга дээр үүнийг харж үзээрэй.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн “12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “чиглэл” гэсний өмнө “тодорхой” гэж,” гэснийг хасаж, “33 дугаар зүйлийн” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн “Шилдэг бүтээл” гэснийг “Шилдэг уран бүтээлч болон шилдэг бүтээл” гэж” нэмж, мөн зүйлийн “50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийн “дурсгал” гэснийг “түүх соёлын дурсгалт зүйлээр” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Яг үндсэн орж байгаа зүйлд нь найруулгатайгаа 22 заалт орж байгаа юм. Бусад нь Дагаж мөрдөх журмын тухай хуулийн хамтрах юм чинь.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн “Соёлын тухай хуулийн” гэсний дараа “9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтын “уран сайхны” гэснийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлд “26 дугаар зүйлийн 26.3,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ соёлын өвийг хамгаалахтай холбоотойгоор нээрээ сая Архангай аймгийн Өгийн нуур суманд тэр олон зуун жилийн Өгийн нуур биш, Эрдэнэмандал сумын хийдийн. Аан Батцэнгэл сумын хийдийн сэргээн босголтыг Соёлын яамнаас амлалчаад хэрэгжүүлээгүй. Дээвэр нь цоороод тэр олон зуун жилийн түүхтэй сүм хийд соёлын дурсгалт өвүүд устах аюулд орлоо гээд.

Бас Шанхайн хийдийн асуудлаар манай Өвөрхангайн гишүүд болон бид нар Соёлын яаманд бичиг хүргүүлсэн. Тэнд чинь хосгүй үнэт зүйлүүд хадгалагдаж байгаа шүү дээ. Зарим нь тэр Италийн мэргэжилтнүүд ирээд энийг хүний гараар бүтээчихсэн гэхэд итгэмээргүй юм байна. Юун Леонардо да Винчи, ийм гайхамшигтай бүтээл ийм газар байхад гээд шогшироод буцчихаж. Тэр Шанхын хийдэд хосгүй үнэт олон дурсгалт зүйл хадгалагдаж байгаа. Тэрний харуул хамгаалалт, хадгалалт, орчин нөхцөл гэж ерөөсөө.

4.Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар. 1.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 3 дугаар зүйлийн “хассугай” гэсний өмнө “тус тус” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Дараа нь хэлчих. Энэ санал хураалт явчихлаа. Тус тус хассугай л гэж нэмэх юм байна. Найруулгын шинж чанартай юм байна.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “15.1.15” гэснийг “15.1.16” гэж өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

15.1.16.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор албан татвар ногдох орлогын 5 хувиас хэтрэхгүйгээр өгсөн хандив. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт явуулахгүй. Цохиогүй. Гочоогийн Ганболд гишүүн үг хэлнэ.

**Г.Ганболд:** Нэг үг хэлье дээ. Би хоцорчихлоо. Номин сайдаа энэ эцсийн найруулга дээр нь бас анхаарах хэрэгтэй байх гэж бодож байх юм. Энэ 18.6 дээр төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар.

Тэгэхээр чинь энэ хэдэн музей энэ театр урлагийн байгууллага чинь удирдах зөвлөл гээд юм заавал байх юм байна. Ер нь ингээд би харах юм бол энэ Удирдах зөвлөл бол бараг дэмжлэг болохоосоо илүү тээг садаа байна шүү дээ. Бид нар энэ үндэсний олон нийтийн зөвлөл, тэр удирдах зөвлөл гээд л ерөөсөө дэмжлэг үзүүлэхээсээ илүүтэй юм шахдаг, тэгээд л ерөөсөө тэр байгууллагын үйл ажиллагаанд нь оролцдог, тэгээд л эсвэл ерөөсөө гацаа үүсгэдэг. Тэгэхээр энэ байгууллага болгон дээр нь ийм юм орох гээд байна уу? Соёлын бүх байгууллагууд дээр юм уу, юун дээр орох гээд байгаа юм? Үүнийг

бас тэгээд яах вэ нэгэнт хариулахгүй байх л даа. Үүнийг анхаарахгүй бол.

Миний ойлгож байгаагаар энэ төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага гэхээр чинь бүгд л орно шүү дээ. Тэгэхээр энэ нь бол бүгдэд нь удирдах зөвлөл байна гэвэл явахгүй. Тэгээд үүнийг анхаарна биз л гэж хэлэх гэсэн юм.

**Г.Занданшатар:** Үүнийг сайн тодорхойлохгүйн бол нээрээ сумын соёлын төв удирдах зөвлөлд явах уу гээд л асуудал гарч ирнэ шүү дээ. Санал хураалт явуулна. Гишүүд суугаарай. Жаргалмаа гишүүн суугаарай, Одонтуяа гишүүн суудал суу. Санал хураалт.

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 1 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “нүүр” гэсний дараа “болон” гэж нэмж, “талд үндэсний агуулга, хэлбэр, дүр төрхийг илэрхийлсэн үзэл баримтлал,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “22.5.11, 22.5.12” гэснийг “22.5.20” гэж өөрчилж, “хөнгөлнө” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдсэн.

Болдын Жавхлан гишүүн үг хэлнэ.

**Б.Жавхлан:** Хууль санаачлагчаас, Засгийн газрын гишүүнээс асууя. Номин сайдаа энэ чинь буцааж татсан юмнууд чинь буцаад ороод ирсэн юм уу? Айн энэ юун санал юм?

**Г.Занданшатар:** Асуулт, хариулт байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй санал хэлнэ.

**Б.Жавхлан:** Үгүй энэ ерөөсөө болохгүй юм болоод ороод ирчихжээ. Энэ хууль өөрөө орж ирэхдээ нэлээн мафаантай орж ирсэн юм. Засгийн газраас өргөн баригдах үед Засгийн газар дээр яг яригдсан, эцэслэж яригдсан хувилбараараа биш өргөн баригдах хооронд өөрчлөлт орчихсон. Тийм нэлээн олон заалтууд яваад байсан. Уг нь хассан, буцааж авсан гээд байсан тэр заалтууд нь буцаад ороод ирсэн байна шүү дээ. Үүнийг дахиж эргэж харья Их Хурлын даргаа. Энийг буцаая. Энэ ерөөсөө огт болохгүй. Улсын Их Хурал дээрээс ажлын хэсэг гаргаж энэ яг Засгийн газраас яг гарсан хувилбар, өргөн баригдсан хувилбарыг эргэж хянахгүй бол ийм байдлаар ингэж цаашаа явж болохгүй шүү Номин сайдаа.

**Г.Занданшатар:** Үгүй үгүй энэ юу. Гааль, НӨАТ-ын тухай хуулиуд нь буцааж татагдсан. Тэр нь хэлэлцэгдээгүй юм. Энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль бол энэ хандив өгнө гэсэн заалт байгаа. 100 сая хүртэл төгрөгийн хандив гэсэн заалтыг л хэтрэхгүй гэж өөрчилж байгаа юм байна лээ. Ингээд дэмжигдчихсэн. Тийм хөнгөлнө гэсэн.

Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулчихсан.

Одоо Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 болон 2 дугаар зүйлийн “16.1.17” гэснийг “16.1.19” гэж, 2 дугаар зүйлийн “заалтын” гэснийг



“хэсгийн” гэж, “16.1.16” гэснийг “16.1.18” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төслийн 1 болон 2 дугаар зүйлийн “38.1.21” гэснийг “38.1.23” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ заалт нь өөрчлөгдсөн юм байна Жавхлан сайдаа ийм агуулгатай байхгүй юу. Монгол Улсад бүтээх боломжгүй том хэмжээний уран баримал, урлагийн бүтээлийг болон гадаад улсаас Монгол Улсад авчрах соёлын өвийн хуулбар гэсэн энэ заалтынх нь хуучин хуульд байсан заалт нь, дугаарлалт нь өөрчлөгдчихсөн юм байна. 38.1.21 гэж байсан нь 38.1.23 болчихсон юм байна. Тэгээд л тэр нь л өөрчилж байгаа юм. Санал хураалт.

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Соёл, урлагийг дэмжих сан” гэснийг “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан” гэж өөрчилж, 13.3.5 дахь заалтын “арга хэмжээнд оролцуулах,” гэснийг, 13.3.7 дахь заалтын “онцгой” гэснийг, “13.4” дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 9.14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмэх:

“3.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох, хянах, хэрэглэгчийн статистик мэдээлэлд үндэслэн хязгаарлалт тогтоохтой холбоотой журмыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 9.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “6.10 дугаар зүйлийн” гэснийг “1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.46 дахь заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “үүсвэрээс” гэсний дараа “болон гадаадын киног Монгол Улсад гаргасны ашигийн 2 хувиас” гэж нэмсүгэй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.**

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**12. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

**1. Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.**

69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

**Төслийн гарчгийн “, өөрчлөлт” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**2 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2 дахь хэсгийн “34.27” гэсний дараа “, 34.28” гэж нэмсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.**

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бусад хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

**Хууль төслийг хуулийн төсөл санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэгт. Санал хураалт.**

**Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

**1. Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмж, төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйл болгон өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**1 дүгээр зүйл. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалтын “аргачлалыг” гэсний дараа “соёлын болон” гэж нэмсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг.**

**Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 3 минут үг хэлнэ.**

**Б.Бат-Эрдэнэ:** Тийм, баярлалаа. Би уг нь тэр Хүний нөөц, боловсон хүчний асуудал дээр үг авах гэж байсан юм. Тэгээд яах вэ би юу хэлэх гээд байгаа вэ гэхээр зэрэг энэ Соёлын яам, Боловсролын яам жаахан анхаармаар юм байгаад байна. Яагаад гэвэл энэ хүний нөөц, боловсон хүчинтэй холбоотой юман дээр жаал анхаарахгүй бол энэ чинь СУИС бусад энэ соёлын сургуулиар сурч байгаа хүүхдүүдийн дунд дээрэлхэл, гадуурхалт гээд ийм асуудлууд яригдаад байна шүү дээ. Тэгэхээр ерөөсөө бол энэ чинь харьцаа хандлага, ялангуяа энэ эерэг хандлага, нөлөөллийн ажлыг бол биеийн тамир, ер нь бүх салбар тэр тусмаа эрүүл мэнд, биеийн тамир, спорт, соёлын салбарынхан энэ дээр ихээхэн анхаарах хэрэгтэй байхгүй юу даа. Тэгэхгүй бол мэндлэх монголчуудын мөнхийн ёс байдаг.

Гэтэл ерөөсөө хүн хүнтэйгээ мэндлэх, мэндлэхгүй болохоор чинь харьцаа үүсэхгүй, итгэл байхгүй. Энэ чинь хайр, хүндлэл хамгийн чухал байна шүү дээ. Тийм учраас ийм юман дээрээ жаахан анхаарахгүй бол ингээд бид нар ...Монголиа гээд ийм том хөтөлбөр, аялал жуулчлалын юм ярьж байдаг. Тэгээд л харьцаа, хандлагын асуудал муу. Бидэн шиг жишээлэх юм бол ийм харьцаа хандлагын хувьд ингээд уламжлалаа орхичихсон дэлхийн хүн төрөлхтний жишгээс ер нь нэлээн хоцрогдонгүй явж

байгаа ийм улс орон гэж хэцүү шүү дээ. Тэгээд яах вэ ер нь учир, шалтгаан нь энэ дээр байж байгаа улсуудаас л эхэлсэн ажил. Би бас удаа дараа хэлдэг энэ Их Хурал дээр энэ Төрийн ордны энэ өргөн коридороор чинь ер нь хүн хүнтэйгээ мэндэлдэг улс их цөөхөн байдаг юм шүү дээ. Тийм учраас ийм юман дээр эерэг нөлөөллийн ажлыг гол үүргийг гүйцэтгэх ийм ажил дээр манай Соёлын яам нэлээн манлайлж оролцооор, Боловсролын яам Энх-Амгалан сайдтай бид олон удаа л ярьж байгаа юм. Ийм юман дээрээ анхаарах хэрэгтэй байна гэж. Хууль, эрх зүйн зохицуулалтын хувьд ямар боломж байдаг юм байгаа юм? Өөр юмгүй.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулна. Үг хэлсэн. Даваасүрэн гишүүн суудалдаа. Тогтохсүрэн дарга, Учрал гишүүн хоёр суудалдаа санал хураалт. Баделхан гишүүн суудалдаа суу, Тогтохсүрэн дарга, Учрал гишүүн суудалдаа. Санал хураалт.

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Кино үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1 санал үлдсэн байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “байгууллагатай” гэсний өмнө “төв” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураая.

22 гишүүн дэмжиж, 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан,

спортын байнгын хороонд шилжүүлж байна.

Түүрүүн бас гишүүд хэлээд байсан юм өдий үед байна шүү дээ хууль хэлэлцэх маш хүнд байдаг. Өмнөх парламент ямар байсан юм гэхээр ингэж хурууны хээгээр бүртгүүлдэггүй, хурууны хээгээр санал өгдөггүй байсан учраас төгөлдөр хуурдах гэдэг нэр томъёотой. Тэгээд 7 гишүүн сууж байгаад л хууль баталчихдаг, ирц бүрдүүлчихдэг байсан жишээнүүд байдаг юм байна лээ. Өдий үед бүүр цөөн. Тэр битгий хэл Тамгын газрынхан рекорд тогтоочихсон хүмүүсийг харж байсан. 10 секундэд нь амжиж хамгийн олон кноп дарж, 1 гишүүн 9 гишүүний кнопкиг дарж рекорд эвдсэн нь тухайн үедээ хамгийн өндөр болж байсан байхгүй юу. Одоо бол тийм юм байхгүй болчихсон учраас хууль бол байна шүү дээ, мандуулж байгаа юм бишээ Одонтуяа гишүүн ... хэлж байгаа юм. Тэр үед тэгж бодуулж байсныг чинь харин одоо ингээд ийм хэцүү болчихсон байхгүй юу. Дараагийн асуудалд орно.

12.41 цаг

**“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалт. Хөөе Амартүвшин гишүүнээ Хүний эрхийн санал хураалт явуулна. Хүний эрхийн тогтоол. Энх-Амгалан гишүүн, санал хураалт.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж,

хариулт авч, уг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Учрал гишүүн суугаарай санал хураалт явууллаа шүү. Санал хураалт.

59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Дараагийн асуудалд орно.

12.43 цаг

**Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Хянан шалгах түр хорооны тайлан болон санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, хянан шалгах түр хорооны дарга Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Ж.Чинбүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 60 дугаар тогтоолоор байгуулагдсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хороо 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хуралдаж хянан шалгах түр хорооны тайлан гаргасныг та бүхэнд танилцуулж байна.

Түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн миний бие, гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Батлут, Бейсен, Жаргалмаа, Оюунчимэг, Сандаг-Очир, Туваан нар ажиллалаа.

Улсын Их Хурлын Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооноос нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг 2024 оны 4 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгууллаа. Энэ нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хэрэгжсэнээс хойших 3 дахь удаагийн сонсгол юм.

Түр хороонд иргэдээс эмийн үнэ, чанарын асуудлаар болон төрийн хүнд суртлын талаар олон баримт, мэдээлэл цугларсан нь нийт 1164 албан тушаалтанд хамаарах 6200 нотлох баримт, 153 мянган ширхэг цаасан баримт, 85 мянган цахим файл болсон. Мөн нотлох баримт цуглуулах хүрээнд 150 орчим хүнтэй фокус ярилцлага хийж, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн шинжлэх лаборатори, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын гаалийн газар болон Техник, импортын эмийн агуулах, Говь-Алтай аймгийн эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, эмнэлгийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалж буй агуулахын нөхцөл байдал, Гаалийн ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх Гаалийн газар болон Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар, Алтанбулаг боомтын үйл ажиллагааг газар дээр нь очиж танилцаж эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх хилийн болон гаалийн хяналтын ажилтай танилцлаа.

Хянан шалгах түр хорооноос баталсан нотлох баримт гаргуулах тухай 2023 оны 3 дугаар тогтоолын хүрээнд нотлох баримтууд цуглуулах, хяналт шалгалт, дүн шинжилгээ хийж,

дүгнэлт гаргуулахаар хянан шалгагчаар Чойжамц Хүний их эмч, эм судлаач, анагаах ухааны доктор, профессор, Саруул Үндэсний аудитын газрын менежер, Саруултөгс их эмч, Пүрэвдорж цагдаагийн хурандаа, шинжээчээр Оргилмаа Монголбанкны улсын байцаагч, Батхүү Монгол улсын их сургуулийн Биологийн хүрээлэн, Биологи, био технологийн сургууль, дэд захирал, профессор, Аз Шинэ сэргэлтийн бодлого, Хурдасгуур төв Улсын төсөвт үйлчилгээний газрын Ногоон бүтээмж, хөгжлийн бодлогын газрын дарга, Гарагсайхан цагдаагийн ахмад, Хаш-Эрдэнэ эрх зүйч, дата аналитист Энхбат, сэтгүүлч Хонгор нарыг 11 хянан шалгагч шинжээчийг томилон ажиллууллаа.

Сонсголд ажиглагчаар Монголын эрдэмтдийн үндэсний зөвлөлийн тэргүүн Оюунбилиг, Япон улсын Каназава Үндэсний их сургуулийн Анагаах ухааны сургууль-Үүдэл эс, дархлаа судлалын тэнхимийн профессор Нямбаяр нар оролцлоо.

Мөн урилгаар Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг хууль хяналтын байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний аудитын газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Цахим хөгжил, харилцаа холбооны болон Эрүүл мэндийн яам, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн газар зэрэг төрийн байгууллагын төлөөлөгчид сонсголд оролцлоо.

Сонсголыг эмийн хүртээмж, үнийн өсөлтийн шалтгаан нөхцөл, эмийн бүртгэл, хяналт гэсэн үндсэн 3 сэдвийн хүрээнд нийт 32 асуудлаар явуулж, мэдэгдэх хуудас хүргүүлсэн нийт 119 гэрчээс 83.2 хувийг оролцуулж, тайлбар мэдээлэл сонссон болно.

Тухайлбал, 2024 оны 4 дүгээр сарын 15-ны эхний өдрийн сонсголоор

эмийн хүртээмжийн асуудлыг шинжлэн судлав. Үүний хүрээнд хүртээмж, эмийн үнэ, чанарын талаар иргэд, эмчлүүлэгчдийн төлөөллийг оролцуулан гэрчийн мэдүүлэг авсан нь төр иргэдийн оролцоог ханган тэдний дуу хоолойг сонссон нь сонсголын онцлог боллоо.

Нотлох баримтыг шинжлэн судлах сонсголоор эм зүйн салбарын ерөнхий мэдээллийг шинжээчид танилцуулж, хүртээмж, үнэ болон эмийн чанарын талаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлалын олдмол хомсдол болон бэлгийн замын халдварт өвчин халдварын тандалт, судлалын албаны дарга, Мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн Даваалхам оролцож, олон нийтэд ил гарч, өөрсдийн үг хэлэх эрхээ эдлэх боломжгүй иргэдийг төлөөлж үг хэлсэн. Нийгэмд үйлчлэх “Наран ижий заяа” ТББ-ын тэргүүн Ариунаа, Хавдрын өвчнийг даван туулагчдыг төлөөлж “Элэгний Б, Д вирусийн тэмцэгчид” ТББ-ын тэргүүн Дэлгэрмаа, Б, Д вирус тэй иргэдийн төлөөлөл Буянтогтох, “Эрхтэн шилжүүлэн суулгагчдын холбоо” ТББ-ын тэргүүн Өлзийбаяр, Уналт таталттай өвчтийн төлөөлөл Хонгор, Чихрийн шижинтэй өвчтөнүүдийн төлөөлөл Жаргалсайхан нар тайлбар өглөө.

Сонсголд оролцсон архаг хууч өвчтэй иргэдийн төлөөлөл төр шаардлагатай эмийн бүртгэлийг хийхгүй байна гэж шүүмжиллээ. Тухайлбал, уналт таталттай өвчтэй иргэдийг төлөөлж Хонгор би 27 жил уналт таталтын өвчнөөр өвчилж байна. Солонгос улсаас сентиклобозам эмийг 7 жил авч ууж байна. Монгол Улсын эмийн бүртгэлд, жагсаалтад ороогүй, харин хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон. Тиймээс үүнийг эмийн сангаар авах боломжгүй байна гэсэн зүйлийг ярилаа. Яаралтай үед тариа хийх болдог. Гэтэл сентиклобозам ганц эм л байдаг. “Монос” фарм оруулж ирсэн ч Монгол Улсад бүртгэлгүй учир эмийн сангуудаас худалдан авах боломжгүй байна гэсэн

байна. “Элэгний В, С вирустэй тэмцэгч” ТББ-ын тэргүүн Дэлгэрмаа элэг хамгаалах Видика Ниссел эмийг хөнгөлөлттэй эмийн жагсаалтад хамруулж өгөхийг хүслээ. Эрхтэн шилжүүлэн суулгагчдын холбооны гишүүн Өлзийбаяр Монгол Улсад импортын эм 4.5-6.5 дахин их үнэтэй байгааг шүүмжиллээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах сонсголыг телевиз, сайтаар шууд дамжуулан хүргэж, иргэд бодит мэдээллийг үзэн сонсон олон нийтийн мэдэх эрхийг ханган ажиглах үүргээ амжилттай гүйцэтгэлээ.

3 өдрийн турш үргэлжилсэн сонсголд Хянан шалгах түр хорооны гишүүд 100 хувийн ирцтэй идэвхтэй оролцож, эмийн үнийн өсөлт, хүртээмж, тулгамдсан асуудлаар асуулт тавьж, гэрч, хянан шалгагч, албаны хүмүүсээс хариулт авч, гарц шийдэл хайлаа.

Энэ сонсгол бол Монгол Улсын Засгийн газрын явуулж байгаа “5 Ш” ажиллагааны үргэлжлэл боллоо. Бид танил тал, сайд, дарга гэлгүй эм хангамжийн тогтолцооны идээ бээрийг шахаж, нөхцөл байдал ямар байгааг ард иргэддээ ойлгуулж, болохгүй, бүтэхгүй байгаа бүхнийг үүд хаалгыг хаахын төлөө ажилласан болно.

Бид өнөөдөр Монголдоо өвчин зовлонгоо эмчилж чаддаг, эм нь чанартай байж ард иргэд маань өвчнөөс болж ядуурахгүй байх тогтолцоог бүрдүүлэх том алхмын эхлэлийг тавьж, энэ үйл хэргийн гэрчүүд боллоо гэж дүгнэж байна.

Сонсголоор тэр бүхэн өргөс авсан мэт эдгэрчихгүй ч гэлээ томоохон өөрчлөлтүүд гарна гэдэгт итгэлтэй байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь холбогдох хуулийн дагуу цуглуулсан нотлох баримтад үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Эмийн хүртээмжийн асуудлаар

1. Манай улсын хувьд 2023 оны байдлаар нийт 4213 бүртгэлтэй эм байгаа бөгөөд үүний 79 хувийг импортын, 21 хувийг Үндэсний үйлдвэрийн эм байна. Импортын эмийн хувьд 2018 онд 3.2 сая кг эм импортолж байсан бол 2022 онд 8.6 сая болж өссөн байна. Мөнгөн дүнгээр авч үзвэл 2018 онд 232 тэрбум төгрөг, 2022 онд 447 тэрбум төгрөг болтол өссөн байна. 23 оны байдлаар 468 тэрбум төгрөгийн эмийг импортоор авсан бөгөөд 20-21 онд 1.6 дахин өсөж, түүнээс хойш тогтмол өсөлттэй байгаа юм байна.

Эмийн сангийн хувьд 2018 онд 2128 эмийн сан байсан бол 2023 онд 2857 болж өссөн бөгөөд Улаанбаатар хотын хувьд 2021 онд 1325 байсан бол 2023 онд 1754 болон өссөн байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын мянган хүнд 1 эмийн сан ноогдож байгаа бөгөөд энэ Стандартчилал, хэмжил зүйн тухай хуулиар 500 метр дотор 1 эмийн сан байна гэдэг зохицуулалт хасагдсантай холбоотойгоор эмийн сангийн тоо нэмэгдэх үндэслэл болсон байна.

2. Зайлиггүй шаардлагатай эмийн жагсаалт боловсруулах журам арга, аргачлал байхгүй учир жагсаалт батлах бүрдээ эм нэмэх шалгуурт өөрчлөлт оруулах, жагсаалтын шалгуураас хэдийг хангаж байж жагсаалтад эм орох ёстой нь тодорхой бус байна.

3. Эмчилгээ, оношилгооны эмнэл зүйн удирдамж зааврыг тогтмол шинэчлэн баталдаггүй. Бүртгэлгүй эмийг

бүртгэж, эмчилгээ оношилгоонд ашиглах бодлого хэрэгждэггүй ажилласаар байна.

4.Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл нь тухайн жилийнхээ үйл ажиллагаатай холбоотой архивын нэгжээ Эрүүл мэндийн яаманд хүлээлгэн өгөөгүй байна. Иймээс сонсголд зайлшгүй шаардлагатай эмийн 8, 9 дүгээр жагсаалтыг боловсруулсан ажлын хэсгийн мэдээлэл, хурлын тэмдэглэл, эм нэмэх, хасах саналууд зэрэг нотлох баримтууд ирээгүй учир тухайн жагсаалтад албан тушаалтнууд хэрхэн нөлөөлсөн, аж ахуйн нэгжүүдтэй хамааралтай эсэх, ашиг сонирхлын зөрчлийг тогтоох боломжгүй байсан байна.

5.Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 24 дүгээр тогтоолд эм сонгох Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөх, хувь тогтоох арга, аргачлал байгаагүй. Тогтоолууд буюу ерөнхий нэршилд хамаарах бүх худалдааны нэршлийн эмийг хөнгөлөлттэй эмийн жагсаалтад оруулдаг, батлагдсан хөнгөлөлттэй эмийн жагсаалтын ерөнхий нэршилд хамаарах худалдааны нэршлийн эмийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар нэмж оруулдаг байна.

6.Хөнгөлөлттэй эмийн үнийн дээд хязгаарт ижил бус өөрчлөлт орж байна.

7.Яаралтай горимоор бүртгэлгүй, уналт таталтын эсрэг 44 нэр төрлийн эмийн импортын лицензэд уналт, таталтын эсрэг эмийн ангилалд багтаагүй, таталтын эсрэг үйлчлэлгүй, заалтгүй Эл-карнитин эмийг оруулж импортын лиценз олгосон байна.

8.Хүний эмийн зөвлөлийн хурлаар орж Эрүүл мэндийн сайдын тушаалаар эм, эмийн түүхий биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн журмын 1.8 дахь хэсгийг зөрчиж бүртгэгдсэн 17 ерөнхий нэршлийн 217 худалдааны эм

хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон байна.

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийн талаар дараах дүгнэлт гаргаж байна.

9.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь хамаарал бүхий этгээд гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч эхнэр, нөхрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг, 3.1.6.Нэгдмэл сонирхолтой этгээд гэж тухайн нийтийн албан тушаалтанд ашигийн төлөө үйл ажиллагаатайгаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг, 3.1.11.Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл, байдал гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг гэж тус тус зааснаар нийтийн албан тушаалтан нь албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж эс үгүй бол зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох эрсдэлийг тодорхойлох зорилгоор эм хангамжийн байгууллага дахь төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудын хамруулж Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн нотлох баримтад үндэслэн танилцуулсан.

Тухайлбал, Эрүүл мэндийн яаманд 2018-2023 онд ажиллаж байсан болон ажиллаж байгаа давхардсан тоогоор нийт 110 албан тушаалтны хамрагдсанаас 97 албан тушаалтан буюу

88.1 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнээр ажилласан болон зайлиггүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалтыг баталсан нийт 28 албан тушаалтан давхардсан тоогоор хамрагдсанаас 35 буюу 100 хувь нь хамаарал бүхий, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 42 албан тушаалтан хамрагдсанаас 41 буюу 97.6 хувь нь эм хангамжийн байгууллагын хамаарал бүхий, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 93 албан тушаалтан хамрагдсанаас 57 буюу 61.2 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий байна. Хүний эмийн зөвлөл, түүний салбар зөвлөл болох Эм зүйн салбар зөвлөл, Эм судлалын салбар зөвлөл, Био бэлдмэл, оношлуурын салбар зөвлөл, Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөл, Фармакопейн хороо болон эмийн бүртгэлийн шинжээчээр ажиллаж байсан болон ажиллаж байгаа давхардсан тоогоор 321 албан тушаалтны хамрагдсанаас 241 албан тушаалтан буюу 75 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий байсан байна.

Эрүүл мэндийн яамнаас 2018-21 онд эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх болон ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг олгох, ажилласан тусгай зөвшөөрлийн комиссын гишүүн болон шинжээчээр ажиллаж байсан 50 албан тушаалтан хамрагдсанаас 32 албан тушаалтан буюу 64 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас 21, 23 онд эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх болон ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг олгож ажилласан Тусгай зөвшөөрлийн комиссын гишүүн болон шинжээчээр ажиллаж байсан болон ажиллаж байгаа 31 албан тушаалтан хамрагдсанаас 28 албан тушаалтан буюу 90 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий байсан.

Гаалийн ерөнхий газрын 41 албан тушаалтан хамрагдсанаас 14 албан тушаалтан болон 34.1 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий, Нийслэлийн эрүүл мэндийн газар 51 албан тушаалтан хамрагдсанаас 18 албан тушаалтан буюу 31 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий, Төрийн худалдан авах ажиллагааны газрын 34 албан тушаалтан хамрагдсанаас 8 албан тушаалтан буюу 23.5 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий, аймгийн Эрүүл мэндийн төвүүд дэх 146 албан тушаалтан хамрагдсанаас 36 албан тушаалтан буюу 24.6 хувь нь эм хангамжийн байгууллагатай хамаарал бүхий албан тушаалтан байна гэж тус тус үзэхээр байна.

Хянан шалгах түр хорооны цуглуулсан холбогдох нотлох баримтыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн төрийн байгууллага дахь эм хангамжийн байгууллагын хамаарал эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд үүссэн байж болзошгүй ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг холбогдох хуулийн дагуу шалган иргэд, олон нийтэд нээлттэй мэдээллэхийг Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгасан болно.

10-т, зайлиггүй шаардлагатай эмийн өсөлтийн суурь шалтгаан нь валютын ханишийн өөрчлөлт, КОВИД-ын үеийн худалдан авалттай холбоотой байна. КОВИД-ын үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллагуудын борлуулалтын орлого 2-3 дахин, зарим байгууллагын цэвэр ашиг 4-5 дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн эм ханган нийлүүлэх байгууллагуудын борлуулалт, маркетингийн зардал, өсөлт анхаарал татахуйц өндөр байна.

11.Онцгой эрхт гэрээ байгууллагууд тэр нь 1-40 жил цаашилаад хугацаагүй байдлаар сунгаад явах нь



өөрөө давамгайл байдлтай аж ахуй эрхлэгч, зүй ёсны монопол болж байгаа эсэхийг тогтоодог байх нөхцөл, хэрэгцээ шаардлагыг үүсгэж байна. Иймээс онцгой эрх буюу эксклюзив гэрээг зохицуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

12.Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагад хэрэглээндээ тохирсон худалдан авалт хийгээгүйгээс эм хангамжийн байгууллагууд төлөх их хэмжээний өглөг үүсгэсэн байна. Өр үүсгэх болсон үндсэн шалтгаан нь тендерийг хүчингүй болгох буюу худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг амжилтгүй зохион байгуулах замаар шууд худалдан авалтыг хийдэгтэй холбоотой байна.

Эмийн бүртгэл болон чанарын хяналтын асуудлаар.

13 дахь дүгнэлт. Эмийн бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгаагүй тохиолдолд цаашид төрөөс эмийн зах зээлийг зохицуулах боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, эмийн хяналт, зохицуулалтын нэгдсэн цахим тогтолцоо бүрэн бүрэлдээгүйгээс эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэгдсэн цахим тогтолцоогоор хянах зохицуулахад хүндрэл учирч байна.

14.Лайс мед сайтын системийн аюулгүй байдлыг тодорхойлох зорилгоор мэргэжлийн байгууллагаар мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэж ажилласан. Тус системийн ашиглалтыг харууцдаг Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт сүлжээний хамгаалалтын төхөөрөмж буюу файрвол суурилуулаагүй. Энэ нь сүлжээгээр байгууллагын хэрэглэгч рүү чиглэсэн халдлага хийх боломжтой, халдлага болон түүнийг илрүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байгаа нь харамсалтай байна.

15.Систем хэрэглэгч нь төвлөрсөн хэрэглэгчийн удирдлагагүй, хяналтгүй, интернэт сүлжээнд холбогдсон хортой кодын эсрэг программ суурилагдаагүй үйлдлийн систем нь лицензгүй байгаа нь байгууллагын дотоод мэдээлэл алдах, халдлагад өртсөнөө тодорхойлох боломжгүй байна.

16.Өгөгдлийн сангийн эрхийн нэр, нууц үгийг солих боломжгүй, серверт веб системээр дамжилгүйгээр өгөгдлийн санд засвар хийх, лог мэдээлэлд засвар оруулах эрсдэлтэй өгөгдлийн сангийн хамгийн том эрхийн нэр, нууц үгийн хэдэн хүн мэдсэн, мэдэж байгаа нь тодорхойгүй байна.

17.Өгөгдлийн сан, серверийн түвшинд тодорхой хэмжээнд бүртгэл хадгалагдагч системийн эмзэг байдлуудыг ашиглан логуудыг устгах бүрэн боломжтой зэрэг олон сул тал эрсдэл тогтоогдлоо.

18.Эмийн чанарыг шинжлэх лаборатори нь хүчин чадал, хүний нөөц хангалтгүй, эмнэл зүйн судалгаа буюу био эквивалентын шинжилгээ хийдэггүй, эмнэл зүйн удирдамжийг шинэчлэх шаардлагатай эмийн цувралын судалгаа шинжилгээ хийдэггүй зэрэг олон асуудлууд бугшижээ.

Цаашид тус лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, харьяаллын асуудлыг шийдвэрлэх зайлигүй шаардлагатай байна.

19.Монгол улсын эмийн зохицуулалтын төлөвшилтийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2022 онд үнэлсэн үнэлгээг 4 түвшинээс 1 дүгээр түвшинд үнэлэгдсэн бөгөөд системтэй зохицуулалт байхгүй гэж үнэлсэн хамгийн муу дүн авчээ.

20.Эмийн талаар баримтлах төрийн бодлогын баримт бичиг байхгүй, эрх зүйн орчныг боловсронгуй болгох,

хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалтыг сайжруулах, холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хийх зайлиггүй шаардлагатай байна.

Тухайлбал, тогтолцооны байгууллагуудын чиг үүрэг, эрх хэмжээ нарийвчлан зохицуулагдаагүй Хүний эмийн зөвлөл жишээлбэл, зарим үйл ажиллагаа, процедур шалгуурууд, нарийвчлан зохицуулагдаагүй эмийн бүртгэл хийх, зайлиггүй шаардлагатай эмийн жагсаалт, Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох эмийн жагсаалт батлах гэх мэт. Онцгой эрхт гэрээ, эм хангамжийн байгууллага, эмийн сан, үйлдвэрийн үйл ажиллагааг хамаарал бүхий хуулийн этгээдүүд эрхэлж байгаа асуудлаар эрх зүйн харилцаа зохицуулалт хангалтгүй байгаа зэрэг асуудлууд байна гэж дүгнэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хянан шалгах түр хорооноос дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд эмийн үнийн.../минут дуусав./

**Г.Занданшатар:** 20 минутад багтааж илтгэл тавих ёстой индэрт. Гүйцээгээд, нэмээд 1 минут.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Тэгээд одоо та бүхэнд хүргүүлсэн байгаа тогтоолын төсөл та бүхэнд очсон байгаа. Энэ тогтоолын төсөлд нийтдээ үндсэн 2, задаргаагаар нийтдээ 14 зүйл, заалтууд Засгийн газарт үүрэг болгож өгөх гэж байгаа.

Тийм учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн тогтоолын төслийг дэмжиж, санал хураалтад идэвхтэй оролцоно уу.

Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Түр хорооны санал, дүгнэлт, тогтоолын төсөл, Байнгын хорооны саналтай

холбогдуулан асуулт асуух, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу?

Тэмүүлэн гишүүнээр санал. Ням-Осорын Учрал гишүүн, Сарангэрэл гишүүнийг нэмье. Сайд үг хэлэхгүй.

**Н.Учрал:** Эмийн түр хороо ажлаа бас хариуцлагатай хийлээ гэж бас дүгнэж байгаа. Тэгэхээр ард түмний анхаарлын төвд байсан гол сэдэв. Тэгээд Монголд эмч нарын чадвар биш эмийн чанар дутагдаж байна гэдгийг энэ сонсголоос тодорхой харагдсан. Тэгэхээр Чинбүрэн гишүүнээс бас нэг зүйлийг асуумаар байна. Их Хурлын тогтоол дээр, 4 дээр Лайс мед системийн тоног төхөөрөмжийн хамгаалалтыг нэмэгдүүлж, аюулгүй байдлыг хангах, сайжруулах чиглэлээр Цахим хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам, Гаалийн ерөнхий газарт үүрэг өгч байгаа юм байна.

Лайс мед системийн талаар бид мэднэ. 2015 оноос хойш Дэлхийн банкны энэ цахим эрүүл мэнд төсөл хэрэгжээд бараг энэ чинь 18 сая долларын төсөл байх шүү. Төсөл хэрэгжээд ард түмэн үр ашгийг нь хүртээгүй, эрүүл мэндийн салбар цахимжаагүй, энэ олон хувийн эмнэлгүүд, төрийн эмнэлгүүд хоорондоо мэдээлэл солилцож чадаагүй.

Гэхдээ анхан шатын эмнэлгүүд бол дотроо өөр өөрийн системтэй байсан уу гэвэл байсан. Эмийн жорыг цахим дээр бүртгэдэг байсан уу гэвэл байсан. Гэхдээ тэр жор нь бусад аптекуудтайгаа холбогдож байсан уу гэвэл бас үгүй. Тэгэхээр хувийн эмнэлгүүд, улсын эмнэлгүүд хоорондоо мэдээлэл солилцож чаддаггүй байсан шалтгаан бол энэ цахим эрүүл мэнд төслийн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтээр гарсан энэ байгууллага чинь ажлаа хангалтгүй хийсэн гэдэг дүгнэлтийг шууд харж болно. Нэг ёсондоо бол энэ Лайс мед чинь удахгүй амьдралд хэрэгжээд эхэлнэ, эмнэлгүүд чинь мэдээллээ солилцоно гэж

хэлсээр он жил өнгөрсөн. Ингээд энэ эрүүл мэндийн цахимжилт бол гацсан.

Тэгээд Дэлхийн банкны зүгээс хангалтгүй гэж дүгнэлт өгсөн учраас зогсоосон. Сая Засгийн газар дээр шийдвэр гаргаад энэ Цахим эрүүл мэнд төсөлтэй холбогдуулаад эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудыг шалгая гээд Авлигатай тэмцэх газарт ишлжүүлчихсэн. Тэгээд аргаа бараад Засгийн газар дээр Ерөнхий сайдын захирамжаар миний бие ахлаад Эрүүл мэндийн сайд Чинзориг сайд болон холбогдох албан тушаалтнууд ороод бид 800 гаруй хувийн эмнэлгүүд, төрийн эмнэлгүүдийн мэдээлэл солилцох боломжоор нь өнгөрсөн хугацаанд хангасны үр дүнд өнөөдөр Лайс Мед-ээр биш, нийтийн мэдээлэл солилцооны Хур системээр мэдээллээ энэ эмнэлгүүд солилцсоны үр дүнд өнөөдөр и-монгол аппликэйшн дээр 3 жилийн шинжилгээний хариу орсон. Эмийн жор цахимжисан учраас аптека дээр цаас бичиг барьж очихоо больсон. Одоо 6 дугаар сарын 1-нээс өмнө жирэмсний дэвтэр, эх хүүхдийн ягаан дэвтэр, амбулаторийн карт, дүгнэлтүүд бүгдээрээ энэ эмнэлгүүд мэдээлэл солилцдог болсны үр дүнд орох гэж байна.

Нэг ёсондоо бол хэдхэн хувийн эмнэлгүүд дээр хэрэгжүүлсэн хэдэн хувийн компаниуд төрийн байгууллагад ажиллаж байсан хэдэн Ай Ти-гийн залуучууд энэ 18, 9 сая доллароор хийж чадаагүй ажлыг 3 сарын хугацаанд хэрэгжүүлчихсэн.

Гэтэл Лайс мед гэдэг системийн дахин сайжруулаач, дэд бүтцийг нь сайжруулаач гэдэг үүргийг Их Хурлын тогтоолоор өгөөд байх юм. Энэ Лайс мед гэдэг компанийг хэн ингээд хамгаалаад байдаг юм? Энэ хаа сайгүй бичиг дээр ийм нэр оруулж ирээд л ингээд үүрэг өгөөд байдаг. Энэ дампуурчихсан газрыг чинь дахиж сэргээж чадахгүй.

Энэ чинь хуулийн байгууллага шалгаж байгаа систем.

Гэтэл энийг ингээд дахиад Их Хурлын тогтоолоор энэ системийг сайжруул, аюулгүй байдлыг нь ханга, Цахим хөгжлийн яам хариуц гээд энэ чинь дампуурчихсан байна, энэ чинь болохоо больчихлоо гээд аргаа бараад сая манай энэ ай ти-гийн хэдэн залуучууд өөрсдөө энэ гацааг нь гаргаад явж байгаа байхгүй юу. Тэгээд энэ Лайс медийг сайжруулах бололцоо бол байхгүй шүү. Харин.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Жигжидсүрэнгийн н Чинбүрэн Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга хариулна. Яагаад ийм газар оруулчихсан юм?

**Ж.Чинбүрэн:** Учрал гишүүний асуултад хариулъя. Чухал зүйл та анзаарч байна. Лайс мед гэдэг маань Эрүүл мэндийн яаманд өмчлөгдөж байгаа ийм тогтолцоо. Нэг ёсондоо Монгол улсад бүртгэлтэй 4000 гаруй эмийн жагсаалтын. Тэгтэл бид энэ Түр хорооны шалгалтын явцад энэ Лайс мед программ нь өөрөө ямар ч хамгаалалтгүй. Жишээлэх юм бол, тэр админы эрхийг эдэлж байгаа хүмүүс паспортоороо бүртгэлгүй эмийг дураараа бичээд, тэгээд гааль дээр ирээд бүртгүүлэх гээд ирэхэд нь энэ чинь байгаа юм байна шүү дээ гэж үзэж хараад дараа нь 7 хоногийн дараа нөгөөдхөө буцааж устгаад, Монголд орсны дараа тэр эмийг дахиад хэн ч үзэхгүйгээр, ямар ч бүртгэлгүйгээр эм орох ийм нээлттэй тогтолцоо бий болчихсон юм байна. Ямар ч хамгаалалт байхгүй. Тэгээд тэрийг мэддэг 3-хан хүн паспортыг нь эзэмшдэг, хэн мэдэж байгаа, яаж орсноо лог нь устгаад нуучихдаг, харах боломжгүй ямар ч файрвол систем байхгүй ийм ноцтой асуудал байгаад байгаа юм.

Тийм учраас энийг Засгийн газар ялангуяа юуны төлөө бид Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай билээ та

бүхэн энэ дээр анхаарч, энэ системийг сайжруулах тал дээр онцгой анхаарахгүй бол болохгүй болчихжээ. Тухайлах юм бол, одоо бид Цахим, инновац байнгын хороон дээр энэ эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн Дэлхийн банкны төслийг явуулах гэж яаж их дэмжиж өглөө. Сая түр хорооны сонсгол дээр Энхболд сайд асан хэв нэг ярьж байгаа шүү дээ бид мөнгөө хураалгачихсан, хэдэн тендер авсан аж ахуйн нэгжийн буруугаас болоод бид 10 сая доллар хураалгачихлаа гээд сууж байгаа байхгүй юу. Ийм хариуцлагагүй сууж байна.

Тэгэхлээр энэ болгон дээр бид Засгийн газар энэ дээр бүүр онцгой анхаарч ажиллахгүй бол болохгүй болчихжээ. Тийм учраас бүүр зориудаар Цахим хөгжлийн яамыг ялангуяа Учрал сайдыг энэ дээр онцгой анхаарал тавьж ажиллаасай гэж хүсэж бүүр зориуд ингэж тавьсан.

**Г.Занданшатар:** Годруулж асууя. Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Энэ Чинбүрэн гишүүн бол маш тийм эмзэг сэдвүүдийг энэ сонсголын үеэр хөндсөн. Нэг ёсондоо бол Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулиар бол хүний эрүүл мэндийн мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл. Хүний эмзэг мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр ашиглаж болохгүй хувь хүний нууцад хамаардаг.

Гэтэл эмнэлгийн байгууллагуудаар өөр өөр төрлийн тасгийнхан гэхэд аль ч өвчтөний мэдээллийг шууд ороод хардаг байсан шүү дээ энэ хуулиас өмнө. Одоо бол энэ хориглогдсон хуулиар. Тэгэхээр энэ Лайс мед гээд яриад байгаа чинь өнөөдөр Эрүүл мэндийн яаман дээр байгаа ч гэсэн энийг хийсэн компани чинь тэр хувийн хэвшил чинь, аж ахуйн нэгжүүд чинь өнөөдөр хууль хяналтын байгууллагаас шалгагдаад байгаа юм бол Лайс мед системийгээ сайжруулаач, хамгаалалтыг нь нэмэгдүүлээч гэдэг бол энэ системийг л хөгжүүлнэ шүү, хувийн

хэвшилд хэрэгжүүлж байгаа нөгөө системүүд чинь бас л дахиад гацаанд орно.

Тэгэхээр нэг ийм системийг ингэж шууд тулгаж болохгүй байх. Энэ зүгээр системээ ерөнхийд нь сайн.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би хоёр зүйл асууя. Нэгдүгээрт, Улсын Их Хурлын энэ хяналт шалгалтын тухай хууль батлагдаад энэ хүрээндээ ерөнхий сонсгол, цаашилах юм бол яг тулгамдсан ийм асуудлаар зайлиггүй Түр хороо байгуулж ингэж үр дүнтэй ажиллаж байгаа. Тийм учраас энэ Чинбүрэн гишүүнээр ахлуулсан Түр хороод сайн ажиллажээ гэж би ингэж бодож байгаа. Ер нь энэ Улсын Их Хурлын нэг чиг үүрэг хянан шалгах энэ үүргийн чиг үүргийн үр нөлөө тийм туйлын хангалтгүй явж ирсэн учраас энэ 20-24 оны Улсын Их Хурал энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд ахиц дэвшил гарч ажиллаж байгаа гэдгийг би эхэнд нь хэлье.

Би юу хэлэх гэж байгаа вэ гэхээр зэрэг нэлээн сайн ажиллажээ. Тэр ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийн тухай асуудал байна. Ингээд өмнө нь яригдсан асуудлууд шиг ийм байдлаар ингээд замхраад өнгөрөх вий. Энэ Их Хуралд чинь ер нь үе үеийн парламентад л байсан аливаа нэгэн хууль шийдвэр гаргахаар зэрэг нөгөө талаар нь гуд татдаг, тэгээд ерөөсөө хэрэгжихгүй нөхцөлгүй болдог. Тэрний цаад талынх нь ашиг сонирхол бол хувийн ашиг сонирхол байдаг. Энэ болж өнгөрсөн үйл явдлуудыг хар жижиг, дунд үйлдвэрлэл гэхэд яг жижиг, дунд ЖДҮ-гийн зээл авсан улсууд гэхэд тэгээд яг авсан, завшсан, ажил албан тушаалаа нөлөөгөөрөө авсан, хууль зөрчсөн ийм хүмүүсийнх нь тухай асуудал биш, нөгөө тал руу нь гуд татаж аваачаад баахан улсуудыг зарлаад л, тэгээд л нэр хүндэд нь халдаад

л ингээд л замхруулаад дунд нь хаядаг. Хөгжлийн банкны асуудлаар бид нар ажлын хэсэг байгуулаад, 56 хоног ажиллаад бүх асуудлуудыг нь ил болгоод ингээд хуулийн байгууллагад шилжүүлээд ингээд Түр хороо байгуулаад явсан.

Тэгээд Түр хороо байгуулагдаад яваад яг жинхэнэ нүүрсний хулгайч нар, хүмүүс нь бол тэгээд ямар нэгэн хариуцлага хүлээсэн юм байхгүй. Харин өчнөөн олон хамаарал бүхий улсуудыг нь баахан цоллож нэр зарлаад тэн дотор хууль тухайн үед тэр үйлчилж байсан, хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн ямар нэгэн зөрчил байхгүй, хулгай худал ийм юм гараагүй ингээд ийм ашиг сонирхлын хоорондын тийм нөлөө гэж үзэхээр юм байхгүй улсуудыг бүгдийг нь хамж шимээд ингээд гаргадаг. Иргэдийн мэдэх эрхийг хангаж байгаа цахимжисан шилэн болж байгаа энд бол маргах юм байхгүй.

Гэхдээ нөгөө улсууд нь гол улсууд нь цаана нь үлдчихдэг ийм аюул бий шүү. Энэ талаас нь юу гэж үзэж байгаа юм? Эрүүл мэндийн салбарынхны л хамаарлын анги байсан юм уу, нутаг ус байсан юм уу юу байсан юм гээд л ингээд л өчнөөн юмнууд гаргаж ирсэн тухай та илтгэл дээрээ дурдлаа л даа. Гэтэл чинь цаад талд нь энэ өндөр дээд ажил албан тушаалын хүмүүсийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах энэ Ашиг сонирхлын хуульд өөрчлөлт оруулчихсан шүү дээ. Нөгөө төрийн албыг төрлийн алба болгодог, төсөл, тендер, концесс, төр, ард түмний нэр барьж авсан зээл, хууль, элдэв юманд оролцохгүй болчихсон ийм хууль байж байгаа.

Гэтэл энэ хүрээндээ төрийн өндөр энэ нөлөө бүхий этгээдүүдийн энэ тухайлах юм бол энэ эмийн бизнес, эм, эмнэлгийн хэрэгслийн энэ бизнест оролцоотой ийм хүмүүс ямар улсууд байгаа юм? Тэр гол хүмүүс барихгүйгээр яг хүмүүстээ хэлэхгүй баахан улсуудыг зарлаад сүүлд нь шалгаж шалгаж шалгаж тэр чинь угаасаа хууль

зөрчөөгүй, хулгай хийгээгүй, асуудал гараагүй улсууд чинь тэгээд л үлдэнэ шүү дээ. Тэгээд л ингээд ерөөсөө цаад улсууд нь цаана нь сугараад үлдчихдэг ийм юм бол манайд бол бүүр хэвшил болчихлоо. Үүнийг таслан зогсоохгүй бол болохгүй байна. Би энэ талаас .../минут дуусав./

**Г.Занданшатар:** Хариулт өгье. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн. Чинбүрэн гишүүн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

**Ж.Чинбүрэн:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ өнгөрсөн 30 жилийн хугацаанд хувийн хэвшлийнхэнд эмийн салбарыг нуруун дээр нь ачаа үүрүүлээд та бүхэн эмийн хүртээмж, хангамжийг тасалдахгүй хангаарай, хямд үнэтэй эмээр төсөвт том ачаа үүрүүлэхгүйгээр хийгээрэй гэдэг энэ өнгөрсөн 30 жилийн бугшсан нэг том зүйл бол энэ ашиг сонирхол, нэгдмэл сонирхолтой хамаарал бүхий этгээдүүдийн сүлжээ төрийн байгууллагаар дамжиж нэвт шургалсан байна. Эмийн ханган нийлүүлдэг байгууллагуудын төлөөллүүд гэх байдлаар энэ шийдвэр гаргадаг байгууллага дотор нэвчсэн байгаагийн нэг тод илрэл бол саяын миний нэлээн удаан хувь, процентоор ярьсан хамаарал бүхий этгээдүүд нэгдмэл ашиг сонирхолтой улсуудын тэр тоо.

Тухайлах юм бол, бид энэ тогтоолынхоо 2 дээр Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөл хийсэн хяналт шалгалтын явцад төрийн байгуулагдах эм хангамжийн байгууллагын хамаарал, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд үүссэн байж болзошгүй ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг холбогдох хуулийн дагуу шалган иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэхийг Авлигатай тэмцэх газар Дашидаваа-д хяналт шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг холбогдох хуулийн дагуу шалгаж

шийдвэрлэхийг Монгол Улсын Ерөнхий прокурор Жаргалсайхан-д тус тус зөвлөсүгэй гээд бүүр оруулчихсан. Ингээж бид араас нь нэхэхгүй бол тэгээд зарладаггүй, хэлдэггүй, тэгээд баахан нэр бид ингээд хэлээд гаргаад өглөө. Бид гэм буруутайг тогтоохгүй. Хууль хүчний байгууллага тогтоох ёстой.

Тэгэхлээр энэ үүргээ биелүүлэх ёстой гэж харж байгаа. Энэ утгаараа л бид 200 гаруй албан тушаалтны нэрсийг Авлигатай тэмцэх газарт өгсөн. Өнөөдөр би сая тогтоол дээр уншлаа 8, 9 дүгээр жагсаалтын архивын материал байхгүй, бүүр Эрүүл мэндийн яаманд байхгүй. Ямар ашиг сонирхолтой, яаж шийдвэрүүдэд гаргахад оролцсон гэдгийг бид үзэж болохгүй. Тэгэхлээр энэ юуг хэлж байна вэ гэхлээр хаан нуугдуулж, мэдээлэл өгөхгүйгээр уснаас хуурай гарна гэж бодож байгаа. Тэгвэл үүнийг хүртэл заавал энэ Авлигатай тэмцэх газар, Ерөнхий прокурорын газар үүнийг шалгаж үзээрэй. Эс үйлдэл гэдэг айхтар ноцтой зүйл байна шүү. Тийм учраас үүнийг ил гаргаарай гэж үүрэгжүүлж байгаа юм.

**Г.Занданшатар:** Тэгээд Чинбүрэн гишүүн ер нь энэ Түр хороо баахан асуудал дэлгээд тавьчихдаг, тэгээд сүүлд нь хариуцлага яасан бэ гэж л ард иргэд нэхээд байгаа юм.

Тийм учраас Мал эмнэлгийн газар малын нэгдсэн эмийн тооллого, хяналт шалгалт явуулж байна шүү дээ. Тэгэхэд энэ хүний эмийн нэгдсэн шалгалт тооллого хийж, энэ хуурамч, стандартын шаардлага хангахгүй хулгайн замаар орж ирсэн байж болзошгүй энэ эмүүдээ тодорхойлоод нийтэд, олон нийтэд зарламаар байна. Тэгж байж энэ тендер нэрийн доор хямд үнэтэй нь шалгараад эмийн чанар, стандарт алдагдлаа гэдэг дээр газар болгон иргэд нэн ялангуяа ахмадууд энэ аль юманд чинь илтгэх юм бэ энэ чинь? Ингээд бүгдээрээ л хуурамч эм гээд зарлачихлаа шүү дээ.

Тэгээд үүнийгээ улс тэгвэл тэр нь баталгаатай энэ нь баталгаагүй гэдгээ зарлаж өгөөч гэж байна. Энэ дээр бас Эрүүл мэндийн сайд төгсгөлд нь үг хэл, Эрүүл мэндийн сайд Эм, эмнэлгийн хэрэгслийн хууль дээрээ оруулаад, энэ тогтоолд оруулаад энэ бол хүний аюулгүй байдлын асуудал чинь улсын аюулгүй байдлын асуудал шүү дээ. Энэ дээр онцгой анхаарч зүгээр яриа хөөрөө биш бодитой арга хэмжээ авах шаардлагатай. Ахмадууд нэн ялангуяа тэрийг онцгойлон шаардаж байна лээ. Сая Архангай аймгийн иргэдтэй уулзаж байхад, Өвөрхангай аймгийн иргэдтэй уулзаж байхад. Ахмадууд одоо энэ эм чинь бид нар ямар эм уугаад байгаа итгэл байхгүй боллоо. Нөгөө сэжгээр өвдөж, сүжгээр иддэг эдгэдэг гэсэн чинь нөгөө эмдээ итгэлгүй болохоор чинь хүн яаж эдгэх болж байна? Тийм биз?

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгэхээр зэрэг Их Хурлын дарга сая асуучихлаа миний тодруулж асууя гэж байсан асуудал. Ингээд бүх эмийг хуурамч гээд зарлачхаж байгаа юм. Тэгэхээр ерөөсөө энэ Түр хорооны ажлын эцсийн үр дүн бол энэ эмийн чанар байдал дээр бүүр тодорхой үр дүн гарах ёстой нэг, энэ талаас нь.

Нөгөөдөх нь энэ үнийн өсөлттэй холбоотой. Энэ үнэ үнэхээр тэр монопол тогтоогоод ингээд зохиомлоор үнэ өсгөөд байсан байна уу, үгүй юү? Үүнийг нь шалган тогтоогоод тэр этгээдүүдэд хариуцлага тооцоод, үнэ дэлхийн зах зээлийн бодит зах зээлийн үнээр эмийн хэрэглээ иргэдэд хүргэх хэрэгтэй байна шүү дээ энэ асуудал.

Тийм учраас би дахиад хэлэхэд яг хариуцлагагүй, хууль зөрчсөн, хулгай луйвар, зохиомлоор үнэ өсгөсөн ийм хүмүүстэй холбоотой хариуцлагаа тооц. Тэгэхгүй бүгдэд нь нийтүүлж хаяад.

**С.Одонтуяа:** Чинбүрэн гишүүн хариулъя.

**Ж.Чинбүрэн:** Түр хорооны сонсголоор 3 өдрийн сонсгол дээр бид нэг чухал мэдээлэл өгсөн. Энэ бол одоо Монгол улсын зах зээл дээр хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа 10 нэр бүхий эмүүдийг үйлдвэрлэгчийн нэрээр 100 гаруй эмийн чанарыг шалгахад харьцангуй зөрүүтэй зүйл гараагүй. Хоёр ч лаборатори шалгуулсан.

Тийм учраас бид нарын дүгнэлтэд өнөөдөр Монгол Улсын зах зээл дээр байгаа бүх эм хуурамчаа гэж бид зарлаагүй. Бид тэгж зарлаагүй шүү.

Харин өргөн хэрэглээнд хэрэглэж байгаа эм бол ямар ч байсан чанарын шаардлага хангаж байгаа юм байна шүү. Харин үнийн зохицуулалт, төрийн зохицуулалт байхгүй байна. Бид чанартай эм гэдгээ батлах лаборатори нь ажиллахгүй байна. Үүнийг шалгадаг лаборатори нь тоног төхөөрөмжгүй музей болчихсон байна. Эмийн бүртгэл дээрээ түрүүн бас хэллээ Гаалийн ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн газар, Татварын ерөнхий газар мэдээллүүд нь хоорондоо нэгддэггүй. Тэгэхлээр нэгд.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Одоо Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя.

**Г.Ганболд:** Орон нутагт иргэд ерөөсөө тэтгэврийн мөнгө ер нь эмдээ хүрэхгүй байна л гэж байгаа юм. Өмнө нь 90-ээд оны үед 7 хоног сумынхаа эмнэлэгт хэвтэхэд шээснээс нь антибиотик, витамин хангинаад л сэн гээд гардаг байсан. Одоо тийм юм байхгүй болсон л гэж байгаа юм. Ер нь бол энэ сонсголдууд ер нь агуулга гэхээсээ илүү жоохон хэлбэр рүүгээ яваад байна. Хэлбэр рүүгээ. Ер нь хэн нэгэн хүн рүү чиглэдэг, тэгээд л баахан хамаарал гаргадаг. Тэгээд энэ Эрүүл мэндийн яам чинь тэгвэл бүгдээрээ л эмийн наймаачид

юм байна шүү дээ. Ингээд л 67 хувь нь, 75 хувь нь л эмийн сан, эмийн компаниудтай хамааралтай юм бол бүгдээрээ наймаачид байна. Энэ эмийн, Эрүүл мэндийн яам энэ эмийн салбарынхан.

Тэгвэл энэ чинь нөгөө ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гээд энэ Авлигатай тэмцэх газар чинь албан тушаалд томилоход нь авдаг биз дээ? Тэр яагаад ингээд гарч ирэхгүй байгаа юм? Ерөөсөө та хэд ингээд сонсгол хийгээд хамгийн ноцтой нь яг нэгдүгээрт нь нь яг юу байсан юм? Хоёрдугаарт нь яг юу байсан юм? Гурван ноцтой юм та хэлээд өгөөч. Хуурамч эмийг тэгвэл байхгүй гэж ойлгох нь байна шүү дээ би. Та нар гадагш нь гаднын лаборатори руу явуулж нэлээн хэдэн юман дээр шинжилгээ хийлгэсэн гэж ойлгосон. Гаднаас ирсэн лаборатори тэгээд дотооддоо таны хэлж байгаагаар лаборатори байхгүй гээд байх юм. Бараг дээр үеийн бүүр тэрэнд чинь тэгээд л орчин үеийнхээ лабораторид гадагш нь явуулсан лабораторийн шинжилгээнүүд энэ тэр таарч байна уу? Тэрийг нэг асуумаар юм. Яг ноцтой юм байгаа эсэхийг нь.

Гуравт нь байна шүү дээ. Энэ дээр бичсэн юмнуудын хамгийн ноцтой нь байна шүү дээ. Энэ анагаахын шинжлэх ухааны эм шинжилгээний лаборатори, эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын лаборатори хоёрын бүх шинжилгээний хариу зөрж байна. Тэр битгий хэл нэг асуудал дээр, эм дээр 2K874 ордог код байлгүй дээ. Нэг нь огт шаардлага хангахгүй байна гаргасан байхад, нэг нь шаардлага хангаж байна гэж гаргасан байх юм. Хэрэв шаардлага хангаагүй юмыг хангасан гэж гаргасан бол энэ хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг. Бүүр ноцтой юм байхгүй юу энэ чинь.

Тэгэхээр зэрэг энэ лабораториудын зөрүүтэй гараад байгаа нь хамгийн ноцтой асуудал юм биш үү?

Тэгэхээр лабораториудаа ер нь цаашидаа хэдүүлээ яг яах юм? Одоо ингээд Монголд итгээж болох лабораторийг танихаар яг аль нь байна? Итгээж болох лаборатори ер нь Монголд байна уу? Тэгэхээр энэ дотор бид нар хуурамч эмийн тухай л яриад байгаа. Одоо ингээд баахан мэдээлэл өгч байгаад өчнөөн эмүүд хуурамч л байна гээд байсан. Яг хуурамч эм нэг ширхэг ч алга уу? Бүгд ингээд асуудалгүй, олон улсын хамгийн сүүлийн тавигдаж байгаа энэ зүйлүүдийг шаардлагыг хангаж байна гэж ойлгох уу?

Нөгөө талаасаа байна шүү дээ. Бид нар энэ баахан хүмүүсийн хамаарал гараад ирдэг. Нөгөөдүүл нь үгүйсгэдэг. Тодорхой зарим асуудлуудаар ингээд Түр хороо байна шүү дээ. Бид бас нэг талаасаа би чинь Түр хороонд орж ажиллаж байсан хүмүүс. Шинжээчдийн дүгнэлтдээ хэдүүлээ 100 хувь үнэн гэж итгэхэд бас хэцүү шүү. Нөгөө талаасаа ингээд буруу мэдээлэл ер нь цаашидаа энэ Хяналт шалгалтын хууль дээр, одоо явж байгаа хууль дээр шинжээч хэрэвзээ хянан шалгагч буруу мэдээлэл гаргасан байх юм бол түүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг байх ёстой юм байна лээ. Бас энэ Түр хороо ч гэсэн өөрөө тэр зарлаж байгаа хүмүүс дээр нь асуудал гарах юм бол бас хариуцлага хүлээдэг.

Тийм учраас тэрэндээ нухацтай ханддаг байхгүй бол бид нар байна шүү дээ үндсэн агуулга руугаа орохгүй энэ юмны ард хэн байна гээд эзэн л хайгаад байгаа байхгүй юу. Хүн хайгаад байдаг. Энэ эм чанартай байна уу, үгүй юү гэдгээ ерөөсөө үзэж байгаа юм байхгүй шүү дээ. Эздийг нь хайгаад л, хүнийг нь хайгаад л, хэдэн төгрөгийн ашиг олж байгааг нь хайж гүйсээр байгаад ингээд үндсэн хяналт шалгалтын агуулгаасаа ингээд хэлбэр нь дэндүү хэлбэр рүүгээ ороод яваад байна. Тэгэхээр энэ дээр би ямар ч гэсэн эхний ээлжид танаас тодорхой мэдээллүүд авъя гэж бодож байна.

**С.Одонтуяа:** Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн хариулъя.

**Ж.Чинбүрэн:** Та хамгийн ноцтой байсан гурван жишээ хэлээдхээч гэж байна. Нэг дэх нь та өөрөө хэлчихлээ. Одоо үйл ажиллагаа явуулж байгаа улсын тодотголтой 2 лабораторийн хариу зөрж гарчхаад, хариу зөрж гарахдаа эхлээд тэр ХАБҮЛЛ-ын дэргэд байгаа эмийн лавлагаа лаборатори бол тэнцэхгүй гээд гаргачихсан байгаа. Би бол тэр лабораторид сайн ажлаа хийсэн. Гагцхүү АУИС-ийн дэргэдэх лабораторид очоод нөгөө муу гарсан дүгнэлтийг нь үзүүлэхгүйгээр бусад үзүүлэлтийг нь үзээд тэнцсэн гээд гаргаад ирж байгаа байхгүй юу. Тэгээд эндээс юу харагдаж байна вэ гэхлээр хүнээс хамааралтай хүн шийдвэр гаргадаг тогтолцоо чинь өөрөө нэвт шингэчихсэн байна.

Жишээлбэл, тэр өмнөх лаборатори нь болохгүй гээд байхад яагаад шинжээч тэр тодорхой зүйлийг нь үзээгүй бусдыг нь үзчихээд болгоо гэснийг нь аваачаад Хүний эмийн зөвлөл рүү оруулаад, Хүний эмийн зөвлөл нь тэрэнд тэгээд л хэв нэг батлаад гаргачхаж байгаа юм. Тийм учраас ер нь бид нарт энэ чатбот гэдэг систем ерөөсөө ажиллахгүй байна. Лабораториор дүгнэлт гарлаа. Тэр нь засаж болохгүйгээр систем дээр тавигддаг. Тэрийгээ хоорондоо хардаг. Тэгээд тэр шинжээч нь цаашаа дамжуулахдаа энийг Хүний эмийн зөвлөл дээр очиход тэд нар нь ч гэсэн бас шалгах боломжтой ийм тогтолцоо ер нь цахим тогтолцоо манай эрүүл мэндийн салбарт байхгүй болчихсоны тод хор энэ шүү. Та энийг яг онцолж хэллээ. Тэгэхлээр тэнд үнэхээр энэ чинь гэмт хэргийн шинж чанартай. Тийм учраас бид энэ материалыг Улсын ерөнхий прокурорт өгч байгаа.

Хоёрт, та лаборатори шинжилж чадаад байгаа юм уу гэж байна. Тэгэхлээр тэр тэнцэхгүй гэж гаргасан



эмийн лавлагаа, лаборатори харин байгаа тоног төхөөрөмждөө бүүр хөөрхий хамгийн чухал 3 аппаратынх нь 2 нь эвдэрчихсэн гэдсийг нь гаргаад хагалгаа хийчихсэн хүн шиг хамаг сэлбэгүүдийг нь нөхөөд, бие биеийгээ нөхөөд ганц аппаратаар ажиллуулаад удаан хийгээд байгаа шүү. Түүнээс бүүр хийж чадахаа больчихсон биш. Тэр ч утгаараа бид өргөн хэрэглээний 10 эмийг үзүүлэхэд ямар ч байсан тийм чанарын зөрүүтэй зүйл гараагүй.

Харин сонсгол дээр бид нэг зүйл ярьсан зүйл бол эмийн чанар гэдэг дээр дотор нь байгаа концентратаас гадна бохир зүйл байхаас гадна хүнд хэр нөлөөлдөг юм бэ гэж үздэг био эквалиент гэдэг зүйлийг Монгол Улс үзэхгүй байгаад байгаа байхгүй юу. Энийг үзээч ээ, тэр эмийн түүхий эдийн цэвэршилтээс хамаараад аль сайн цэвэршилттэй бүтээгдэхүүн бэ, гэдсээр хэр хурдан шилмэгдээд хүний биед орох вэ гэдгийг бид үзэж чадахгүй суугаад байгаа нь өөрөө бид энэ эмийн чанараа хянах боломжгүй байгаагийн нэг том жишээ нь энэ шүү.

Итгэж болох лаборатори гэвэл би тэр хөөрхий ажиллаж байгаа лаборатори. 2013 оноос хойш нэг ч тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй. Тэр ч утгаараа одоо харин тоног төхөөрөмжийн шинэчлэлийг нь хийгээд, зохион байгуулалтыг нь нэгдсэн лаборатори хүнстэйгээ цуг оруулаад бид энэ тогтоолын төсөл оруулчихсан байгаа. Ингээд явчих юм бол бид болно. Эмийн чанар гэдэг бол зөвхөн тэр найрлага биш шүү. Очоод хүнээ, өвчнөө эмчилдэг байх нь их чухал.

Тогтолцооны хувийн бид шалгалтыг хийж энэ Түр хороогоор ажилласан. Бид ерөөсөө 1 ширхэг улс төрч, хувь хүний асуудлыг ерөөсөө энд хөндөөгүй. Харин би бол энэ сонсгол бусад өмнөх хоёр сонсголоос арай өөр дөнгөдүү болсон уу гэж би дотроо дүгнэж байгаа. Яагаад гэвэл бид аль

болохоор тогтолцоонд болохгүй байгаа гэжүүдлүүдийг хууль, эрх зүйн орчинд нь, тэр хүнээс хамааралтай зүйлүүд дээр нь хоорондоо уялдаагүй байгаа энэ төрд шингэсэн энэ асуудлуудыг нь бүгдийг нь ил гаргаж тавьсан. Тэр утгаараа харин тогтолцооны шинэчлэлийг хийх ийм зөвлөмжүүд тогтоолоор би гарч байна гэж харж байгаа.

**С.Одонтуяа:** Ганболд гишүүн тодруулъя.

**Г.Ганболд:** Би тодорхой л юм асуугаад байгаа юм. Гадагш нь гаднын хамгийн сүүлийн энэ лаборатори руу хэдэн юм явуулсан гэсэн эмнэлгийн бэлдмэл. Тэрний хариу дээр чинь тэр таны хэлээд байгаа тэр нөгөө эмчлэх чадвар гэдэг нь бий гэдэг юм уу? Тэр нь яг яаж гарсан юм? Тэр нь тэрүүгээр яг баталгаажуулаад манайх ингээд дээж аваад бас болохгүй бол энэ шинэ лабораторио ашиглалтад ортол нь гадагш нь нэг жоохон лабораторийн дээжийг нь хөдөө гадаа зарагдаж байгаа энэ захаар зарагддаг энэ сум, аймгийн жижиг аптекууд дээр зарагддаг эмүүдээс түүврийн аргаар ингээд явуулах чиглэлээр ажиллахгүй бол. Одоо тэгвэл ингээд энэ сонсголоос чинь би Монгол улсад нэг ширхэг ч хуурамч эм байхгүй юм байна. Тийм учраас одоо тэр үнийн асуудал дээр нь л төр зохицуулалт хийх, Эрүүл мэндийн яам, бусад байгууллагын хамаарал бүхий нөхдүүдийг жоохон зайлуулах ийм л хоёр дүгнэлт гарлаа.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Чинбүрэн гишүүн хариулъя.

**Ж.Чинбүрэн:** Бид эмийн үнийн сонсголд, эмийн сонсгол дээр 3 өдөр явахад бас хуурамч эмтэй холбоотой шүүхийн шийдвэр гарсан 5 жилийн тайланг сонсгосон. Энэ сонсголоор жил болгон 4-8 тохиолдол байнга хуулиас шийтгэл хүлээж байгаа шийдвэрүүдийг танилцуулсан. Тийм учраас бүүр байхгүй гэсэн юм байхгүй шүү дээ. Тэгэхлээр бид

нөгөө стандарт бус эм, хуурамч эм гэдгийг нь хууль, эрх зүйн томъёоллын сайн ойлгоорой. Хуурамч гэдэг бол тэр шошиго, гадна цаас бичгийг нь өөрчлөөд, эс үгүй бол хуурамчаар үйлдвэрлээд ингээж оруулж ирж байгаа.

Стандарт бус чанаргүй эм гэдэг нь дооз нь хүрдэггүй. Эс үгүй бол зөвшөөрөлгүйгээр Монгол улсын хилээр оруулж ирж байгаа ийм тохиолдлууд байгаад байгаа шүү дээ. Үүнийг бид үгүй гээж хэлээгүй шүү. Тийм учраас бид бас нэр томъёо дээрээ нэг ойлголттой байхгүй зөрж ойлгоод буруу бас яриад байх вий.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Гүйцээж хариульа Чинбүрэн гишүүн.

**Ж.Чинбүрэн:** Гадагшаа шалгуулахаар бол Учрал гишүүнээр ахлуулж байсан Эмийн чанарын түр хороо явуулж байсан. Түүний төлбөр нь 40-өөд мянган долларын асуудал яригдаж байсан. Миний ахалсан Эмийн түр хороо төсөв ердөө бид 200 сая орчим төгрөгт багтааж энэ бүх ажлуудыг хийсэн. Бидэнд тэр төлбөрийг нь төлөх ийм санхүүгийн боломж байгаагүй. Тэр шинжилгээний хариунуудыг татаад авах боломж байгаагүй. Тийм учраас энэ үнэхээр төсвийн хязгаарлалтдаа түүний хариуг нь авах үнэхээр боломж нь надад байсангүй.

**С.Одонтуяа:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултаа асууна.

**Г.Тэмүүлэн:** Хэд хэдэн асуудлыг тодруулаад бас асууя. Сая хөдөө орон нутагт томилолтоор ажиллалаа. Ингэхээр ерөнхийдөө ер нь л яах вэ дээ сүүлийн томилолтоор ажиллах ч юу байх вэ сүүлийн 4, 5 жилийн хугацаанд л дандаа манай ахмадууд байнгын тогтмол эмийн хэрэглээ, хэрэглэдэг хүмүүс ч гэдэг юм уу гомдолж байгаа асуудал энэ байгаад байгаа юм. Эмийн үнийн өсөлттэй холбоотой, чанартай холбоотой асуудлууд дээр. Одоо эмийн

үнэтэй холбоотой Хянан шалгах түр хороо ажиллалаа. Үр дүн нь хэзээнээс гарах юм бэ гэдэг асуудлыг асуугаад байгаа юм. Энэ сонсголоор бол гол бас нэг айдас бол нийгэмд бий болгочихсон зүйл нь өөрөө ер нь эмийн чанар өөрөө их муу байна, хуурамч шахуу эмүүд их байна. Хадгалалтын хугацаа горим алдагдсан, чанаргүй эмүүдийг бараг ус тостой эмүүдийг, хор шахуу эмүүдийг ингээд зах зээлд нийлүүлж борлуулдаг байжээ гэдэг асуудал яригдаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ер нь яг ямар хариуцлага тооцох юм бэ? Гол асуудал бол хариуцлагын асуудал. Бид нар энэ хүний эрүүл мэндээр эмээр бол нэг талдаа бизнес хийж болохгүй. Ийм хариуцлагагүй нөхдүүд дээр тэр тусгай зөвшөөрлийг нь цуцлах, энэ нөхцөл байдлыг бий болгосон хариуцлагагүй магадгүй тэр холбогдох бүх албан тушаалтнууд болоод тэр хувийн хэвшил, байгууллагууд дээр хариуцлага л тооцох ёстой асуудал байна. Нэгдүгээрх нь.

Хоёрдугаарх нь чанараас гадна үнийн асуудал. Одоо иргэд хүлээлт үүсэж байна. Үнийг хэзээ буулгах юм бэ гэдэг асуудал яригдаад байгаа юм. Яг хугацаа хэзээ байна? Мэдээж энэ том юу гэдэг юм бугшсан ийм мафижсан маягийн засаглал тогтолцоо, ингээд төр засаг дээр анхаарал, халамж тавихгүйгээс болоод үүсчихсэн олон жилийн бугшмал энэ асуудлыг хэрхэн, ямар хугацаанд, хэзээ бий болгох вэ гэдэг асуудал. Сая магадгүй саяын тэр гол ярьж байгаа адаглаад тэр мэдээлэл дата-гаа бид нар нэгтгэж чадахгүй байна. Гааль, татвар, Сангийн яам ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ дээр нь хугацаатай үүрэг даалгавар өгөөд, энэ хүний эрүүл мэндтэй холбоотой асуудлууд дээр, эмийн чанартай холбоотой асуудлууд дээр, эмийн үнэтэй холбоотой асуудлууд дээр шуурхай хугацаа заагаад үр дүн гаргамаар байх юм. Бид нар нэгдүгээрт баталгаатай юм

хэрэглэмээр байна, чанартай юм хэрэглэмээр байна.

Дээрээс нь зах зээлийнх нь бодит үнэд тулгуурласан энэ эмийг хэрэглэдэг болмоор байна. Аудитын дүгнэлт бол гарсан жилийн өмнө. Энэ дээрээс зарим эмүүд дээр 5.4-10.6 дахин өндөр үнэтэй байна гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Энэ манай эмийн зах зээл өөрөө бараг 1 их наяд төгрөгт эргэлддэг гэж сонссон. Импортоор оруулж ирж байгаа эм маань бараг 500, 600 тэрбум төгрөг. Нэг талдаа аягүй асар их том мөнгөний зах зээл, бизнес болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр энэ хэрэв хөөсрөлт байгаа бол хэзээнээс, яаж бууруулах вэ гэдэг асуудлыг тодорхой гаргаж ирж тавихгүй бол энэ нэг талдаа бас асар их чухал асуудал шүү. Магадгүй бид нар асар олон луйвар, булхайн дээр бас нийтийн сонсголудыг хийлээ. Энэ дээр бид нар асар том ач холбогдол өгөх ёстой, хариуцлагыг өндөр хэмжээнд ярих ёстой, хүнийхээ эрүүл мэндийг хамгаалах ёстой л ийм чухал асуудал болоод байна. Тэгэхээр бид нар энэ эмийн зах зээлийг зохицуулах төр зохицуулах, хяналт тавих боломжгүй гээд суугаад байж болохгүй шүү дээ тээ. Тэгэхээр энэ дээр та хэд маань бас дотор ажиллалаа. Өдөр бүр нэмэгдээд байгаа энэ үнийн асуудлыг яах вэ? Иргэд бухимдаж байгаа нь тэтгэврээрээ, цалингаараа ч бараг эмээ авч чадахгүй болчихлоо гэдэг асуудлыг ярьж байна. Зарим тохиолдолд эмийг хоол хүнс шиг хэрэглэдэг ч хүмүүс бас байгаа.

Тэгэхээр бид нар бол тодорхой хэмжээнд хатуу хяналттай, хязгаарлалттай байх зайлшгүй шаардлага байна. Одоо энэ олон 4200 гаруй эмийн аптекууд байна гээд байдаг, 500 гаруй эм импортолж борлуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд байна гээд байдаг. Үүнийг ингэж тоог нь дураараа өсгөөд, нэмэгдүүлээд тэгсэн мөртөө хяналт тавихгүй байгаад байх болох юм уу? Үнэхээр саяын тэр хариуцлагагүй,

өндөр үнэ өсгөдөг, чанаргүй эм борлуулдаг энэ аж ахуйн нэгж, байгууллагууд.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Асуултад Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн. Тэмүүлэн гишүүний асуултад Жигжидсүрэнгийн Чинбүрэн хариулна.

**Ж.Чинбүрэн:** Үр дүн хэзээ гарах вэ гэж байгаа юм. Ерөөсөө энэ аливаа сонсголын гол асуудал бол үр дүнгээ яаж бид гаргах вэ гэдэг бол үнэхээр чухал. Тэр утгаараа ер нь энэ Эмийн түр хорооны бид хийсэн зүйл бол энэ эм зүйн салбарт болохгүй байгаа энэ бүх зүйлийг оношилж, энд тавьж оношиллоо. Гарал шийдэл бид бас хайсан. Тэр гарал шийдлийн дотор хамгийн чухал зүйл нэгд бид хэлж байгаа зүйл бол Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төслийг Засгийн газар яаралтай өргөн барь гэдэг энэ тогтоолын төсөл хүртэл орчихсон байгаа. Бид энэ хууль нь 2010 оноос хойш ерөөсөө их 6 дахин янз янзын ийм нэмэлт, өөрчлөлт орсноос яг жишээлбэл Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай агентлагийн тухай нэг заалт ч одоо үйлчилж байгаа хууль нь байхгүй. Зүгээр Засгийн газрын тогтоолоор энэ явж байгаа.

Тийм учраас Чинзориг сайд саяхан Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийг сая өнгөрсөн энэ 7 хоногт өргөн барьчихлаа. Энэ дээр харин Их Хурлын гишүүд та бүхэн идэвхтэй оролцож, Нийгмийн бодлогын байнгын хорооноосоо ажлын хэсгийг гаргаад яаралтай энэ асуудлыг шийдэх нь энэ гарц гаргалгааны нэг том шийдэл байна.

Хоёр дахь асуудал нь энэ үнэхээр энэ тогтмол эм хэрэглэдэг архаг хууч өвчтэй улсуудын санхүүгийн дарамт бол энэ эмийн үнэ. Судалгаагаар харахад бүх төрлийн судалгаатай бид нарын Түр хорооны шинжилсэн зүйл яг адилхан. Эм бол үнэхээр үнэтэй. Санхүүгийн дарамтад оруулж байгаа юм. Их Хурлаас бид нарт олгож байгаа том эрх юу

байна вэ гэхлээр бид төсөв дээр эмийн хөнгөлөлтийг 40 тэрбум төгрөг байсан эмийн хөнгөлөлтийг одоо 140 тэрбум буюу 100 тэрбум болтол нь өсгөөд өгсөн. Энэ өсгөсөн үнэ өсөлт өнөөдөр бодитой ард иргэдийн кармаг хоослохгүй байхад хамгаалж чадаж байна уу гээд харахлаар тийм сэтгэл хангалуун биш байна. Та бүхэн орон нутгаар яваад үзэхэд ерөөсөө ард иргэдийн ахмадуудын ярьж байгаа зүйл бол тэтгэврийн мөнгө хүрэхгүй байна гээд хэлээд байгаа юм. Оновчтой биш байгаа байхгүй юу. Нөгөө сүлбэчихсэн, нөгөө моно, олигополи болчихсон тогтолцоо чинь тэр үнэтэй эмүүдийг амь бөх оршуулаад байна шүү дээ. Яг гурилтай адилхан. Бид 100 тэрбум төгрөгөөр нэмж өгөөд байхад төсвийг 100 тэрбум шүү, 40-хөн тэрбум төгрөг байсан эмийг 140 тэрбум төгрөг болгоод өгөөд байхад энэ ард иргэдийн кармаг хоосолсоор л байна шүү дээ энэ эм. Тэгэхлээр оновчгүй байна. Тэгэхлээр шийдвэр гаргалтын түвшинд байгаа улсуудын ашиг сонирхлын зөрчил, хамаарал бүхий байдлыг бид яаралтай арилгах ёстой. Энэ хуулиараа бид энэ бүгдийг хийх ёстой.

Дараагийн нэг чухал зүйл бол бид ард иргэдийн хяналтад миний авч байгаа эм хэд дахин өсөж миний гар дээр ирж байгаа гэдгийг нь мэддэг эрхийг нь нээе. Нийтийн мэдээллийн тухай хуулиараа бид бүх юмыг цахимжуулж болж байна. Яагаад эмийн салбарын энэ үнэ цахимжиж чадахгүй байгаа юм, юу нугаад байгаа юм, хэн нугаад байгаа юм, үүний ард ямар бүлэглэлүүд байгаа гэдгийг бид таамаглаж байна шүү дээ.

Тийм учраас энэ бүгдийг буулгах бас дараагийн том алхам бол ханган нийлүүлж байгаа байгууллагууд жижиглэнгийн үнээр, хэмжигдэхүүнээр эмээ би ийм үнээр Монгол улсын хилээр оруулаа гэдгээ харуулдаг болгоё. Иргэн эмийн сан дээр очоод худалдаж авахдаа тэр компанийн эмийг би тэд дахин нугалаад юм уу тэдэн хувь нэмэгдээд авдаг юм байна гэдгээ ард иргэдийнхээ

хяналтад оруулах шиг сайн хяналт байхгүй. Тийм учраас бид энэ тогтоолын төсөл дотор энийг зориуд бүүр оруулж өгсөн. Гаалийн газруудаар яваад үзэхэд ханган нийлүүлэх компаниуд килограмм, литр, тонноор нь биччихэж байгаа байхгүй юу. Яаж энийг жижиглэнгийн үнэтэй харьцуулах юм? Би ч ойлгохгүй байсан.

**С.Одонтуяа:** Түр хорооны гишүүн Сандаг-Очир гишүүн нэмж хариулъя.

**Ц.Сандаг-Очир:** Түр хорооны гишүүнээр ажилласан гишүүний хувьд бас ганц нэг тайлбар, мэдээллийг өгье. Манай Их Хурлаас байгуулагдсан Түр хороо бол эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг л тогтоох. Шалтгаан нөхцөл. Үнийн өсөлтөд ямар шалтгаан, ямар нөхцөл нөлөөлж байгаа юм бэ гэдгийг л тогтоох. Тэрнээс шууд Түр хорооны сонсгол хийгдсэнээрээ эмийн үнэ буурна, чанартай болчихно гэж ингэж шууд ойлгож болохгүй юм. Энийг анхнаасаа бид бүхэн бас хэлж байсан. Энэ сонсгол хийгдсэнээр шууд эмийн үнэ буураад л, чанар нь сайжирна гэж. Ингэж гагцхүү өнөөдрийн нөхцөлд байгаа Монгол улсад хэрэглэгдэж байгаа эмийн үнэ яагаад үнэтэй байна, түүнийг үнэтэй байлгаж байгаа тэр шалтгаан, нөхцөл нь юунд байгаа юм бэ гэдгийг л гол нь илрүүлж, нийтэд тавих.

Одоо харин бид нар сонсгол хийгдсэнээр цаашидаа Эрүүл мэндийн яам нь Засгийн.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Нэмээд гүйцээгээд хариулъя Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Тэгэхээр цаашидаа энэ тогтоол орж ирж байгаа. Тогтоолоор бид нар Эрүүл мэндийн яам, Засгийн газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, татвар, гаалийнхан нь юу хийх юм бэ, ямар арга хэмжээг авах юм бэ гээд энэ бүх тогтоолоор орж ирж байгаа арга хэмжээнүүдийн үр дүнд эмийг цаашидаа

чанартай байлгах, үнийг бууруулах энэ бололцоо, боломжуудыг гаргаж ажиллана.

Тийм учраас тодорхой хугацаа шаардлагатай. Тэрнээс шууд өнөөдөр эмийн үнэ буурчиггүй нь шүү. Энэ олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүл. Энэ нь өөрөө эмийг үнэтэй байлгах нэг шалтгаан, нөхцөл нь болоод байна гэж байгаа учраас маш олон арга хэмжээнүүдийг энд Улсын Их Хурлын тогтоолоор холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл болгож өгч байгаа. Үүний хүрээнд цаашид тодорхой хэмжээнд үнэ буурах, орж ирж байгаа эмийг хяналт шалгалт нээлттэй болгох, чанартай болгох энэ асуудлууд яригдах юм л гэдгийг хэлье.

**С.Одонтуяа:** Тэмүүлэн гишүүн тодруулъя.

**Г.Тэмүүлэн:** Энд би орж ирж байгаа тогтоолын төсөл дээр нэг их ноцтой асуудал байгаад байгаа юм. Ингээд байгаа юм. Чанаргүй болон хадгалалтын хугацаа дууссан, горим алдагдсан эм, эмийн бүтээгдэхүүний устгалын бүртгэлийг цахимжуулах арга хэмжээ авах гээд. Тэгэхээр үндсэндээ энэ чинь нэг талдаа юуг харуулж байна вэ гэхээр яг чанаргүй болон хадгалалтын горим, хугацаа дууссан ерөөсөө хэрэглэх ёсгүй хор болчихсон ийм эмийг манайхан зах зээлд борлуулж байна гэсэн үг болж байна уу? Хэр хэмжээний эм, хэчнээн аж ахуйн нэгж, хэчнээн юу гэдэг юм ийм борлуулагч байгууллагууд ингэж байгаа юм? Энэ тийм байгаа бол бид нар энэ дээр чинь нэг талдаа эрүүгийн хэрэг үүсгээд шалгах ёстой асуудал шүү дээ. Хариуцлагын асуудал яригдах ёстой шүү дээ. Бид нар энэ бараг хор болчихсон шахуу зүйлээр ийм эмээр бизнес хийгээд байж, иргэдийнхээ эрүүл мэндээр тоглож байж болохгүй шүү дээ нэг талдаа.

**С.Одонтуяа:** Чинбүрэн гишүүн хариулъя.

**Ж.Чинбүрэн:** Тэгэхлээр Монгол улсад эмийн устгал хийж байгаа монопол нэг компани байна лээ л дээ. Тэгээд баруун, зүүн талд 2 компани байдаг. Тэр нь Бүрт. Устгасан эмийнхээ сери дугаараар цахим бүртгэл ерөөсөө байхгүй. Зүгээр цаасаар нэг юм байгаад байх шиг байгаа юм. Тэгэхлээр үүнийг бид үзэж, харж чадахгүй байгаа учраас Монгол улсад хэчнээн эм хугацаа нь дуусаж устгаж байгаа гэдэг мэдээллийг харах боломжгүй. Түүнээс одоо тэр устгах хугацаа нь дууссан эмийг зах зээл дээр гаргаад зараад байна гэж ойлгох зүйл биш шүү биш. Тийм биш.

Харин устгаж байгаа зүйлийн тэр мэдээлэл цахим болохгүй байгаа нь буцаад нөгөө орж ирсэн эм, устгачихсан эм хоёрын балансыг харах боломжгүй байгаад байгаа байхгүй юу. Жишээлбэл, та их чухал зүйл хөндлөө. Жишээлэх юм бол, одоо хүнсний бүтээгдэхүүн 3-ны 1 хугацаанд дуусахаас өмнө Монгол улсын хилээр орж ирдэг. Тэгэхэд эмд тийм зохицуулалт ерөөсөө байхгүй. 1 сар дутуу байсан ч гэсэн орж ирнэ гэсэн үг шүү дээ Монгол улсын хилээр.

**С.Одонтуяа:** Одоо Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Сонсгол явах ёстой юу? Ёстой. Олон нийт мэдээлэл авах ёстой юу? Ёстой. Тэгэхдээ энэ аливаа сонсголын энэ хандлага, шийдэл юмнууд тийм шударга, дабл стандартгүй баймаар байгаа юм. Тэгээд энийг би ажлын хэсгийн Улсын Их Хурлын гишүүд рүү хэлэхээсээ илүүтэй шинжээч нарт хандаж хэлэх гээд байгаа юм л даа. Тухайлбал, Мөнхсайхан сайд Эрүүл мэндийн сайдаар 6 сар ажилласан. Их л магтаад л жигтэйхэн юм болцгоож байна лээ. Тэгвэл 2020 оны 11 дүгээр сарын 11-нд Мөнхсайхан сайдын үед анх хүн амын дунд корона вирусийн халдвар гарч чухамдаа Мөнхсайхан сайдын үед 8 сая төгрөгөөр эмчилсэн. 20 мянган маск

худалдаж авсан байдаг. Энэ юмнуудаа ярихгүй хэр нь яг энэ КОВИД-ын үед өдөр, шөнөгүй ажилласан Баясгалан дарга Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Улсын 2 дугаар төв эмнэлгийн даргаар ажиллаж байсан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргаар ажиллаж байсан, мөн манай Энхзаяа дарга газрын даргаар ажиллаж байсан энэ КОВИД-ын үед одоо гайхалтай ажиллаж байсан. Одоо Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга хийж байгаа, манай Буянжаргал гавьяат, Нарангэрэл гавьяат 11 цагийн мэдээгээр манай иргэд бүгд мэднэ. Үгүй энэ 4 хүнийг л зарим нь ч тэтгэвэртээ суучихсан. Бүгдээрэнг нь эмийн мафитай холбоотой, хамааралтай гээд ингээд орон даяар зарлачхаж байгаа байхгүй юу. Дөрвүүлээ эсэргүүцэл илэрхийлсэн байна лээ. Хууль хяналтын байгууллага үүний учрыг олох байх.

Түрүүн Бат-Эрдэнэ гишүүн хэлчхэж байна лээ л дээ. Бид нар ЖДҮ, нүүрс бүгдийг нь ярьсан. Тэгээд ямар хүмүүст хариуцлага тооцсон бэ? Доогуур нь байгаа баахан хүмүүсийг л жоохон ороосон байх, тэгээд л үндсэндээ бусад нь төрийн өндөр албан тушаал хашаад л ингээд л явж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дабл стандартын асуудлыг ер нь нэг цэгцлэхгүй бол тэгээд л баахан хүний нэр төрд халдаад, хариуцлага тооцсон зүйл байхгүй, шийдэл ч байхгүй ингээд өнгөрөх гээд байгаа учраас би энэ зүйлүүдийг ярьж байгаа юм шүү. Яг ажлаа хийгээд, тэгээд хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө зогссон хүмүүс буруудаад байж болохгүй.

Хоёрдугаарт Эрүүл мэндийн яамыг бүхэлд нь мафи гэж нэрлэж болохгүй. Энэ чинь 56 мянган хүнтэй ийм томоохон салбар. Яг тодорхой асуудлуудыг ярихгүй бүхэлд нь салбарыг харлуулах юм бол нөгөө эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авдаг иргэдийн маань сэтгэл, санаа юм ямар байх вэ? Харин сая Чинбүрэн гишүүн маань бүх юм хуурамч биш гэдгийг зарлачихлаа.

Намайг Эрүүл мэндийн сайдаар ажиллаж байхад бид нар зах зээлийн судалгаа хийлгэж байсан. 14-19 хувь нь асуудалтай байна. Энэ бол зарим нь ганзагаар ороод ирчихсэн ихэнхдээ бүртгэлд бүртгүүлээгүй эмийг л ер нь бүртгэлд бүртгэгдээгүй хуурамч эм гэж үзэж байгаа болохоос биш бусдыг нь одоо бас тэгж үзэх боломжгүй гэж энэ судалгааны дүн гаргасан байдаг юм.

Одоо Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль ороод ирэхээр зэрэг эдгээр асуудлыг бид нар хуулиар засчих бололцоотой байх гэж бодож байгаа юм. Цэцгээ гээд энэ эмийн чиглэлийн мундаг мэргэжилтэн байдаг юм, одоо хаа явна? Саяын миний нэрлэсэн улсууд чинь бүгдээрээ Мөнхсайхан сайдын үед бүгд халагдчихсан шүү дээ. Тэгээд энэ тэр үед бас Цэцгээ халагдсан байсан, одоо хаана яваа юм? Энэ Цэцгээ хэлдэг юм эмийг борлуулалтынх нь үед бас шалгалт хийж зах зээлээс татах, чанарт нь. Дээр нь үнийн тухайд ижил төрлийн эмүүд өөр өөр үнэтэй байгааг ил цахим орчинд тавих юм бол хүмүүс тэндээсээ сонголт хийх боломж их гарах гээд ингээд олон улсын туршилага судалсан маш олон гаргалгаануудыг гаргаад хуулийн төсөл бэлэн болгосон. Харамсалтай нь хэлэлцэхгүй байсаар байгаад өдий хүрсэн. Тэгээд манай Чинзориг сайд өнөөдөр оруулж ирэх гэж байгаа юм шиг байна.

Тийм болохоор миний гол хэлэх гээд байгаа асуудлууд бол энэ саяын энэ Цэцгээ мэргэжилтэн бол бас ийм зүйл ярьж байсан юм шүү. Эмийн үнийг хэдэн хувийн ашигтай байх вэ гэдэг ийм дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж болон олон улсын туршилага дээр үндэслээд эмийн, одоо бид нар чинь тивдээ 3-аас 5 дахин өндөр үнэтэй эм хэрэглэж байгаа байхгүй юу. Тэгвэл энэ эмийн үнийн хязгаарлалтыг төрөөс зохицуулдаг.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн хариулъя.

**Ж.Чинбүрэн:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Би хянан шалгагч шинжээч нараа дабл стандартаар ажилласан гэж ерөөсөө дүгнэхгүй байгаа. Эд нар маань бас хууль, эрх зүйн нөхцөлөө сайн ойлгож байгаа. Хуулийн өмнө хариуцлагаа хүлээнэ. Мөн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах энэ хуулийн хүрээнд хамаарал бүхий этгээдүүдийг үзэж шалгасан. Ингээд нийтдээ 200 гаруй хамаарал бүхий шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа хүмүүсийг тодорхойлсон. Эдгээр нь бүгдээрээ шийдвэр гаргах нөхцөлд ажиллаад, хувийн өөрийнхөө тэр нэгдмэл сонирхолтой байгууллагуудынхаа эрх ашгийг гаргасан уу гэдгийг би одоогоор хэлж мэдэхгүй. Бид хуулийн хүрээнд хамаарал бүхий ийм байна шүү гэдгийг л бид тодорхойлж өгсөн.

Гэхдээ би зарим жишээг ярьсан шүү дээ. Зарим жишээн дээр тухайн өөрийнхөө ажиллаж байгаа тэр их сургуулийнхаа бүтээгдэхүүнийг Хүний эмийн зөвлөлд ороод батлуулж ирсэн жишээлбэл тохиолдол байгаа. Харин би энэ социал мэдээн дээр зориудаар цагаан нөмрөгтэй эмч нараар халхавчлан ард нь энэ том сүлжилдсэн компаниуд PR-аа хийсэн.

Жишээлбэл, хамаг буруу, булхайг эрүүл мэндийн салбарын тусламж үзүүлж байгаа салбар руу, эмч нар руу, эмнэлгийн ажил хийж байгаа хүмүүс рүү аваачихыг оролдсон. Энэ социал орчин гэдэг бол өөрөө асар их том тэмцлийн талбар болчихсон юм байна. Их мөнгөтэй монопол компаниудын амархан идэш болдог ийм салбар болчихсон юм байна. Нөгөө ажлаа хийж байгаа заавал тэр асуудалд оролцоод гэмт хэрэг хийчихсэн гэж зарлаагүй улсуудыг зориудаар нүүрийг нь гаргаж ирж тавьж байгаад мафи бүлэглэлийн ийм гишүүд байна. Ингэнэ, тэгнэ гэж зориуд манай Түр хорооны сонсголыг хүчгүй болгож, хүчийг нь сулруулах гэж

оролдсон том оролдлого гэж би үүнийг харж байгаа. Түүнээс манай эрүүл мэндийн салбарынхан, эмч, ажилчид энэ дээр ерөөсөө ур чадвар дутсан, эмчилж чадахгүй байгаа зүйл байхгүй. Харин ч том том дэвшилүүдийг хийж чадсан. Би ч өөрөө энэ салбарын хүн учраас энийг өмөөрнө. Тэгэхлээр та бүгдийн би тэр сошиалаар явуулж байгаа тэр хар PR-ыг чинь санаа, зорилго бүтээгүй гэдгийг бүүр зориуд энд онцолж хэлье.

Харин тэр нэр холбогдоод байгаа улсууд хэрвээ албан тушаалаа ашиглан шийдвэр гаргаагүй бол энэ тэр асуудал биш. Энд эмзэглээд байх зүйл байхгүй. Харин түрүүн би бас хэллээ 8, 9 дүгээр жагсаалтын нууж, дарагдуулж, хамаарал бүхийгээс нь зайлуулах гэж оролдож байгаа бол та нар уснаас хуурай гарна гэж бодож байгаа бол үгүй шүү. Энийг Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурор заавал шалгаж, яагаад мэдээллийг нуун дарагдуулсан гэдгийг илчлэх болно. Бид ийм ч тогтоолоороо үүрэг өгч байгаа.

**С.Одонтуяа:** Сарангэрэл гишүүн тодруулъя.

**Д.Сарангэрэл:** Эмийн үнийн асуудал дээр бид нар онцгойлон анхаарах ёстой. Энийг Улсын Их Хурал Байнгын хорооны түвшинд яриад ажил хэрэг болохгүй юм байна лээ. Тийм болохоор хуулиар зохицуулах ёстой. Үүнийг бид Байнгын хорооны шугамаар өнөөдөр ингээд хийгээд эхлэх байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, эмийн үнийн асуудал иргэн хүн болон айл өрхөд зүгээр санхүүгийн дарамт болж байгаа юм биш. Бүхэлд нь ядууралд хүргэх ийм том эрсдэл болж байгаа учраас олон улсын жишигээр эмийн үнийн зохицуулалтын асуудлыг бид хуулиар зохицуулахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байгаа.

Эцэст нь хэлэх гэж байгаа зүйл бол эмийн агентлаг байх ёстой шүү.

Хөгжсөн оронд эмийн болон хүнсний агентлагаар тогтохгүй яамтай байгаа. Яагаад гэвэл эм, хүнс бол хүний эрүүл мэнд, амь нас, үндэсний аюулгүй байдлын хэмжээний асуудал учраас энэ агентлагийнхаа асуудлыг хэдүүлээ бас өөр тийш нь залж авч явах шаардлагагүй гэж би хэлэх гэсэн юм. Үг хэллээ.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Одоо Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

**С.Чинзориг:** Би зүгээр санал хэлчихье дарга. Түр хороо бол ажилласан, Түр хорооноос гаргасан дүгнэлттэй бол санал нэг байгаа. Гэхдээ бас зарим юмнууд дээр бас жаахан эргээж харах бас олон нийт эргэлзээ өгвөл бас гэсэн тийм асуудал байгаа болов уу гэж би эргэлзээд байгаа юм. Бодож байна.

Ер нь бол эм гэдэг өөрөө Үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой стратегийн бүтээгдэхүүн. Стратегийн бүтээгдэхүүнийг бид нар сүүлийн 30 жил зөвхөн хувийн хэвшилд даатгаад л явж ирсэн нь энэ бодлогын бас би том алдаа байсан юм болов уу л гэж бол салбарын сайдын хувьд үзээд байгаа юм. Стратегийн бүтээгдэхүүн юм бол энд төрийн оролцоо байх хэрэгтэй, төрийн зохицуулалт байх хэрэгтэй, төрийн хяналт байх хэрэгтэй. Нөгөө талаасаа төрийн бас дэмжлэг ч байх ёстой. Бид бол стратегийн бүтээгдэхүүн гээд шатах тослох материал, дээр улаан буудай дээр эд нар төр асар их анхаардаг шүү дээ. Санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээлээр дэмжлэг үзүүлдэг, татварын дэмжлэг үзүүлдэг. Тэгсэн атлаа стратегийн бүтээгдэхүүн эм дээрээ тийм төрийн бас дэмжлэг байхгүй явж ирсэн энэ бас нэлээн тийм алдаа байсан байна гэж би тэгж бодож байгаа юм.

Чинбүрэн гишүүний энэ Түр хороо зүгээр болохгүй байгаа юмыг нь нэлээн яриад байгаа юм. Гэхдээ бас болж байгаа юм юу байна вэ? Ялангуяа

сүүлийн үед энэ Их Хурлаас, Засгийн газраас авч байгаа арга хэмжээнд бас засаж байгаа, залруулж байгаа, бас сайжруулах гэж хичээж байгаа юмнууд юу байна вэ гэдгийг нь уг нь бас дүгнэлтэд оруулж хэлсэн бол бас зөв байсан болов уу гэж бодож байгаа юм. Энэ Их Хурал чинь бол өнгөрсөн хавар бид нар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар бараа, бүтээгдэхүүн худалдан авах хуульд өөрчлөлт оруулаад эмийн тендерт бага үнийн санал үйлчлэхгүй, хэмнэлтийн зарчим үйлчлэхгүй, эмийн тендерийг чанар, үнийн хосолмол аргаар шалгаруулдаг байна энэ тэр гээд хуульдаа өөрчлөлт оруулсан.

Хоёрдугаарт, бидний яриад байдаг чанартай эмийг олон улсын стандартын шаардлага хангаж байгаа эмийг гадаад улсын үйлдвэрээс нь шууд худалдан авах, олон улсын худалдан авалтын системийг ашиглаж шууд худалдан авдаг болж байгаа эд нар гээд энэ бас хийж байгаа юмнууд байна. Тэр эмийн лабораторитой холбоотой асуудал бол одоогийн байгаа нөхцөлүүд жаахан өнөөгийн шаардлага хангахгүй байгаа юм. 20 жил энэ лаборатори чинь Мэргэжлийн ерөнхий газрын харьяанд байж байгаад сая 22 онд Эрүүл мэндийн яаманд бол салбарын хяналт ирж байгаа юм л даа. 13 онд бол бас Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр нэлээн бас тоног төхөөрөмжөө авсан. Одоо тэр бүгд нь шаардлага хангахгүй болчихсон асуудал. Бид бол Дэлхийн банкны цар тахлын төслөөс буцалтгүй тусламжийн хүрээнд 5 тэрбум төгрөгийг шийдүүлээд энэ онд бол энэ эмийн чанар, хяналт, баталгаажуулалт хийдэг лабораторийг тоног төхөөрөмжийг шинэчлэхээр бас ажиллаж байгаа. Ингээд Засгийн газраас авч байгаа арга хэмжээнүүд байна.

Тэгэхээр миний эргэлзэж байгаа юм, бид бол ер нь Засгийн газар дээр яриад нэгэнт үнийн эмийн асуудлаар Түр хороо байгуулаад, сонсгол явуулаад олон нийтэд ийм болж байгаа, болохгүй



байгаа мэдээлэл өгчихлөө, засах сайжруулах юмнууд бол байна. Тийм учраас бид энэ эмийн Эм, эмнэлгийн хэрэгслийнхээ хуулийн шинэчилсэн найруулга яаралтай Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлбэ гээд Их Хуралд өргөн барьчихсан яаралтай горимоор. Тэгээд өнөөдөр Байнгын хороо хэлэлцэх гээд төлөвлөж байна.

Тэгэхээр энэ тогтоолын чинь дийлэнх нь эмийн хууль тогтоомжид ийм чиглэлээр зохицуулалтуудыг оруулж ир гэсэн тогтоол Засгийн газар хуулиа Их Хуралд оруулж ир гэсэн тогтоол байгаа юм. Тэгэхээр одоо бид нар ингээд энэ тогтоол яг энэ чигээр нь явуулах юм уу, эсвэл энийгээ өөрчлөөд жаахан цомхон болгоод Засгийн газраас Их Хуралд хуулийнхаа шинэчилсэн найруулгыг өргөн барьчихсан учраас хэлэлцүүлэг дээр энэ асуудлууд анхаараад явчих уу гэдэг нэг асуудал бас асуудал байгаа юм.

Хоёр дахь асуудал эмийн лабораторитой холбоотой асуудал чинь хөрөнгийг нь бол тэр Дэлхийн банкны төслөөс буцалтгүй тусламжийн хүрээнд шийдчихсэн юм. Тэгэхээр үүний хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийд гээд ингээд тогтоолд ороод ирж байгаа юм. Тэгэхээр энэ хууль өргөн барьчихсан асуудлууд, дээр нь лабораторитой холбоотой асуудал бас шийдэгдсэн учраас энэ үүнийгээ.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Үг хэлсэн гэж ойлгосон тийм үү? Санал хэлсэн. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Хянан шалгах түр хорооны саналаар санал хураалтыг үдээс хойших хуралдаанаар үргэлжлүүлэн явуулна. Үдээс өмнөх хуралдаан үүгээр завсарлаж байна.

13.59 цаг.

Пүрэв гараг, 02 Тавдугаар сар 2024  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
14 цаг 30 минут.

## ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Чуулганы 05 дугаар сарын 02-н өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Одоо хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Гишүүд чуулганы танхимд орж ирье. Монгол Улсын Их Хурлын шалгалт хянан шалгалтын тухай хуулийн 56.8-д заасны дагуу Түр хороо тайлан, санал, дүгнэлттэй нэгдсэн хуралдаанд танилцуулснаар уг хороог татан буугдсанд тооцно гэж заасны дагуу Эмийн үнийн өсөлт, шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгалтын хорооны хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулна.

Үүний дараа Хяналт шалгалтын түр хорооны хууль санаачлагч, төсөл санаачлагчид байхгүй учраас үүнийг хойшлуулаад дараагийн асуудалд орно.

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн,

Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Индэрт урьж байна. Их Хурлын хууль.

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нараас 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчим алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн.

14.36 цаг.

**Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нараас 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүд яасан орой орж ирж байна? Бямбадоржийн Болдбаатар Хууль, эрх зүйн газрын дарга, Үнэнбат дарга Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга.

Байнгын хорооны төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн бататгах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд оръё. Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль болсон.

14.41 цаг.

**Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн явуулна.

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Л.Мөнхбаатар, Г.Тэмүүлэн нараас 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 1 саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд  
ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Маамын Үнэнбат Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга, Бямбадоржийн Болдбаатар Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Ганхуягийн Агар-Эрдэнэ Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхэлсэн хэлтсийн дарга.

Танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Асуулт, хариулттай хүн байхгүй юу?

Асуулт, хариулт байхгүй учраас Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийг хасах санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Энэ саналыг дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно.

Төсвийн байнгын хороо дуусчав уу Сандаг-Очир гишүүнээ? Нийгмийн бодлого дуусчав уу? Нийгмийн бодлогынхныг орж ир. Оюунчимэг гишүүн 12 цаг хүртэл чөлөө авсан шүү дээ.

Санал хураалт явуулна, санал хураалтад бэлдье. Нийгмийн бодлогын байнгын хороо дууссан байгаа 5 гишүүн орж ирье. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо яасан? Төсөв түрүүн дууссан. Төсвийн байнгын хороо хуралдаж дууссан. Одоо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдаж байна. Энэ, Ганболд гишүүнээ Ганболд гишүүнээ танай Байнгын хороо дууссан уу? Нийгмийн бодлогын байнгын хороо дуусчихсан гээ биз дээ? Анужин Нийгмийн бодлогын байнгын хорооныхон яачхав? Жаргалмаа гишүүн Байнгын хорооныхныгоо дууд.

Санал хураалт явуулна. Энэ Содномын Чинзориг сайд, Даваажанцангийн Сарангэрэл гишүүн хоёр Байнгын хороод тарчхаад байхад хаачсан? Дууд. Яг дуудангуут хоёулаа орж ирж байна. Санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал байна энэ.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Карт сугалж болохгүй шүү. Одоо болсон. Санал хураалт явуулна. Анхааралтай. Санал хураалт явуулна. Санал хураалт.

20 гишүүн дэмжиж, 51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчлэл найруулгын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд илжжүүлж байна.

14.49 цаг.

Одоо нэг тогтоол батална. Бүгдээрээ сайн анхааралтай байж байгаарай. Чинбүрэн гишүүн ирчихсэн учраас.

**“Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн, шалтгаан нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.**

Үг гэж байхгүй. Хэлэлцүүлгийн явцад гаргасан гишүүдийн гаргасан саналыг үндэслэн Улсын Их Хурлын тогтоолын төсөлд найруулгаар тэр компанийн нэр энэ тэр тодорхой заахгүйгээр нийтлэг эрх ашгийг хамгаалсан. Хөөе Оюунчимэг гишүүн суудалдаа суу. Санал хураалт явуулах гээд байна. Энх-Амгалан гишүүн. Санал хураалт явуулна шүү. Санал хураалтад бэлэн үү? Сэргэлэн гишүүн пиджакаа тайлж байна, тавилаа. Санал хураалт. Санал хураалт, санал хураалт, санал хураалт бүгд.

21 гишүүн дэмжиж, 53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 56.8-д Түр

хороо тайлан, санал, дүгнэлттэй нэгдсэн хуралдаанд танилцуулснаар уг хороод татан буугдсанд тооцно гэж заасны дагуу Эмийн үнийн өсөлт шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хороог татан буугдсанд тооцлоо.

Манай Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүний ахалсан Эмийн үнийн өсөлт шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий ажлын түр хороо богино хугацаанд үр дүнтэй ажиллаж, тодорхой санал, дүгнэлтүүдийг гаргалаа. Одоо энэ үнийн өсөлт, шалтгаан нөхцөлийнхөө арилгах, шийдлийг гаргах ёстой. Одоо ерөөсөө шийдэл, хариуцлага хоёр орхигдоод байна гэж ард иргэд шүүмжлээд байна.

Тийм учраас энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиа сая хэлэлцчихсэн үү Чинзориг сайд аа? Ард иргэд ахмадууд нөгөө энэ чанаргүй эм, энэ малын ч эм, хүний ч эм ерөөсөө чанаргүй болчхоод, баталгаажихгүй болчхоод энийг лабораториор баталгаажуулдаг, Монгол хүнд дасан зохицох чадварыг нь хянан шалгадаг хянан шалгахынхаа Эф Ти Эйчийг тэр тусгай зөвшөөрөл энэ тэрийн асуудлыг маш сайн тодорхойлох хэрэгтэй байгаа юм. Ингээд энэ түр хорооны дараагийн ажил эм, эмнэлгийн хэрэгсэл дээр тусгалаа олох ёстой.

14.52 цаг.

**Одоо Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Сайханбаяр генералыг урьж байна, орж ирье. Хууль санаачлагчийн илтгэлийг Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Сайханбаяр:** Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга аа, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл болон Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай 2024 оны 16 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж байна.

Тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлан хамгаалах болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар батлагдсан ажлын хэсэг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн юм.

Тус хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр дараах эрх зүйн зохицуулалтуудыг тусгалаа. Үүнд:

Хуулийн зарим нэр томъёоны тодорхойлолт болон энхийг дэмжих ажиллагааны удирдлага, зохион байгуулалттай холбогдох зохицуулалтыг нарийвчлан тогтоолоо.

Монгол Улсын Их Хурал Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх, цэрэг, цагдаагийн багийн захирагчийн нийтлэг эрх, үүрэг, энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэрэг, цагдаагийн алба хаагч, багийн нийтлэг үүрэгтэй холбогдох зохицуулалтыг шинээр орууллаа.

Засгийн газрын болон гадаад харилцаа, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхтэй холбогдсон эрх зүйн

зохицуулалтад холбогдох өөрчлөлтийг тусгалаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан тушаал, сонгон шалгаруулалтад тэнцсэн бие бүрэлдэхүүнийг томилох, эргүүлэн татах болон энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн баг оролцуулах, цагдаагийн албан хаагч оролцуулах, үүрэг гүйцэтгэх төрлийг шинээр тодорхойллоо.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас нөхөн олговор олгуулах, ээлжийн амралтаа эдэлж чадаагүй тохиолдолд мөнгөн урамиуулал олгох, үүрэг гүйцэтгэх хугацаанаасаа өмнө эргүүлэн татагдах тохиолдолд холбогдон гарах зардлыг гаргах тухай хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон зэрэг зохицуулалтуудыг хийлээ.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад Монгол улсын хувь нэмэр, үүрэг оролцоо нэмэгдэж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрээр энхийг дэмжих болон олон улсын бусад ажиллагаанд оролцох хууль, эрх зүйн орчин боловсронгуй болж, энхийг сахиулагчдын аюулгүйн болон эрх зүйн байдал иргэний үүрэг, гүйцэтгэх чадавх дээшилж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, батлан хамгаалах бодлогын үндэс, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх зорилтыг хангахад чухал нөлөө үзүүлэх болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй юм.

Иймд Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн шийдвэр гаргаж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 4 сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын бусад ажиллагаанд оролцох төрлийг нэмэгдүүлэх, энхийг дэмжих ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн 35-д Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, Монгол Улсын Үндэстний аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны 2 дугаар зөвлөмжийн 2.1-д Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсаас цагдаагийн баг оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх гэж заасныг үндэслэн Засгийн

газраас Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдыг ямар журмаар сонгон шалгаруулж авдаг, уг үйл ажиллагаанд оролцоноор манай улсад болон тухайн цэргийн албан хаагчдын олох орлого болон зарлагын талаар асуулт асууж, хариулт авсан болно. Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хуулийн төслийн 4.4-д тухайн цэргийн алба хаагчийг энхийг сахиулах ажиллагаа, үүрэг гүйцэтгэх хугацаанд өөр албан тушаалд өөртэй нь тохиролцсоны дагуу томилж, эргэж ирэхэд нь ямар албан тушаалд томилж ажиллуулах талаар, цэрэг цагдаагийн албан хаагч Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэх тухай зохицуулалт өмнөх хуульд байсан эсэх, энэ тохиолдолд заавал цэргийн албанаас чөлөөлөх эсвэл энгийн албан хаагч нараас сонгон шалгаруулах эсэхийг тодруулаад, төслийн 7.1.6-д Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон нөхөн төлбөрөөс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардал болон Зэвсэгт хүчний болон цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоох гэж заасан нь цаашид өөрчлөгдөх эсэх, цагдаагийн алба хаагчид нэгдсэн цэргийн командлалын удирдлагад хамрагдах эсэх талаар тодруулан асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан энхийг сахиулах ажиллагаанд онцгой байдлын алба хаагчдыг оролцуулах боломжтой эсэх, тэднийг уг ажиллагаанд оролцуулснаар дэлхий нийтэд тохиолдож буй гамшигийн болон хохирлын голомтод ажиллаж туршилагажих, бэлтгэгдэхийн зэрэгцээ

шаардлага байгаа болохыг онцлоод цагдаагийн алба хаагчид энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоноор ямар давуу талыг өөрсдөдөө бий болгох, тухайн албан хаагчид ямар үйл ажиллагааны хүрээнд ажиллах тухай болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн рот, хохирлын дараах сэргээн босголтод батлан хамгаалах салбарын инженерийн ротыг оролцуулах эсэх талаар баримталж буй бодлогын тухай тодруулан асууж, хариулт авсан болно.

Хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Эрхийн Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна. 2 гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулна.

Ажлын хэсгийн гишүүд Гүрсэдийн Сайханбаяр Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний



Жанжин штабын дарга, хошууч генерал, Чулуунборын Гандирваа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал, Гомбосүрэнгийн Энхболд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа, Лхамдоржийн Нямаа Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа.

4 сарын 28-нд Монгол генералуудын өдөр тохиосон. 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Ардын сайд нарын зөвлөлийн тогтоолоор Монгол Улсад анх генерал цолыг бий болгож, 11 хүнд генерал цол олгосон байдаг. Тэгээд энэ түүхэн өдрийг тохиож Монгол генералуудын өдрийг жил бүрийн 4 дүгээр сарын 28-нд тэмдэглэдэг. Тэгээд эр цэргийн оргил манлай болсон генерал цолтнууддаа, генерал цолтны 80 жилийн ойн баярыг тохиолдуулан баяр хүргэе. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс болон хувиасаа халуун баяр хүргэж, Монгол цэргийн яруу алдар, хийморь лундаа үргэлж өөдөө байхыг хүсэн ерөөе.

Энхбаярын Батиугар гишүүн асуулт асууна.

**Э.Батиугар:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Сайханбаяр генерал ирсэн болохоор салбарын юм асууя гэж бодсон юм. Сая мэдээгээр Казахстан улсын хэрэглэж байсан 81 сөнөөгч онгоц “МиГ-27”, “МиГ-29” болон “Су-24”-ийг 19 мянган доллароос 20 мянган долларын тийм нэгж үнээр зарж байгаа гэсэн тийм мэдээ гарсан байсан. Үүнийг нисэх хүчний чадамжийг сайжруулах байдлаар манайхан бас худалдаж авч болох уу? Үүнийг судалсан уу гэж л асуух гэсэн юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гүрсэдийн Сайханбаяр Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал хариулна 3 номер.

**Г.Сайханбаяр:** Баярлалаа. Батиугар гишүүний асуултад хариулъя. Энэ тухай мэдээ байгаа. Гэхдээ ер нь одоо яг энэ асуудалтай холбоотой асуудлаар бас тодорхой төрөл, марк, нэр, зэвсэг хэлэх боломжгүй байна. Агаарын цэргийн командлагч болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ер нь манайд ашиглагдаж байгаа, одоо ашиглагдаж байгаа, тайван цагт ашиглагдаж байгаа онгоц, нисэх хэрэгслүүдийг засварлах, шинэчлэх ажлын хэсгийг томилоод ажиллаж байгаа. Тэр хүрээнд бид судлаад авах боломжтой.

**Г.Занданшатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Монголын энхийг сахиулагчдын Нэгдсэн Үндэстний Байгууллагын үйл ажиллагаанд оруулж байгаа хувь нэмрийг ялт ч үгүй өндрөөр үнэлэх ёстой. Би өөрөө Өмнөд Судан Улсын Жуба хотод энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа цэрэг дайчдынхаа бас үйл ажиллагааг сурвалжилж байсан хүний хувьд ер нь Монгол улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа цэрэг, дайчдын чадвар, чадамжийн асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгуулга маш өндөр үнэлгээг өгдөг юм байна лээ. Энэ дээр хууль орж ирж байгаатай тохиолдуулаад нэг зүйл асууж тодруулъя гэж бодож байна.

Ер нь Энхийг сахиулах үйл ажиллагааны хууль Монгол улсад ямар зохицуулалтыг хийх шаардлагатай болсон юм? Хүмүүсийн ярьж байгаагаар яг энэ албанд алба хаасан ч гэдэг юм уу, энэ чиглэлээр ажилладаг судалдаг эрдэмтэн, судлаачдын хэлж байгаагаар Монгол улс дэлхийд ганцхан, цор ганцхан Энхийг сахиулах үйл ажиллагааны тухай

хуультай гэдэг ийм мэдээлэл байдаг. Тэгээд энэ хуулийг дахин шинэчлэх ямар шаардлага үүссэн юм бол? Цэргийн албаны эрх зүйн байдлын тухай хуульдаа үүнийг зохицуулчхаж болоогүй юм болов уу гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм. Ямар шаардлага байгаа юм? Үнэхээр Монголын цэрэг дайчид, цэргийн алба хааж байгаа хууль хүчний байгууллагад байгаа, цагдаа, сэргийлэх, эмнэлгийн салбарт ажиллаж байгаа бүхий л хүмүүс бас үнэхээр энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоод Монгол улсынхаа нэр төрийг өндөрт өргөөд, албаа сайн хаагаад, амьдралдаа бас 5 цаас нэмэрлэхчье гэдэг ийм хүсэл сонирхол байдаг уу гэвэл байдаг. Гэхдээ шаардлага нь юу байсан юм бол энэ хуульд? Өөрчлөлт оруулах шаардлага нь юу байсан юм гэдгийг тодруулаадахъя. Тэгээд дараагийнхаа асуултыг асууя.

**Г.Занданшатар:** Гүрсэдийн Сайханбаяр Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал хариулна. 3 номер баярлалаа.

**Г.Сайханбаяр:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын батлан хамгаалах багц хуулийн шинэчлэл 2015 онд батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийг шинэчлэн баталснаар бас 2 дахь үеийн шинэчлэл эхэлсэн. Тэр хүрээнд Батлан хамгаалахын багц хуулийн шинэчлэлийг 16, 17, 18 онуудад хийсэн. Энхийг дэмжих ажиллагааны хууль бол үндсэндээ Монгол улсын эдгээр хуулиудад нийцүүлэх, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагатай Монгол улсын Засгийн газар хооронд байгуулдаг санамж бичиг байгаа. Энэ санамж бичиг дээр заагдсан заалтуудыг хуульд нийцүүлэх, мөн энхийг дэмжих ажиллагаанд шинээр цагдаагийн баг, цагдаагийн албан хаагчийг оролцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг хийх, үг, үсэг, найруулгын хувьд шинэчлэн батлагдсан багц хуулийнхаа зохицуулалтад нийцүүлэх арга хэмжээг авах, мөн өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Энхийг дэмжих

ажиллагааны хууль бол 2 удаа шинэчлэгдэж, 10-аад удаа бас нэмэлт, өөрчлөлт орж байсан. Эдгээр зүйлүүд дээр бусад хуулиудад нийцүүлэх арга хэмжээг авах гээд нэлээн том түвшинд шинэчилсэн найруулгын шинжтэйгээр орж ирж байгаа.

Түүн дотроо бас энэ төрийн цэргийн байгууллагууд хууль зүйн асуудал эрхэлсэн сайдын энэ энхийг сахиулах ажиллагаанд оролцохтой холбоотой, цэргийн баг, алба хаагч оролцохтой холбоотой эрх зүйн зохицуулалт эрх, үүргийг бас тодорхой болгож байгаагаараа бас энэ хуулийн шинэчилсэн найруулгыг хийх зайлигүй хэрэгцээ шаардлага байсан юм гэдгийг хэлж байна.

**Г.Занданшатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

**Б.Жаргалмаа:** Ер нь энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон цэрэг дайчид, алба хаагчдын хувьд болохоор дахиад энэ албанд дахиад явчих юм сан гэдэг юм уу, энэ албанд дахиж томилогдох боломж байгаа юу гэдэг ийм зүйлийг маш ихээр тодруулдаг л даа. Тэгээд л нарийн зүйл, заалтууд орж ирж байна гэж ойлгож байна.

Нөгөөтээгүүр цагдаагийн алба хаагчдыг энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох тэр боломжийг л энэ хуулиар нээж өгөх гэж байгаа юм байна гэж ойлголоо. Нөгөөтээгүүр яг газар дээрээ гэдэг юм уу, орон нутгийн тэр нөхцөл байдалсаа шалтгаалаад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх шаардлага энхийг сахиулагчдад маш ихээр байдаг юм байна лээ. Үүгээрээ эмнэлгийн ажилтнуудыг бас оролцуулах нь хуулийн зүйл, заалттайгаа байдаг гэж ойлголоо.

Яагаад гэвэл таны саяын хэлсэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуультайгаа нийцүүлэх боломжгүй учраас энэ тусгайлан бие даасан хууль

хэрэгтэй гэдэг энэ тайлбарыг сонслоо л доо. Тэгэхлээр ер нь яг энэ цэргийн алба хаагчдыг оруулж байгаатай адилхан эмнэлгийн алба хаагчид гэсэн бүх зүйл, заалтууд нь хуульдаа байдаг уу, үгүй юү гэдгээ тодруулж өгөөч. Нөгөө талаар энэ.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Гүрсэдийн Сайханбаяр дэслэгч генерал хариулъя.

**Г.Сайханбаяр:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцох эрх зүйн зохицуулалтын хувьд бол дэлхийн энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цэргийн багаа оролцуулж байгаа 150 гаруй орны улсуудад тодорхой хэмжээний эрх зүйн зохицуулалт, хуулиуд баталж хэрэгжүүлдэг юм байна лээ.

Дээрээс нь бас Монгол улсын Засгийн газраас, Батлан хамгаалах яамнаас Нэгдсэн Үндэстний Байгууллагатай, холбогдох газруудтай гэрээгээр бас хамтарч ажилладаг. Тэгээд энэ гэрээн дээр бол энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагад ямар төрлөөр энгийн албан хаагчид оролцуулах, ямар ажиллагаанд оролцуулах, бүс нутгаа сонгох, хугацаагаа тохирох, албан хаагчдын нөхөн төлбөртэй холбоотой асуудал гэх мэтчилний нарийн зүйлүүдээ гэрээгээр зохицуулдаг. Энэ хууль бол үндсэндээ эрх зүйн манай Монгол улс.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх дэмжсэн, дэмжээгүй гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна. Санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүдийг, тэр Өнөрболор, Сандаг-Очир хоёр гишүүн хаачив? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн, Содномын Чинзориг Эрүүл мэндийн сайд, энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг ер нь хэлэлцэхээ болино. Ерөөсөө энэ Чинзориг сайдыг өөрийнхөө хуулийг хэлэлцүүлчхээд л гараад явчихдаг болчихсон. Одонтуяа дэд даргыг дуудчих даа. Өрөөндөө уулзалт хийчхээд санал хураахаар ороод ирье гэсэн.

Санал хураалт явуулъя. Байнгын хорооны саналаар саяын уншаад танилцуулчихсан байгаа томъёоллыг. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн энэ 5 хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдээ олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ишлжүүллээ. Дараагийн асуудалд орно.

15.14 цаг.

**Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Сайханбаяр:** Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл нь Монгол улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 5.6-д цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно гэсэн зорилт Монгол улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхэд цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох зэрэг эрх зүйн заалтууд үндэслэл болж байна.

Тус хуулийн төсөлд дараах нэмэлт өөрчлөлтийг тусгаж орууллаа. Үүнд:

Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт 5 ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид мөнгөн урамшуулал олгох, дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчдад цалин хөлс олгох журмыг холбогдох Засгийн газрын гишүүн батлах, цэргийн алба хаагчийн үүрэгт ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд аливаа дарамт, шахалт, ялгаварлан гадуурхалтаас ангид байхтай холбогдсон эрх зүйн зохицуулалт, холбогдох хууль тогтоомжийн нийцлийг хангах хүрээнд хуулийн зарим хэсэг, заалтад өөрчлөлт оруулсан зэрэг юм.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар алслагдсан болон хөдөө орон нутагт байрлах цэргийн анги, салбарт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж, нийгмийн баталгаа дээшлэхийн зэрэгцээ Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийн хот хөдөөгийн сэргэлтийн хэрэгжилт, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6-д заасан Монгол улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлэх гэсэн зорилт хангагдахад чухал нөлөө үзүүлэх болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сэргэлэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хуулийн төсөлд зөвхөн алслагдсан цэргийн анги, салбарт ажиллаж байгаа цэргийн албан хаагчдын асуудал хөндөгдөж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан дотооддоо болон гадаадын улс орнуудад батлан хамгаалахын чиглэлээр.../үг тасрав./

...эсэх, дотоодын суралцагчдын суралцсан хугацааг ажилласан жилд нь оруулан тооцдогтой адил гадаадад суралцагчдыг хэрхэн тооцож байгааг тодруулан асуулт асууж, хариулт авсан бөгөөд цаашид алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарын жагсаалт, холбогдох журмыг шинэчлэн гаргах шаардлагатай гэсэн болно. Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн уг хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарын жагсаалтыг хуульдаа тодорхой заах, алслагдсан гэсэн ухагдахуунаа тулгуурлан хуулийн нэр

томъёог зөв тодорхойлох нь зүйтэй гэсэн санал хэлж өөр бусад хуульд дээрх нэр томъёог ашигладаг эсэхийг тодруулж асуулаа.

Хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх нь хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүд өмнөх хуультай овог, нэр, ажил албан тушаал адил. Протокол тэр чигээр нь тэмдэглэе.

Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна. Манай эмэгтэйчүүд л цэрэг сайн мэдээд байдаг болчхоод байгаа юм даа. Салдангийн Одонтуяа гишүүнээр тасаллаа. Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Тэгэхээр энэ их чухал хууль бас байна. Энэ нэмэлт, өөрчлөлт дээр хууль тогтоомжид заасан ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд аливаа даралт, шахалт, ялгаварлан гадуурхалтаас ангид байна гэсэн ийм заалт байна. Тэгэхээр би зүгээр энэ гишүүддээ бас энэ батлан

хамгаалахынхандаа нэг зүйл хандаж хэлмээр байна. Сүүлийн жилүүдэд энэ цэргийн бус дүрмийн харилцааны олон зөрчлүүд гарсан. Тэгээд хүний амь нас хохирох ч асуудал олноор гарсан байгаа.

Тэгэхээр тухайн үедээ бид нар сенсац болгоод, хэн нэгэн рүү буруугаа чихээд ингээд хохироод өнгөрөх биш дандаа шийдэл, гаргалгааг нь олж байх ёстой. Энэ дээр ямар бид нар шийдэл олсон бэ гэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийг өнгөрсөн 7 хоногт өргөн барьсан. Энэ хуулийн 33 дугаар заалтад ямар нэмэлт оруулж байгаа вэ гэхлээр энэ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны ажилтнууд, гишүүд энэ зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэргийн анги нэгтгэлд орж ажиллах ийм боломжгүй байсан юм. Эд нар зөвхөн хорих анги, асрамжийн газар гэдэг ч юм уу ийм ангиудад бол орж ажилладаг байсан. Тэгэхээр одоо бид нар энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүд нь дараах газарт орж ажиллах ийм хяналт шинжилгээ хийх боломж олгоно гэсэн байгаа. Энэ дээр зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэргийн анги гэж оруулсан юм байгаа юм.

Ингэснээрээ ямар ач холбогдолтой юм бэ гэхээр бид нар аливаа зүйлийг гэмт хэрэг гарснаас хойш биш дандаа урьдчилан сэргийлэх зүйл дээр их ажиллаж байх ёстой. Тэгэхээр манай энэ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх байгууллагын хүмүүс яадаг вэ гэхээр байгууллага дээр очдог, төрийн албан хаагчдыг хүний эрхийн сургалт хийдэг, эрүүдэн шүүнэ гэдэг чинь зүгээр зодож занчихаас гадна хүнтэй хүнлэг бус харьцахыг хэлнэ, нэр төрийг гутаан доромжлохыг хэлнэ гэдэг ч юм уу ингээд олон улсын тэр яг хүний эрхийн зөрчилд заасан бүх тэр хичээл, сургалт, зөвлөмжийг өгдөг байгаа. Нийт сүүлийн 2 жилийн хугацаанд бас сайн ажилласан

байна лээ. Нийт 7200 гаруй төрийн албан хаагчдад энэ сургалтыг хийсэн байгаа. Тэгэхээр энэ бидний санаачилсан энэ хуулийн төслөөр зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэргийн ангиудад энэ соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажиллагаа хийх боломжтой болох юм.

Тэгэхээр хаа хаанаа бүх хүмүүсийн ажилд эергээр нөлөөлнө гэсэн үг. Тийм учраас энэ хуулийг бид нар удахгүй дэмжиж оруулна. Тэгээд манай эрэгтэй гишүүд эмэгтэй гишүүд цэргийн талаар юугаа мэддэг юм дуугүй бай гээд байж бас болохгүй шүү Чинзориг гишүүн ээ, Чинзориг гишүүн ээ. Эмэгтэй гишүүн хүний амь нас эрсдэхээр л эмэгтэй гишүүд дуугарсангүй гэдэг. Тэгээд цэргийн асуудал дээр ч гэсэн бид нар бол бас энэ урьдчилан сэргийлэх дээр арга хэмжээ авах хуулийн төслүүдийг санаачилж оруулсан байгаа. Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Үг хэлчхэж байна уу? Үг хэлсэн. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна. Санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа суучих. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 2.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, 3.Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад өглөө байсан юм. Чинбүрэн гишүүнийг дууд. Санал хураалт явуулъя.

Хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Гочоогийн Ганболд гишүүн хаачив? Идэрбат гишүүн. Санал хураалт явуулна. Санал хураалт.

67.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудал Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо хэлэлцээгүй учраас хойшлууллаа.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо хойшлууллаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг хууль санаачлагч байхгүй учраас хойшлууллаа. Пүрэвдорж гишүүн. Үүнийг маргааш хэлэлцье.

15.28 цаг.

**Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлтэст бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан

асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу?

Алга байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орёё.

**Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны 4 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан

саналыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн чанартай шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу.

Алга байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуулт орно.

15.32 цаг.

**“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас төрийн аудитын байгууллагын албан



хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг өөрчлөн тогтоолгох саналаа 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн тул Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40.93 дугаар зүйлд тус тус заасны дагуу Төсвийн байнгын хорооноос “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрийн аудитын байгууллага албан тушаалын сарын цалингийн хэмжээг адил төстэй чиг үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ доод жишигтэй дүйцүүлэн “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй бөгөөд тогтоолын төслийг батлуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна.

Одоо Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа сууя санал. Сэргэлэн генерал хаачив? Санал хураалт Тогтохоо даргаа, Учрал гишүүнээ. Сэргэлэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ороод ирчихсэн. Тэгвэл санал хураалт явъя. Санал хураалт.

22 гишүүн дэмжиж, 56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дараагийн асуултад орно.

Тогтоолын төсөл батлагдлаа.

15.34 цаг.

**“Засгийн газарт чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 5 сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын нийт гишүүдийн тоо 126 болж нэмэгдсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдах Их Хурлын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл,

боломжоор хангах зайлиггүй шаардлагыг харгалзан тогтоолын төслийг боловсрууллаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг Тагнуулын ерөнхий газрын одоогийн байрлаж байгаа байранд ишлжүүлэн байршуулах, Тагнуулын ерөнхий газрыг Хөшигийн хөндий, Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын хүрээнд шинээр төлөвлөгдөж байгаа Засгийн газрын байгууллагуудын нэгдсэн байрны цогцолборт байршуулахаар зохион байгуулах, Засгийн газрын байгууллагуудын нэгдсэн байрны цогцолборын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг холбогдох дэд бүтэц Их тэнгэрийн болон Номтын амны ерөнхий төлөвлөлттэй нягт уялдуулан цогц төсөл байхаар төлөвлөж барилга угсралтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Тагнуулын ерөнхий газарт хариуцуулан хэрэгжүүлэх, цогц төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай Засгийн газрын баталгаа, төрөөс үзүүлэх бодлогын бусад дэмжлэг, туслалцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад тухай бүр нь тавьж ишийдвэрлэж байхыг Засгийн газарт даалгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар ишлжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулахтай холбогдох байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхад анхаарч ажиллах талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 54.5 хувь нь Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн учраас “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын

хорооны санал, дүгнэлтийг хэлэлцсэн Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу.

Алга байна.

Санал хураалт. Санал хураалтын дараа гишүүд суудалдаа суугаарай. Санал хураалт дээр нэг горимын санал байна. Төрийн байгуулалтын байнгын хороо өглөө 8:30-аас хуралдах. Хуралдаа одоо ингээд чуулганаар хэлэлцэх асуудал үндсэндээ дуусаж байна. Байнгын хороо ярьчихсан бол одоо горимын саналаар л нэмж болно. Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороог өнөөдөр бас хуралдуулж болж байна гэдгийг л хэлэх гэсэн юм. Энэ ихэнх гишүүд нь, Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороог маргааш 8:30-аас гээд баталчихсан. Энэ Жаргалмаа гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Оюунчимэг гишүүн Байнгын хорооны ирц үндсэндээ байх шиг л харагдаад байгаа шүү дээ. Сараа гишүүн байна, Ц.Мөнхцэцэг гишүүн байна. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. 6, 11. Санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулж байна.

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэх гэж байгаа юм уу? Би чинь тэн дээр ингэж заагаагүй, тэрийг яагаад та нар сайн мэдээд байдаг юм?

Тогтоолын төсөл батлагдлаа.

15.38 цаг.

**Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан ч гэсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хэлэлцэх асуудлын дараалалд нэмж оруулъя гэсэн горимын саналыг Содномын Чинзориг гишүүн гаргаж байна.**

Та микрофонд саналаа хэлчих үү, эсвэл Байнгын хорооны дарга хэлэх юм уу? Пүрэв-Очирын Анужин Байнгын хорооны дарга хэлчих. Пүрэв-Очирын Анужин гишүүн.

**П.Анужин:** Баярлалаа. Эмийн түр хороо ажиллаж бас өнгөрсөн 2 долоо хоногийн өмнө бас тайлангаа тавьж, өнөөдөр Улсын Их Хурал дээр тайлангаа тавьж бас тогтоолоо батлууллаа. Энэ үйл явдалтай бас холбогдуулж Засгийн газар Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг яаралтай горимоор өргөн барьсан. Ер нь Нийгмийн бодлогын байнгын хороогоор сүүлийн үед энэ эмнэлгийн салбарт тулгамдаж байсан олон суурь хуулиуд бас орж ирснийг энд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Засгийн газраас яаралтай горимоор өргөн барьсан энэ хуулийг сая Байнгын хороо бас яаралтай горимоор хуралдаж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн учраас улс Улсын Их Хурлын өнөөдрийн чуулганаар Эм, эмнэлгийн тухай хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэх эсэхийг бас хэлэлцэж өгөөч гэдэг горимын саналыг гаргаж байна. Баярлалаа.

**Г.Занданишатар:** Тамгын газраас холбогдох материалуудыг тараачихсан уу? Тийм. Гарсан горимын саналаар санал хураалт явуулна. Тэгвэл материал тараагдаагүй бол өгч болно. Өнөө маргаашдаа бүх асуудлуудаа шахаад хэлэлцэнэ гишүүд ээ, хэлэлцчихье. Тэгээд ирэх долоо хоногт хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд энэ Уламжлалт мал аж ахуйд уур амьсгалын өөрчлөлтөөс учруулж байгаа сөрөг нөлөөллийг

бууруулах тухай хуулийн хэрэгжилт, “Шинэ хоршоо-чинээлэг малчин” санаачилгын хэлэлцүүлэг. Хотоос сонгогдсон гишүүд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудыг бас өөр хороодоор хэлэлцүүлэх, хөдөө орон нутагт Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийг бас хэлэлцүүлэх ийм ажлуудаар ирэх 7 хоногт ер нь чуулганаар хөдөө орон нутагт, гишүүд хөдөө орон нутагтаа ажиллаж гэсэн санал хүсэлт маш их ирж байгаа. Үүнийг харгалзаж үзээд энэ 5 дахь өдөр бүх ажлууд дуусчих юм бол, энэ хуулиудаа хэлэлцчих юм бол, маргааш идэвхтэй ингээд хуулиудаа хэлэлцчих юм бол ирэх долоо хоногт энэ гишүүдийн санал, хүсэлтийг харгалзан үзэж чуулган завсарлуулж магадгүй гэдгийг мэдэгдье.

Ингээд Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Байнгын хорооны дарга Пүрэв-Очирын Анужин гишүүний гаргасан, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хэлэлцэх асуудлын жагсаалтад нэмж хэлэлцье гэсэн санал. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

Горимын санал дэмжигдсэн тул Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлын жагсаалтад нэмлээ.

Материал, санал, дүгнэлтийг хэн танилцуулах юм? Эхлээд хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулна л даа. Ингээд хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг танилцуулна. Индэрт урьж байна.

**С.Чинзориг:** Улсын Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол улсын Засгийн газраас Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, яаралтай горимоор хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг анх 1998 онд баталж, Эмийн тухай хуульд 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгосон бөгөөд 2010 онд тус хуулийг шинэчлэн найруулснаас хойш нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Өнөөдрийн байдлаар манай улсад нийт 3130 эм хангамжийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагийн 2595 нь эмийн сан, 495 эм ханган нийлүүлэх байгууллага, 40 эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, ариутгал халдваргүйжлийн бодис болон биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол улсын эмийн бүртгэлд 56 улсын 780 үйлдвэрлэгчийн 4097 нэрийн бүртгэлтэй байна. Нийт бүртгэлтэй эмийн 20.4 хувь нь үндэсний үйлдвэрийн эм эзэлж байна.

Олон улсын стандартын шаардлагыг хангасан эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаанд орчин үеийн технологи болон зохистой дадлыг бүрэн нэвтрүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өргөн ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, нийлүүлэлт, засвар үйлчилгээ, ханган нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд дараах зарчмын томоохон өөрчлөлтүүдийг оруулж байгаа болно.

1. Эмийн чанар, аюулгүй байдал, эмийн үнийг бууруулах зохицуулалтыг тодорхой тусгаж оруулж байна. Эмийн

чанарыг хянах зорилгоор био эквивалент буюу эмчилгээний идэвхийг төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд болон эмийн чанарын лабораторид хийх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Эмийн үйлдвэрүүд чанарын хяналтын итгэмжлэгдсэн лабораторитой байх талаар эмийн үйлдвэрүүдэд тавигдах шаардлага тодорхой тусгаж байна. Төрөөс зохицуулалт хийх аргуудыг нэлээн хуульд тусгаж байгаа болно.

Тухайлбал, бүх түвшинд эмийн үнийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллага болон гадаад орноос худалдан авах, үнийн хэлцэл хийх, үнийн дээд хязгаар нэмэгдэх, хувь хэмжээ тогтоох зэрэг арга хэмжээг тусгаж байна. Мөн эмийн үнийг цахимаар хянах салбар дундын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох асуудлыг ч тусгаж байна. Уламжлалт эм, түүний түүхий эдтэй холбогдуулан үндэсний үйлдвэрийн уламжлалт эмийг эх сурвалжид үндэслэн бүртгэдэг байхаар, түүхий эдийг уламжлалт эмийн хамт цахим мэдээллийн нэгдсэн санд бүртгэн хянахаар тусгаж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгааны хувьд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдийг хэт төөрөгдүүлсэн, үйлчилгээг нь хэт дөвийлгөсөн байдлаар эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн сурталчлахыг хориглох болно. Үүнтэй зэрэгцүүлэн эм, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ч гэсэн үйлдвэрлэл, үйлчлүүлэгчдийн эм, эмнэлгийн хэрэгслийг сурталчлах асуудлыг хязгаарлах асуудлын тусгаж байгаа болно.

Эм ханган нийлүүлэх байгууллагад тавигдах шаардлагыг илүү өргөжүүлж, олон улсын жишигийн дагуу дан ганц үйлдвэрлэлийн зохистой дадал бус, хадгалалт, түгээлтийн зохистой дадал

болон бусад шаардлагыг мөн дэлгэрэнгүй тусгасан.

Эмийн зохистой хэрэглээний чиглэлээр оролцогч талууд тухайлбал эмч, эмнэлгийн эрүүл мэндийн байгууллага, иргэний эрх, үүргийг тодорхой тусгаж байна. Эмч иргэнд эмийн тун хэмжээ, хэрэглэх арга, эмчилгээний нийт үргэлжлэх хугацаа, иргэнд гарч болзошгүй гаж нөлөө, харилцан үйлчлэлийн талаар заавал тайлбарлаж өгдөг байх, эмийн гаж нөлөөг тухай бүр мэдээлж байх, эрүүл мэндийн байгууллага эмийн хэрэглээ, чанарт байнга хяналт тавих, эмийн чанарт тогтмол тандалт судалгаа хийх, тусламж үйлчилгээнд хэрэглэж байгаа эмийн гаж нөлөөг байнга хянан мэдээлж байх зохицуулалтыг оруулж байна.

Эмийн сангийн жор баригч эм олгохдоо эмийг хэрэглэх арга, хадгалалт, эмийн зохистой хэрэглээний талаар үйлчлүүлэгчдэд байнга мэдээлэл өгдөг байх. Эмийг иргэнд дахин савлаж олгохдоо савлалт, шошго дээр эмийн нэр, тун, тун хэмжээ, хэрэглэх аргыг заавал бичсэн байх зохицуулалтыг нарийвчлан тусгаж байна.

Улсын хэмжээнд эмийн зохицуулалтын чиглэлээр ажиллаж байгаа зөвлөл, комиссын эрх, үүргийг илүү тодорхой болгон тэдгээрийн ажиллах журмыг сайдын тушаалаар баталдаг байсныг өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгасан.

Тухайлбал, эмийн зөвлөлийн гишүүдийг ил олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар сонгох, Эмийн зөвлөлийн гишүүн энэ сонгон шалгаруулах шалгуур, Эмийн зөвлөлийн гишүүнээр ажиллах хугацаа зэргийг тодорхой тусгаж байгаа болно.

Тухайлбал, тус эмийн зөвлөлийн гишүүнд мэргэжлээсээ 10-аас доошгүй жил ажилласан байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх, боловсролын хувьд

магистраас дээш зэрэгтэй байх гэх мэт шалгуурыг хангасан байх, далд санал хураалтаар шийдвэр гаргах зэрэг асуудлыг тусгаж байгаа болно.

Эмийн зохицуулалтад оролцогч талууд дахь төрийн байгууллагуудын эрх, үүргийн илүү оновчтой болгохын зэрэгцээ ТББ, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, эмийн төлөөлөгчдийн газрын үүрэг оролцоог мөн хуульчилж илүү тодорхой болгохоор хуулийн төсөлд тусгасан болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх талуудын чиг үүрэг тодорхой болж, чанар, аюулгүй байдлын зохицуулалт илүү боловсронгуй болж, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөргөдөл буурч иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбогдсон санхүүгийн эрсдэл буурна хэмээн үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

**М.Оюунчимэг:** Монгол улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч олон улсын стандартын шаардлагыг хангасан эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаанд орчин үеийн технологи болон зохистой дадлын бүрэн нэвтрүүлэх, тэдгээрийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өргөнөөр ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн тусламж, ашиглалт нийлүүлэлт, засвар үйлчилгээ, ханган нийлүүлэхтэй холбогдсон харилцааг цогцоор нь зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар эм, био бэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг хэрэгжүүлэгч талуудын чиг үүрэг тодорхой болж, чанар, аюулгүй байдлын зохицуулалт боловсронгуй болж, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөргөдөл буурч, иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбогдсон санхүүгийн эрсдэл буурч, эмнэлгийн хэрэгсэл, тухайлбал, тоног төхөөрөмжийн бүртгэл, нэршил, ангилал, чанар, аюулгүй байдал, шалгалт, баталгаажуулалт, шалгалт тохируулга, хөрөнгийн төлөвлөлт, мэдээллийн сан, засвар үйлчилгээний менежментийн тогтолцоог зохицуулах боломж бүрдэж, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад төрийн чиг үүрэг, хариуцлага нэмэгдэж, уламжлалт эмийн зохицуулалт боловсронгуй болж, эм, био бэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт олон улсын жишигт хүрэх ба хуулийн этгээдэд хүлээсэн тухайн чиг

үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд түүнд ойролцоогоор 2.9 сая төгрөгийн зардал бий болохоор, мөн хуулийн төсөл батлагдсаны дараа гарах эрх зүйн баримт бичгийг боловсруулах, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, судалгаа хийхэд нэмэлт зардал гарч болзошгүй гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг *d.parliament.mn* цахим хуудаст байршуулан иргэд олон нийтийн санал авч байгаа болно. Хуулийн төслийг хэлэлцэх үед Байнгын хорооны гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 77.8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйл, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны

санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн чинь өөрөө илтгэхээд өөрөө асуух юм уу, өөрөөсөө асуух юм уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн өөрөөсөө асууна. Оюунчимэг гишүүнээр тасалсан. Дараа нь санал хураалтай гишүүд.

**М.Оюунчимэг:** Энэ хууль өөрөө маш чухал хууль орж ирж байгаа. Өмнөх парламентын босго давж чадаагүй. Энэ парламентад энэ хуулийг зайлшгүй хэлэлцүүлж батлуулах ёстой гэсэн байр суурийг биднийх гишүүд аль бараг 3, 4 жил илэрхийлж байгаа. Тэгээд Эрүүл мэндийн яам нь буцаж татаж аваад илүү боловсронгуй болгоод оруулж ирлээ гэж ойлгож байгаа.

Хамгийн гол нь саяын Эмийн түр хороо сонсголын үеэр яригдсан энэ ноцтой болон зөрчилтэй, зохицуулалтгүй энэ эмийн тухайлбал зах зээлийг гажуудуулсан энэ бүх зүйлийг засах нь өөрөө энэ хуулиар зохицуулагдана. Үүнийг та бүхэн маань ард түмнийхээ эрүүл мэндийг бодож бас эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа олон мянган ажиллагсад, ажилчид, эмч нар бид нар руу сонсголын дараа бичиж байна, уулзаж байна. Ингэх нэг хэрэгтэй байсан юм, энийг задлахгүй бол болохгүй байгаа юм гээд. Ялангуяа Чинзориг сайдаа энэ таны үед биш шүү би сүүлийн бараг 10, 20 жилийн ингээд л хараад байхад Эрүүл мэндийн яам маань өөрөө ашиг сонирхлын, компанийн ашиг сонирхлын төвлөрөл нь болчихсон, тэгээд 200, 300 компани нэрээр лиценз авсан 2, 3-хан монопол компани яам ингээд нийлээд энэ

тухайлбал эмийн зах зээл дээр аалзны тор, мафи үүсгэчихсэн.

Тэгээд энэ нь өөрөө иргэдийн эрүүл мэндэд бараг ноцтой хор, нөлөө үзүүлэхүйц чанартай юм байна уу, үгүй юү? Үнэ нь дэлхийн зах зээлтэй бодит байдалтай нийцэж байна уу, үгүй юү? Бүгд энэ тодорхойгүй ингээд хаалттай. Хүний эмийн зөвлөл нь, эмийн зөвлөл нь тодорхойгүй, хурал нь хаалттай, тухайн өдөр хэн, ямар хуралд оролцсон нэрсээ ч гаргадаггүй гээд нэлээд ноцтой зөрчлүүд байгаад байгаа. Тэгээд үүнийг энэ хуульд орсон заалтуудаар бид задалж чадна. Иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө, ялангуяа эмийн зах зээлийг одоо яг төрийн бодлогоор зохицуулаад тэр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд яг дэлхийн жишгээрээ явах боломж бүрдэнэ гэдэг баталгааг та өгч чадах уу? Би Эрүүл мэндийн сайдаас үүнийг асууя гэж бодож байна. Тэгээд бид нар Түр хорооноос ийм тогтоол гаргасан байгаа. Энэ тогтоол дээр жишээлбэл, Эм, эмнэлгийн хуулиар ийм ийм зохицуулалтуудыг хатуу оруулж өгөх ёстой гээд тодорхой чиглэл бас танд өгсөн байгаа. Энэ бүх заалтууд энд тодорхой хэмжээгээр орсон нь тодорхой.

Гэхдээ яг энэ заалтаар ингээд зохицуулагдаад түрүүн Их Хурлын дарга ч хэлж байна тэр энэ эм иргэдийн чанартай, яг бодит, хөрс дээрээ буусан эм Монголын аптекуудад борлуулагдаад яваад Монгол хүний эмийн хэрэглээ буурах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь илүү үр дүнтэй байх энэ нөхцөлийг бүрдүүлсэн эсэх дээр та яг тодорхой хариулт өгөөч гэж хүсэх байна.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг сайдад хариулна.

**С.Чинзориг:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг би яамны

сайдаар томилогдож очсоноос хойш жил гаруйн хугацаанд нэлээн ажиллаад оруулж ирж байгаа юм. Тэгээд бас сая энэ явсан явцад Түр хороо бас байгуулагдаж, Түр хорооноос бас тодорхой Засгийн газарт чиглэл өгсөн Их Хурлын тогтоол бид баталсан. Энэ Түр хорооноос өгч байгаа чиглэлүүд бол үндсэндээ энэ шинэ хуулийн төсөлд орж ирж байгаа асуудлууд бас байгаа.

Магадгүй сая үдээс өмнө бид Түр хорооны ч Засгийн газарт өгөх чиглэлтэй холбогдуулсан тогтоол баталсан учраас зарим нэг асуудал нь хуулийн төсөлд орж амжаагүй асуудал байхыг үгүйсгэхгүй. Тэрийг нь хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх явцдаа аваад ингээд сайжруулаад явчих ийм боломжтой гэж бодож байна.

Би ерөнхийд нь гишүүддээ нэг зүйл хэлээд бид бол 30 жил энэ эмийн асуудлын хувийн хэвилийн нуруун дээрээ даатгаад явж ирсэн байна. Эм гэдэг бол өөрөө үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой стратегийн бүтээгдэхүүн. Стратегийн бүтээгдэхүүн учраас төрийн оролцоо, зохицуулалт, хяналт байх хэрэгтэй.

Нөгөө талаасаа төрийн дэмжлэг ч гэсэн байх ёстой. Бид стратегийн бүтээгдэхүүнгүүд улаан буудайн дээр, түлш шатахуун дээр асар их хэмжээний төрийн дэмжлэг үзүүлдэг шүү дээ. Татвараас чөлөөлдөг, санхүүгийн бас хөнгөлөлттэй дэмжлэг үзүүлдэг. Гэтэл энэ эм ханган нийлүүлэлтийн байгууллагууд дээр төрөөс үзүүлдэг ийм бас дэмжлэггүй бас явж ирсэн бас нэг өрөөсгөл дутагдалтай тал байна гэж би бол тэгж үзэж байгаа.

Гэхдээ бас эмийн дээр бас монопол байна гэдгийг бас үгүйсгэхгүй. Одоо бол 400 гаруй эм ханган нийлүүлэлтийн байгууллагууд байна. Нийт импортоор орж ирж байгаа эмийн чинь 85 хувийг 10-хан компани л нийлүүлж байна шүү дээ. Тэгэхээр бол

үндсэндээ энэ бол бас тодорхой хэмжээний монопол байна гэдэг асуудал. Энийг бас энэ хуулиар нэлээн өөрчлөлтүүд хийхийг зорьж байна.

Хоёрдугаарт, хоёр дахь асуудал нь эм ханган нийлүүлэх байгууллагууд хоорондоо жуулчлан дамжуулан борлуулалт бас хийдэг ийм бас шат дамжлага бий болгосон байна. Энэ бол үндсэндээ импортоор эм, эмнэлгийн хэрэгсэл оруулж ирэхгүй, оруулж ирсэн, импорт оруулж ирсэн байгууллагуудаасаа хоорондоо дамжуулан зуучлан бас борлуулалт хийдэг нэг шат дамжлага нэмүүлж, шулуухан хэлэхэд бол үнэ бас нэмэгдүүлж нэг бас шат дамжлага болчихоод байгаа юм. Энийг бол энэ хуулиар бас зохицуулж өгч байгаа юм.

Гурав дахь асуудал нь энэ ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдөө өөр нэрээр охин компани хэлбэрээр жижиглэн худалдаа хийдэг асуудлууд маш их түгээмэл болсон байна. Энэ хуулиар бид нар энэ эм ханган нийлүүлэх зөвшөөрөлтэй байгаа аж ахуйн нэгж байгууллагууд жижиглэн худалдаа хийх асуудлыг нэлээн бас хязгаарлаж өгье гэсэн энэ мэтчилэн энэ монополтой холбоотой асуудлыг нэлээн бас өөрчилж гэсэн ийм асуудал байна.

Эмийн зөвлөлтэй холбоотой асуудал дээр ч гэсэн бас Түр хороон дээр маш их шүүмжлэл гарсан.

**Г.Занданшатар:** Байхгүй байхгүй. Протоколд тэмдэглүүлэх зорилгоор ажлын хэсгийн гишүүдийг бас танилцуулчихъя.

Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Намдагийн Гэрэлт-Од Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Ганхуягийн Түвшинбаяр Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын



Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Шаравнямбуугийн Энхтуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ламжавын Зэндмаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга, Даваасүрэнгийн Оюун-Эрдэнэ. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын албад даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тогтохын Мөнхтуул Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга, Рэнцэнгийн Энхсүрэн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна. Одоо санал хураалт явуулна.

Энэ тэгээд энэ дандаа холбогдох дарга нар нь байна. Саяын сонголоор яригдсан хамгийн ноцтой асуудал эмийн бүртгэл дээр, эмийн тусгай зөвшөөрөл, лиценз, зохицуулалтууд дээр маш ноцтой асуудал яригдаж, холбоодох Авлигатай тэмцэх газраас шалгаж байгаа. Та нар хүн ардын эрүүл мэндийн манаанд зогсож байгаа улсууд энэ асуудал дээр өшөө өндөр сонор сэрэмжтэй, хариуцлагатай ажиглах ёстой. шүү. Одоо бүх юм ил тод болчихсон шүү. Бүх хулгай нэг өдөр ил тод болно. Бүх даргын даалгавар нэг өдөр ил тод болно. Ийм учраас энэ эмийн асуудал бол хүний аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал төдийгүй улсын үндэсний аюулгүй байдлын асуудал. Ийм учраас энэ дандаа холбогдох газрууд байна. Энийгээ бас эрс өөрчлөлт гаргах хэрэгтэй шүү.

Эмийн зохиомол өсөлт, үнийн зохиомол өсөлт байна гээд Түр хороо дүгнэхээ биз дээ тийм? Тэр зохиомол үнийн өсөлт дотор нь бол 3, 4 дахин хүртэл өсгөсөн байна гэсэн яриа байгаа биз? Одоо тэр итгэлцлийн зохистой дадлыг Улсын Их Хурлаас баталсан Түр хорооны тогтоолд тусгасан.

Итгэлцлийн зохистой дадал бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас санал болгодог олон улсад санал болгодог энэ зарчим. Тэгээд энэ итгэлцсэн олон улсын стандартлагдсан ийм юмыг манайхан чинь ахиад л бүртгэлжүүлэх гээд л бөөн авлигал, хүнд суртал байдаг юмыг л таслан зохиох хэрэгтэй гэж байгаа шүү дээ.

Санал хураалт явуулна гишүүд суудалдаа сууя. Анужин гишүүн суудалдаа суу.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

*20 гишүүн дэмжиж 51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.*

*Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.*

*Маргааш өглөө 8.30-аас Төрийн байгуулалтын байнгын хороо. 8.30-аас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонууд хуралдана. Нийгмийн бодлогын байнгын хороо 9 цагаас. Нийгмийн бодлогын байнгын хороо 9 цагаас хуралдана. Энэ хурлууддаа цагтаа ирцгээнэ шүү.*

*Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд ишлэжүүллээ.*

*Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.*

*16.03 цаг*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*